



Нийгмийн Ажлын Багш
Сургагчдын Холбоо




Олон Улсын Хөдөлмөрийн
Байгууллага



Нийгмийн Ажлын
Хөгжлийн Төв

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙГ УСТГАХ ЧИГЛЭЛЭЭР НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ГАРЫН АВЛАГА





Нийгмийн Ажлын Багш
Сургагчдын Холбоо



Олон Улсын Хөдөлмөрийн
Байгууллага



Нийгмийн Ажлын
Хөгжлийн Төв

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙГ УСТГАХ ЧИГЛЭЛЭЭР НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ГАРЫН АВЛАГА

БОЛОВСРУУЛСАН:

Ц. ЭРДЭНЭЧИМЭГ
Т. АМАРЖАРГАЛ
Н. ОЮУТ-ЭРДЭНЭ

УЛААНБААТАР ХОТ
2008 ОН

DDC

“Хүүхдийн хөдөлмөрийг устгах чиглэлээр нөлөөллийн ажлын гарын авлага”

Боловсруулсан:

Ц.Эрдэнэчимэг

Т.Амаржаргал

Н.Оюунэрдэнэ

Зөвлөх:

С.Нарантуяа

Энэхүү гарын авлагыг АНУ-ын Хөдөлмөрийн Департаментийн санхүүгийн дэмжлэгээр хэвлүүлэв.

ISBN

Өмнөх үг

Энэхүү “Хүүхдийн хөдөлмөрийг устгах чиглэлээр нөлөөллийн ажлын гарын авлага” номыг ОУХБ-ын АЙПЕК хөтөлбөрийн дэмжлэгээр хүүхдийн хөдөлмөр, түүний тэвчишгүй хэлбэрүүдийг устгах нөлөөллийн ажил хийх үндэсний чадавхийг бэхжүүлэх зорилгод чиглэсэн хөтөлбөрийн хүрээнд боловсруулан гаргалаа. Тус гарын авлага нь 2007 онд батлагдсан Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад чиглэсэн нөлөөллийн стратегийг хэрэгжүүлэх, хүүхдийн хөдөлмөрийг устгахад орон нутгийн бүлгүүдийг дайчлах, оролцоог нь хангах үйл хэрэгт ОУХБ/АЙПЕК-ийн түншлэгч байгууллагууд орон нутгийн түвшинд ажиллаж буй холбогдох төрийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллагуудын ажилтнуудад нөлөөллийн ажил явуулахад арга зүйн зөвлөмж болно.

Нөлөөллийн ажлын арга зүйн гарын авлагыг боловсруулахдаа ОУХБ/ АЙПЕК-ийн түншлэгч байгууллагуудын хүүхдийн хөдөлмөрийг устгахад чиглэсэн нөлөөллийн ажлын туршлагыг судлан нөлөөллийн ажлын хэрэгцээ шаардлагыг тодруулах ярилцлагыг нэг бус удаа хийсэн. Мөн гарын авлагыг боловсруулах явцад ОУХБ/ АЙПЕК -ийн түншлэгч байгууллагууд, бусад холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийн дунд хэлэлцүүлэх уулзалтыг хоёр удаа зохион байгуулсан юм. Тус гарын авлагыг боловсруулахад зөвлөмж өгч, зөвлөхөөр ажилласан Хүүхдийн Төлөө Үндэсний Газрын дэд дарга С.Нарантуяа болон нөлөөллийн ажлыг бодит байдалд нийцүүлэн төлөвлөх, хэрэгжүүлэх талаар санал бодол, туршлагаа хуваалцсан бүх байгууллага хүмүүст талархлаа илэрхийлье.

Зохиогчид

ГАРЧИГ

Өмнөх үг	3
Гарчиг.....	4
Нөлөөллийн ажилд шаардлагатай аргачлал.....	6
1-Р БҮЛЭГ. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙГ УСТГАХ НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ХЭРЭГЦЭЭ	7
1.1 Хүүхдийн хөдөлмөр гэж юу вэ?	8
1.2 Хүүхэд хэдэн наснаасаа ажил эрхэлж болох вэ?.....	11
1.3 Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд.....	12
1.4 АЙПЕК: Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр	14
1.5 Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад чиглэсэн нөлөөллийн стратеги /2007-2011/.....	15
2-Р БҮЛЭГ. НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ	17
2.1 Нөлөөллийн тухай ойлголт	18
2.2 Нөлөөллийн ажилд шаардагдах ур чадварууд.....	20
2.3 Нөлөөллийн үйл ажиллагаа явуулах хэлбэрүүд	22
2.4 Нөлөөллийн ажлын ёс зүйн асуудлууд	24
2.5 Нөлөөллийн түвшин	25
3-Р БҮЛЭГ. НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨХ НЬ	26
3.1 Төлөвлөлтийн үе шатууд	27
3.2 Асуудалд дүн шинжилгээ хийх аргачлал	28
3.2.1 Асуудлыг нарийвчлан тодорхойлох нь.....	28
3.2.2 Асуудал хичнээн хүнийг хамарч байна вэ?.....	29
3.2.3 Асуудлын шалтгаан, үр дагавар нь юу вэ?.....	31
3.2.4 Асуудлыг шийдэхэд саад болж буй ямар хүчин зүйлс байна вэ?	34
3.2.5 Асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах эрх мэдэл, боломж хэнд байна вэ?	35
3.2.6 Энэхүү асуудлыг шийдвэрлэхэд амжилт олох боломж хэр зэрэг байна вэ?.....	36
3.2.7 Нөлөөлөх чадвараа үнэлэх аргачлал.....	36
3.3 Зорилго, зорилтоо тодорхойлох	38
3.3.1. Зорилго гэж вэ?.....	38
3.3.2. Зорилт гэж юу вэ?.....	39
3.4 Сонирхогч талуудыг тодорхойлох нь	40
3.4.1 Сонирхогч талуудыг ангилах нь.....	41
3.5 Зорилтот бүлгийг тодорхойлох нь	42
3.5.1 Хэний төлөө өөрчлөлт хийх вэ?.....	42
3.5.2. Зорилтот бүлгийн мэдлэг, дадал, хандлагыг хэрхэн тодорхойлох вэ?.....	43
3.6 Нөлөөллийн стратеги ба тактикийг сонгох нь	45
3.6.1 Стратеги ба тактик гэж юу вэ?	45
3.6.2. Хамтрах стратеги	45
3.6.3 Олон нийтийг дайчлан зохион байгуулах стратеги	46
3.6.4. Өрсөлдөх стратеги.....	46
3.6.5 Сонирхогч талуудтай ажиллах стратеги, тактикийг сонгох аргачлал.....	49
3.7. Нөлөөллийн ажлын төлөвлөгөө боловсруулах нь	50
3.7.1 Бид ямар ажлын төлөвлөгөөтэй байх вэ?.....	50
3.7.2 Үйл ажиллагаа эхлэхэд шаардлагатай зүйлс бидэнд байна уу?.....	50
3.7.3 Нөлөөллийн ажлын төлөвлөгөө боловсруулах аргачлал	51
3.7.4 Хөрөнгө өсгөх аргууд	52
4-Р БҮЛЭГ. ЗОРИЛТОТ БҮЛЭГТ НӨЛӨӨЛӨХ СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛ БОЛОВСРУУЛАХ НЬ	53
4.1 Зорилтот бүлэгт тохирсон илгээмж боловсруулах аргачлал	54

4.1.1 Илгээмж гэж юу вэ?	54
4.1.2 Илгээмж боловсруулах үндсэн зарчмууд	55
4.1.3 Илгээмж боловсруулах аргачлал	56
4.1.4 Хүүхдийн хөдөлмөрийг устгах чиглэлээр мэдээллүүд	60
4.2 Мэдээллийн хэрэгслээ сонгох нь	63
4.2.1 Мэдээллийн хэрэгслийн төрөл хэлбэр	64
4.2.2 Мэдээллийн сувгийг сонгоход юуг анхаарах вэ?	64
4.2.3 Зорилтот бүлэгт нөлөөлөх төлөвлөгөөг боловсруулах нь	65
4.3 Мэдээллийг хүмүүст ойлгомжтойгоор илэрхийлэх зарим аргууд	66
5-Р БҮЛЭГ. НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АРГА ТЕХНИКҮҮД	68
5.1 Хамтран ажиллах арга техникүүд	69
5.1.1 Хамтын ажиллагаа гэж юу вэ?	69
5.1.2 Хамтран ажиллагчаа сонгох нь	71
5.1.3 Хамтрагч байгууллагаа сонгох нь	72
5.2 Хүүхдээс хүүхдэд арга	73
5.3 Лоббидох аргыг ашиглах нь	74
5.4 Сургалт семинар зохион байгуулах	78
5.5 Эцэг эхчүүдэд нөлөөлөх нь	79
5.6 Хэвлэмэл материал ашиглах арга	81
5.6.1 Зураг үзүүлэн бэлтгэх аргачлал	81
5.6.2 Хүүхдийн фото зураг ашиглахад ёс зүйн ямар шаардлага тавигдах вэ?	83
5.7 Олон нийтийн дайчлах нь	84
5.7.1 Олон нийтийг дайчлах аргууд	84
5.7.2 Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх компанит ажил зохион байгуулах	86
5.7.3 Бойкот буюу хориг тавих	87
5.7.4 Ёс зүйн хөрөнгө оруулалт	90
6-Р БҮЛЭГ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАХ НЬ	91
6.1. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн онцлог юу вэ?	92
6.2. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх аргууд	93
6.2.1 Хэвлэлийн мэдээг хэрхэн бичих вэ?	93
6.2.2 Хэвлэлийн бага хурлыг зохион байгуулах нь	94
6.2.3 Радио телевизийн нэвтрүүлэгт ярилцлага өгөх нь	94
6.2.4 Телевизээр илгээмжээ цацах нь	95
6.2.5 Редакцид захидал бичих	95
6.2.6 Өгүүлэл боловсруулах	96
6.2.7 Тэргүүн өгүүллийн сэдвээр ярилцлага зохион байгуулах нь	96
6.3. Хэвлэл мэдээллийн хэрэгслийг сонгох нь	97
6.4 Хэвлэл мэдээллийнхэнтэй хамтран ажиллах	98
6.4.1 Шинэлэг, сонирхол мэдээг бий болгох нь	100
6.4.2 Сэтгүүлчидтэй хэрхэн хамтран ажиллах вэ?	100
6.4.3 Өөрийн хүчин чармайлтаа үнэлж цэгнэх нь	101
7-Р БҮЛЭГ. НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ	103
7.1 Хүүхдийн оролцоо гэж юуг хэлэх вэ?	104
7.2 Нөлөөллийн үйл ажиллагаан дахь хүүхдийн оролцоо	107
8-Р БҮЛЭГ. НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ НЬ	109
8.1 Үнэлгээ: Бидний төлөвлөгөө хэрэгжиж буйг хэрхэн мэдэх вэ?	110
8.2. Богино хугацаанд ямар өөрчлөлт гарсан бэ?	111
8.3 Урт удаан хугацаанд юу өөрчлөгдсөн бэ?	112
8.4 Үнэлгээний шалгуур үзүүлэлт	113
Нэр томьёо, товчилсон үгийн тайлбар	115
Ашигласан ном, материалууд	117



Нөлөөллийн ажилд шаардлагатай аргачлал

Аргачлал	3.1	Асуудлын модыг ашиглан асуудалд дүн шинжилгээ хийх аргачлал.....	31
Аргачлал	3.2	Асуудалд нөлөөлж буй хүчин зүйлсийн дүн шинжилгээ хийх аргачлал ..	34
Аргачлал	3.3	Маш чухал шийдвэр гаргагчдыг тодорхойлох нь.....	35
Аргачлал	3.4	Нөлөөллийн чадавхид хийх өөрийн үнэлгээний аргачлал	36
Аргачлал	3.5	Сонирхогч талыг ангилах ба эрэмбэлэх аргачлал	41
Аргачлал	3.6	Зорилтот бүлэгт үнэлгээ хийх аргачлал.....	43
Аргачлал	3.7	Түншлэгчидтэй ажиллах тактикийг тодорхойлох нь.....	49
Аргачлал	3.8	Эсэргүүцэгчидтэй ажиллах тактикийг тодорхойлох нь	49
Аргачлал	3.9	Нөлөөллийн ажлын төлөвлөгөө боловсруулах аргачлал	51
Аргачлал	3.10	Нөлөөллийн ажлын төлөвлөгөөний загвар.....	51
Аргачлал	4.1	Нөлөөллийн илгээмж боловсруулах аргачлал	57
Аргачлал	4.2	Зорилтот бүлэгт чиглэсэн нөлөөллийн илгээмж боловсруулах нь	59
Аргачлал	4.3	Мэдээллийн суваг, хэлбэрийг сонгох нь.....	64
Аргачлал	4.4	Зорилтот бүлэгт нөлөөлөх төлөвлөгөөний загвар	65
Аргачлал	5.1	Дэмжигчдийн мэдлэг, хандлагын зураглал	71
Аргачлал	5.2	Хамтрагч байгууллагаа сонгох тактик	72
Аргачлал	5.3	Үр дүнтэй лоббидох уулзалт зохион байгуулах аргачлал.....	75
Аргачлал	5.4	Зураг үзүүлэн бэлтгэх аргачлал.....	81
Аргачлал	6.1	Хэвлэлийн мэдээг хэрхэн бичих вэ?	93
Аргачлал	6.2	Хэвлэлийн бага хурлыг зохион байгуулах аргачлал.....	94

I БҮЛЭГ

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙГ УСТГАХ НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ХЭРЭГЦЭЭ

БҮЛГИЙН ТОВЧ АГУУЛГА:

- 1.1 Хүүхдийн хөдөлмөр гэж юу вэ?
- 1.2 Хүүхэд хэдэн наснаас ажил эрхэлж болох вэ?
- 1.3 Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд
- 1.4 АИПЕК - Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр
- 1.5 Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад чиглэсэн нөлөөллийн стратеги

1.1 Хүүхдийн хөдөлмөр гэж юу вэ?

Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар нөлөөллийн ажил явуулахын тулд юуны түрүүнд хүүхдийн хөдөлмөрийн асуудлын талаарх мэдлэг зайлшгүй шаардлагатай.

Хүүхдийн хөдөлмөр гэж юу вэ?

“Хүүхдийн хөдөлмөр” гэдэг нь хүүхдийн насанд тохироогүй, хүүхдийн бие бялдарын болон оюун санааны хөгжил, ёс суртахуунд нь сөргөөр нөлөөлөхүйц ажлыг хэлнэ гэж тодорхойлдог. Үүнд:

Хүүхдийн оюун санаа, бие бялдар, нийгэм, ёс суртахууны хөгжилд аюултай хор хөнөөл учруулах ажил, хүүхдийн хичээл сурлаганд саад учруулах ажил үүнд:

- Сургуульд явах боломжийг нь хаах,
- Сургуулиа орхихоос өөр аргагүй байдалд оруулах,
- Сургуульд явахын зэрэгцээгээр хүнд хүчир ажлыг удаан хугацаагаар хийх шаардлагатай болох зэрэг орно.

Хүүхдийн хийж буй “ажил” нь “хүүхдийн хөдөлмөр” мөн үү, биш үү гэдэг нь хүүхдийн нас, эрхэлж буй ажлын төрөл хэлбэр, ажлын цаг, ажлын нөхцөлөөс шалтгаалдаг.

Эх үүсвэр: Парламент-хоорондын Эвсэл ОУХБ, 2002-с эмхэтгэн авав.

Хүнийг хөдөлмөрөөр хүмүүжүүлдэг учраас хүүхэд хөдөлмөрлөх нь буруу биш гэж зарим хүмүүс үздэг байна. Хүүхдээр нас биенд нь тохирсон ажил хийлгэж сурган хүмүүжүүлэх аргыг аливаа нийгэмд өргөн хэрэглэдэг бөгөөд энэ нь хүүхдийн хөгжилд эерэг нөлөө үзүүлдэг гэдэгтэй маргах аргагүй юм. Гагцхүү хүүхдийн хийж буй ажил нь дээрх тодорхойлолтод дурдсанаар тэдний бие бялдар, оюун санааны хөгжил, ёс суртахуунд нь сөргөөр нөлөөлж, сурах боломжийг нь хязгаарлан сургууль завсардах эрсдэлд оруулж байгаа зэрэг хор холбогдолтой бол хүүхдийн хөдөлмөр хэмээн үзэж түүнтэй тэмцэх, улмаар бүрмөсөн устгах шаардлагатай юм. Өнөөдөр дэлхий дээр ажил эрхэлж буй хүүхдийн тоо бид бүхний төсөөлөн бодож байгаагаас ч олон гэж хэлж болно. Статистикийн тоо баримтаас харахад 5-14 насны 211 сая хүүхэд, 15-17 насны 141 сая хүүхэд “эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа” буюу ямар нэг төрлийн ажил эрхэлдэг гэсэн баримт байдаг (ОУХБ, 2000).

Хүснэгт 1.1. Дэлхийн бүс нутгуудад эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж буй 5-14 насны хүүхдийн тоо (2000 оны байдлаар)

Бүс нутаг	Эдийн засгийн идэвхтэй хүүхдийн тоо(саяар)	Нийт хүүхдэд харьцуулсан харьцаа(% хувиар)
Хөгжингүй орнууд	2,5	2
Шилжилтийн эдийн засагтай орнууд	2,4	4
Ази, Номхон далайн бүс нутаг	127,3	19
Латин Америк ба Карибийн бүс нутагт	17,4	16
Сахар орчмын Африк	48,0	29
Ойрхи Дорнод ба хойд Америк	13,4	15
Нийт	211	18

Хүүхдийн хөдөлмөр гэж юу вэ?


Ажил нь дарамттай
нас биеийн хөгжлөөс
хэтэрсэн байвал



Сургуульд явах
боломжийг нь
хязгаарлавал



Албадан
ажиллуулбал



Сэтгэл санаа,
доромжлол,
хүчирхийлэлд
өртөж байвал



Мөлжлөгийн
шинжтэй бол



Олон цаг
ажиллуулбал



Эх үүсвэр: Нийслэлийн Хүүхэд Залуучуудын Газраас гаргасан тараах материалаас. 2007 он.

Монгол улс дахь хүүхдийн хөдөлмөрийн байдлыг тодорхойлох анхны үндэсний хэмжээний судалгаа 2002-2003 онд хийгджээ. Монгол улсын хүн амд 18 хүртэлх насны хүн ам 37 хувийг эзэлдэг бөгөөд үүнээс 5-14 насны 522,1 мянган хүүхэд байна (Монгол улсын 2006 оны статистикийн эмхтгэл, УСГ, 2007).

2003 онд УСГ-аас хийгдсэн “Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгаа”-ны дүнгээр Монгол улсын хэмжээнд 5–17 насны 68580 хүүхэд ажил эрхэлж байгаа бөгөөд хүүхдийн дундах ажил эрхлэлтийн байдал 10,1% байна. Нас болон долоо хоногт ажилласан цагт үндэслэн тооцоход эдгээр ажил эрхэлж буй хүүхдийн **56,7 хувь нь хөдөлмөр эрхэлж байна**. Эдийн засгийн үйл ажиллагаа хөвгүүдийн хувьд охидоос өндөр байна. Ажил эрхэлж буй эрэгтэй хүүхдүүд нийт 5-17 насны хүүхдийн 12,0%, эмэгтэй хүүхдүүд энэ насны нийт хүүхдийн 8,1% -ийг тус тус эзэлж байна. Хөдөлмөр эрхэлж буй 5-14 насны 28026 хүүхэд, 15-17 насны 10831 хүүхэд байгаа нь тухайн насны ажил эрхэлж буй хүүхдийн 76 хувь /5-14 нас/ ба 34 хувь /15-17 нас/ байна.

Ажил эрхэлж буй хүүхдүүдийг ажил мэргэжлийн ангиллаар нь авч үзэхэд: ХАА-н салбарт (90,8%), үйлчилгээний ажил, дэлгүүр зах дээр худалдаа эрхэлдэг (4,1%), энгийн ажил (2,7%), үйлдвэр худалдааны ажил (1,6%), бусад ангилал (0,8%) тус тус ажил эрхэлж байна. Цалин хөлстэй ажил эрхэлж байгаа хүүхдийн ихэнх нь уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, барилгын салбарт ажиллаж байгаа дүн гарчээ. Хот суурин газартай харьцуулахад хөдөө орон нутагт хүүхдүүд өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй оролцох нь их байна. Ажил эрхэлж байгаа 10-14 насны хүүхдийн 10,5 хувь нь сургуульд огт суралцаагүй, 15-17 настай

хүүхдүүдийн бараг тэн хагас нь бага боловсролтой байна. Үүнээс харахад ажил хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд боловсролын үйлчилгээнд хамрагдах байдал хангалтгүй байна.

ҮСГ-аас 2006-2007 онд хийсэн “Хүүхдийн хөдөлмөрийн байдал” судалгааны урьдчилсан дүнгээс¹ үзэхэд эдийн засгийн идэвхтэй байгаа хүүхдийн тоо 71330 болсон нь өмнөх 2003 оныхоос 1,4 хувиар өссөн дүнтэй байна. Өөрөөр хэлбэл 5-17 насны нийт хүүхдийн дундах ажил эрхлэлтийн түвшин 11,5 хувь байна. Эдгээр ажил эрхэлдэг хүүхдүүдийн 89,4 хувь нь хөдөө орон нутагт, 10,6 хувь нь хот суурин газарт амьдарч байна. Ажил эрхэлж байгаа хүүхдүүдийн 60,3 хувь нь (43037) эрэгтэй хүүхдүүд байна. Ажил хийсэн хүүхдийн тоог эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл хөдөө аж ахуйд 88,9 хувь, бөөний болон жижиглэн худалдаанд 5,1 хувь, боловсруулах аж үйлдвэр, барилгад 2,7 хувь, уул уурхай, олборлох аж үйлдвэрт 1,0 хувь, бусад салбарт 2,3 хувь байна. 2007 онд үйлдвэр худалдааны болон энгийн ажил эрхэлдэг хүүхдийн тоо 2003 оныхоос 2 дахин, үйлчилгээний салбар, дэлгүүр зах дээр худалдаа наймаа эрхэлдэг хүүхдийн тоо 27,0 хувиар нэмэгджээ. Хүүхдийн ажилласан цагийг үндэслэн тооцоолоход ажил эрхэлж буй нийт хүүхдийн 61,9 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. (сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан цагаар тооцсон). Энэ нь 2003 оныхоос нэмэгдсэн үзүүлэлт юм.

Хүүхэд насаа хөдөлмөр эрхэлж өнгөрөөж буй хүүхдүүдийн эрхийг хамгаалах, хүүхдээр аюултай, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлүүлэхгүй байх зорилт өнөөдрийн нийгэмд чухлаар тавигдаж байна. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд олон улсын хөдөлмөрийн стандартууд гол чиг баримтлал болно. Олон улсын хөдөлмөрийн стандартын хэрэгжилтийг ОУХБ-аас гишүүн орнуудынхаа засгийн газар, ажил олгогчид, ажиллагсдын төлөөллийг оролцуулан жил бүр хэлэлцдэг. Эдгээр баримт бичгүүд хүүхдийн хөдөлмөрийн болон хөдөлмөрийн холбогдолтой бусад асуудлаар улс орнуудад үндэсний хэмжээнд явуулах үйл ажиллагааг тодорхойлж өгдөг. Хүүхдийн хөдөлмөрийн талаар 1973 онд баталсан “Ажилд авах насны доод хязгаарын тухай” 138-р конвенц, 1999 онд баталсан “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай” 182-р конвенцид тус тус заасан байдаг. Монгол улс 138-р конвенцид 2002 онд, 182-р конвенцид 2001 онд нэгдэн оржээ.

Шигтгээ

Айлд мал маллаж , гэрийн үйлчлэгч хийх, хийж буй хүүхдүүд

Нэгэн аймгийн харьяат нэг малчин эцэг эхтэй ярилцаж 16 настай хүүгээр нь өөр аймгийн нутаг хүртэл малаа тууварлуулах, хөлсөнд нь 10 ямаа өгөх, тодорхой хугацааны дараа зардлыг нь даан хүүг нь гэрт нь буцаахаар тохиролцжээ. Гэвч малчин тэр хүүг тохиролцсон хугацаанд нь буцааж явуулалгүй, 4 жил 7 сарын турш мал маллуулж, ноослох, сааль саалгах, хашаа хороо засуулах зэргээр зарцалж, малчин айлын хэн дуртай нь зодож занчин, өсвөр насыг нь амьдралын тэвчишгүй нөхцөл, дарамтанд өнгөрүүлсэн байна. Энэ хугацаанд хүүгийн эцэг эх хүүгээ хайж сураглаж, сумынхаа цагдаад мэдэгдээд ч тус болсонгүй тухайн айлын сураг тасарсан байжээ. Харин хүүг зарцалж байсан айлын ойр орчмыхон хүүгийн байдлын тухай мэдэж, явуулаар ирсэн хүмүүст дайлган зугтаалгаж, гэр бүлийнхэнд нь хүргүүлжээ. Хүү болон түүний гэр бүлийнхэн Хүний эрхийн үндэсний комисст хандаж малчин айлд ажиллаж байсан хугацааны ажлын хөлс, түүнийг эрж хайхад зарцуулагдсан замын зардал, мөн хүүгийн сэтгэл санааны хохирлыг барагдуулж өгөхийг хүсч, тус комисс улмаар талуудын хоорондын маргааныг зуучлах аргаар шийдвэрлэж, хүүгийн нэхэмжилсэн мөнгөний тодорхой хувийг хариуцагч талаас гаргуулах тохиролцоонд хүрсэн байна.

(ХЭҮК – ийн мэдээлэл , 2004)

¹Эх үүсвэр: ҮСГ, ОУХБ. Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгаа 2006-2007 танилцуулга

1.2 Хүүхэд хэдэн наснаасаа ажил эрхэлж болох вэ?

ОУХБ-ын 1973 онд гаргасан Ажил эрхлэх насны доод хязгаарын тухай 138-р Конвенцид хүүхдийн ажил эрхэлж болох насны доод хязгаарыг заавал эзэмших боловсрол эзэмших наснаас доошгүй буюу ямар ч тохиолдолд 15 нас ба түүнээс дээш нас гэж заасан байдаг. Гэсэн хэдий ч 1996 онд болсон ОУХБ-ын бага хурлаар олон хүүхэд ажил эрхэлж байгаа ба зарим нь 5 ба 6 настайгаасаа эхлэн ажиллаж байна гэж мэдээлжээ.

Ажил эрхэлж болох насны доод хязгаар		
Ажилд орох насны доод хязгаар (2-р зүйл)	Хөнгөн ажил (7-р зүйл)	Аюултай ажил (3-р зүйл)
Заавал боловсрол эзэмших наснаас доошгүй буюу ямар ч тохиолдолд 15 наснаас доошгүй	13 нас	18 нас

138-р конвенц, үүнтэй нягт уялдаатай хэрэгжүүлэхээр ОУХБ-аас баталсан 146-р зөвлөмжид ажил эрхлэх насны доод хязгаарыг дараахь салбарт нэн тэргүүнд мөрдөнө гэж заасан.

Эдгээр нь:

- ➔ Уул уурхай,
- ➔ Боловсруулах үйлдвэр,
- ➔ Барилга,
- ➔ Цахилгаан, эрчим хүч,
- ➔ Байгалийн хий ба усан хангамж,
- ➔ Эрүүл ахуйн үйлчилгээ,
- ➔ Тээвэр, агуулга, харилцаа холбооны салбар,
- ➔ Худалдаа арилжааны зориулалтаар бүтээгдхүүн үйлдвэрлэдэг тариалангийн аж ахуйнууд (өрхийн, орон нутгийн хэрэгцээг хангах зорилгоор бүтээгдхүүн үйлдвэрлэдэг өрхийн ба бага оврын аж ахуйг үл хамруулна).

Дараах тохиолдолд 138-р конвенцийн заалт хамаарахгүй бөгөөд эдгээр нь:

- ➔ ЕБС, ТМС болон бусад сургалтын байгууллагуудад насанд хүрээгүй хүмүүсийн сургалтын зорилгоор хийж буй ажил,
- ➔ Эрх бүхий байгууллагаас тодорхойлсон шаардлага хангасан нөхцөлд 14-өөс дээш насны хүүхдийн доорхи тохиолдолд хийж буй ажил
 - тухайн сургууль, мэргэжлийн сургалтын байгууллагаас хариуцан явуулж буй хичээл, дамжаа,
 - зохих зөвшөөрлийн дагуу үйлдвэрийн газрын дэргэд явуулж буй мэргэжлийн сургалт,
 - мэргэжил, сургалтын төрлийг сонгоход тус дөхөм болоход чиглэсэн танилцуулах болон баримжаа олгох хөтөлбөрийн салшгүй хэсэг байвал үл хамаарна.

1.3 Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд

1999 онд Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай 182-р конвенцийг ОУХБ-ын гишүүн 175 орны ажил олгогчид, үйлдвэрчний эвлэл болон засгийн газрын төлөөлөгчид хамтран баталсан. Энэхүү баримт бичгийг баталсан нь хүүхдийн хөдөлмөрийн зарим хэлбэр нь хүүхдийн үндсэн эрхийг ноцтойгоор зөрчиж байгаа учраас нэн даруй устгах хэрэгтэй гэдэг дээр олон улсын хэмжээнд санал нэгдэж байгааг харуулсан юм. Конвенцид нэгдсэнээрээ улс орнууд өөрийн оронд 18-аас доош насны бүх хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох, устгахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг.

ОУХБ-ын 182-р Конвенцийн гол үзэл санаа

ОУХБ-ын Конвенц нь хүүхдийн хөдөлмөрийг багасгах, цаашид устгах зорилгыг агуулдаг. Конвенци нь:

- ➔ *18-аас доош насны бүх хүүхдийг хамардаг.*
- ➔ *Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох, устгахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээнүүдийг нэн даруй авч хэрэгжүүлэхийг шаарддаг.*
- ➔ *Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг тодорхойлсон. Үүнд: хүүхдийг боолчлох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, зарах, хил давуулан худалдах; зэвсэгт мөргөлдөөнд хүүхдийг хүчээр буюу албадан элсүүлэх; хүүхдийг биеэ үнэлэх үйл ажиллагаа, садар самууны сурталчилгаа болон бусад хууль бус үйл ажиллагаанд ашиглах, аюултай ажил хийлгэх зэрэг багтана.*
- ➔ *Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох, хүүхдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэхээс урьдчилан сэргийлэх, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг уг хөдөлмөрөөс хөндийрүүлэх, нөхөн сэргээх, нийгмийн ердийн амьдралд нь буцаан оруулах, бүх хүүхдэд суурь боловсролыг үнэ төлбөргүй олгоход чиглэсэн арга хэмжээг авахыг шаарддаг.*
- ➔ *Охидын болон бусад эрсдэлд байгаа хүүхдүүдийн онцгой нөхцөл байдлыг харгалзан үзэхийг чухалчилсан.*
- ➔ *Үйл ажиллагааны хөтөлбөр болон мониторингийн механизм бий болгохыг анхаарсан*

ОУХБ-ын 182-р Конвенцийн дагуу хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт дараах үйл ажиллагааг авч үздэг байна. Үүнд:

- Боолчлолын бүх хэлбэрүүд болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан ажил хийлгэх буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд хүүхдийг хүчээр буюу албадан элсүүлэх зэрэг боолчлолтой төстэй үйл ажиллагаанууд,
- Хүүхдийг биеэ үнэлэх үйл ажиллагаа, садар самууны сурталчилгаа болон садар самууны үзүүлбэрт ашиглах эсвэл оролцохыг санал болгох,
- Хүүхдийг хууль бус үйл ажиллагаанд, мансууруулах бодис үйлдвэрлэх, нууцаар наймаалах зэрэг олон улсын холбогдох гэрээнүүдэд заагдсан хууль бус үйл ажиллагаанд ашиглах эсвэл оролцохыг санал болгох;
- Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд ажлын мөн чанар, хөдөлмөрийн нөхцөлөөрөө сөрөг нөлөө үзүүлэхүйц ажлууд буюу “аюултай ажлууд” хамаарна гэж тодорхойлсон.

182-р конвенцтэй нягт уялдаатай хэрэгжүүлэхээр хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 190-р зөвлөмжийг ОУХБ-аас 1999 онд баталсан бөгөөд гишүүн

орнуудаас доорх үйл ажиллагааг багтаасан Үйл Ажиллагааны Үндэсний Хөтөлбөрийг батлахыг уриалсан. Үүнд:

- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг тодорхойлсон,
- Бага насны хүүхэд, охид, аюулд илүү өртөмтгий нуугдмал шинжтэй ажил хийж буй болон бусад эмзэг бүлгийн хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийг хамгаалсан,
- Хүүхдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг уг хөдөлмөрөөс хөндийрүүлэх, тэднийг нөхөн сэргээх, нийгмийн ердийн амьдралд буцаан оруулах арга хэмжээг агуулсан,
- Олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх, хүчийг нь дайчлах үйл ажиллагааг тусгасан байхыг санал болгосон байдаг.

Олон улсын хөдөлмөрийн 190-р зөвлөмжид зааснаар аюултай ажил гэдэг нь:

- Хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн болон бэлгийн хүчирхийлэлд өртүүлэхүйц ажил,
- Газар дор, усны гүнд болон аюултай өндөрт эсвэл хэтэрхий давчуу орон зайд хийж буй ажил,
- Аюултай машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй харьцаж буй ажил,
- Эрүүл бус орчинд ажиллах тухайлбал, аюултай бодис, урвалжтай харьцах,
- Тодорхой хүнд нөхцөлд, тухайлбал уртасгасан цагаар эсвэл шөнийн цагаар, эсвэл ажил олгогчийн ажлын байранд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хашигдан хийж буй ажлууд, түүнчлэн хүнд ачааг гараараа өргөж, зөөх болон тээвэрлэх зэрэг биеийн хүчний ажил орно.

Шигтгээ

ОУХБ-ын 190-р зөвлөмжид аюултай ажлыг өөрийн орны нөхцөлд тохируулан тодорхойлох, аюултай ажлын шалгууруудыг бий болгохыг гишүүн орнуудаас уриалсан байдаг. Аж ахуйн нэгж, байгууллагад хүүхдийн хөдөлмөрийн стандартуудыг хангах зорилгоор Хөдөлмөрийн тухай хуулийн 109.5 дахь заалтын дагуу Насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг ЭМНХ-ын сайдын 1999 оны А/204 тоот тушаалаар батлан мөрдөж байна. Жагсаалтад эдийн засгийн үйл ажиллагааны 36 чиглэлийн 326 ажил, үйлчилгээ тусгагдсан. Аж ахуйн нэгж байгууллагад хөдөлмөрийн хяналт тэр бүхэнд хүрч чадахгүй байгаа, хөдөлмөрийн хяналтад хамрагдах боломжгүй албан бус хэвшлийн хүрээ өргөжсөн, хүүхдийн хөдөлмөр олон хэв шинжийг агуулах болсон, эдийн засгийн үйл ажиллагааны төрөл олширч байгаа зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалан жагсаалтыг дээрхи өөрчлөлтүүдэд нийцүүлэн шинэчлэх шаардлага гарч байгаа юм. Түүнчлэн манай улс ОУХБ-ын 182 ба 138 дугаар Конвенциудын зарчмыг хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх төрийн бодлого, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх явцад гарч буй бодлогын өөрчлөлтүүдийг хүүхдийн хөдөлмөрийн стандартуудтай уялдуулан авч үзэх хэрэгцээ ч мөн байна.

Иймд бодлогын хүрээнд гарч буй дээрхи хэрэгцээ, шаардлагыг үндэслэн уг жагсаалтыг шинэчлэн батлахаар Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын тушаалын төслийг боловсруулж байна.

Жагсаалтын төслийг боловсруулах явцад аюултай ажлын төрлүүдийг тодорхойлох үндсэн шалгууруудыг /аюулын төрөл, хүүхдэд үзүүлэх сөрөг нөлөө, аюулд өртсөн хүүхдийн тоо, нүдэнд үзэгдэх байдал, хүүхдийн аюулд өртөх магадлал, өртөлтийн хэмжээ, түүнийг засах боломж/ боловсруулж, ажлын хэсгээр хэлэлцүүлсэн ба жагсаалтын төслийн үе шаттай хэлэлцүүлгийг хийж байна.

Эх сурвалж: Нийгмийн хамгаалал Хөдөлмөрийн Яамны вэб хуудаснаас /http://www.mswl.pmis.gov.mn/index.php?option=com_content&task=view&id=110&Itemid=2 / 2008 оны 5 сард авав.

1.4 АЙПЕК: Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр

ОУХБ 1992 оноос Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр (АЙПЕК)-ийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн зорилго нь хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх үндэсний чадавхийг бэхжүүлэх, хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх олон улсын хөдөлгөөнийг өрнүүлэх замаар хүүхдийн хөдөлмөрийг бүрмөсөн устгахад чиглэдэг. АЙПЕК нь үндэсний түвшинд хөдөлмөрийн асуудлаарх төрийн яамд, ажил олгогчдын болон үйлдвэрчний байгууллага, ТББ-ууд болон холбогдох бусад төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажилладаг. АЙПЕК нь хамтрагч байгууллагууддаа хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийг аюултай ажлаас хөндийрүүлэх, хүүхдийн ажлын нөхцөлийг өөрчлөх, сайжруулах замаар хөдөлмөр эрхлэх хуулийн насанд хүрсэн хүүхдүүдийг аюулгүй ажил хийлгэх нөхцөлийг бүрдүүлэх (энэ нь хүүхдийн хөдөлмөрийн устгахад чиглэсэн шилжилтийн арга хэмжээ юм) арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэхэд нь тусалдаг.

АЙПЕК-ийн туршлагаас харахад хүүхдийн хөдөлмөр нь өөрөө олон шалтгаанаас үүдэлтэй олон талт асуудал учраас түүнтэй тэмцэх үйл ажиллагааг илүү эерэг үр дүнтэй, урт хугацааны тогтвортой үйл ажиллагаа болгохын тул түүнийг цогц, олон талтай байдлаар зохион байгуулах ёстой байна. Энд зөвхөн хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг ажлаас нь хөндийрүүлэх эсвэл хүнд тэвчишгүй хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг аврах чиглэлийн хөтөлбөр хангалтгүй юм. Эдгээр хүүхдүүдийг буцаад хөдөлмөр эрхлэх эсвэл бүр өмнөхөөсөө дор нөхцөлтэй ажил хийж эхлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд тэднийг цаашид хөгжих боломж бололцоогоор, тухайлбал боловсрол эзэмших, сурах боломжоор хангах хэрэгтэй. Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх үйл ажиллагаа нь ядуурал, хөдөлмөр эрхлэлтийг бууруулах, цалингийн доод хэмжээг нэмэгдүүлэх үйл ажиллагаатай нягт уялдаатай байх ёстой. Ажлын байрнаас нь хөндийрүүлсэн хүүхдийн оронд өөр нэг хүүхэд орохоос урьдчилан сэргийлэх үр дүнтэй, өртөг багатай тогтолцоо байх шаардлагатай.

Монгол улсад АЙПЕК нь 1999 оноос үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдтэй тэмцэх үндэсний хугацаат хөтөлбөрийн дэмжих төсөл”-ийг 2005 - 2009 онуудад хэрэгжүүлж байна. АЙПЕК-аас хэрэгжүүлж буй энэхүү төсөл нь:

- I. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн эсрэг үндэсний хэмжээний үйл ажиллагааг дэмжсэн эерэг орчныг бэхжүүлэх,
- II. Охид, хөвгүүдийг тэвчишгүй хэлбэрүүдийн хөдөлмөрөөс хөндийрүүлэх, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх зорилгоор аймаг, орон нутгийн хэмжээний үйл ажиллагааны загварыг боловсруулан хэрэгжүүлж, цаашид бусад орон нутагт дэлгэрүүлэх зорилготой.

1.5 Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад чиглэсэн нөлөөллийн стратеги /2007-2011/

Монгол улсад хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах зорилгыг хангахад “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад чиглэсэн нөлөөллийн стратеги”-ийг 2007 оны 5-р сард баталсан нь чухал ач холбогдолтой юм. 2007-2011 онд хэрэгжүүлэх тус нөлөөллийн стратегид

- Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, хэрэгжүүлэгчид
- Ажил олгогчид
- Үйлдвэрчний эвлэлүүд
- Сэтгүүлчид
- Олон нийт, эцэг эх, хүүхдүүд гэсэн зорилтот бүлгүүдэд чиглэсэн тодорхой стратегиудыг дэвшүүлжээ.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахын төлөө олон нийтийн ухамсрыг төлөвшүүлэх, нийгмийн тогтвортой хүчин чармайлтыг бий болгоход нөлөөллийн стратегийн дунд хугацааны зорилго чиглэгдэж байгаа бөгөөд үүнд хүрэх зорилт, стратегийг дараах байдлаар тодорхойлон хэрэгжүүлэх үйл ажиллагаа явагдаж байна.

“Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад чиглэсэн нөлөөллийн стратеги”-ийн зорилтууд	
Зорилт 1: Хүүхдийн хөдөлмөрийн талаарх мэдээллийн багтаамж, чанар, хүртээмжийг сайжруулах	Стратеги 1. Хүүхдийн хөдөлмөрийн талаархи судалгааны чанар, хүрээг өргөжүүлэх. Стратеги 2. Хүүхдийн хөдөлмөрийн талаархи мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх. Стратеги 3. Хүүхдийн хөдөлмөр, түүний тэвчишгүй хэлбэрүүдийн талаархи олон нийтийн ойлголтыг төлөвшүүлэх ажлыг хэвшүүлэх. Стратеги 4. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлогыг хүүхдийн хөдөлмөрийн асуудалд чиглүүлэх.
Зорилт 2. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах чадавхийг бий болгож нэмэгдүүлэх	Стратеги 1. Үндэсний болон орон нутгийн түвшинд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн эсрэг бодлого боловсруулах, хэлэлцэн батлаж чадавхийг бэхжүүлэх. Стратеги 2. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх Стратеги 3. Хүүхдийн эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтын үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлэх.
Зорилт 3. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн эсрэг бүх талын хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх	Стратеги 1. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн эсрэг төрийн бүх шатны болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг тогтворжуулах. Стратеги 2. Нийгмийн түншлэлийг үр дүнтэй ашиглах.
Зорилт 4. Хүүхэд, эцэг эх, ах дүү, иргэд, албан бус хэвшилд ажиллагсад, ажил олгогч, олон нийтэд хүүхдийн хөдөлмөр, түүний тэвчишгүй хэлбэрүүдийн талаар зөв ойлголтыг төлөвшүүлж, тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад тэдний оролцоог нэмэгдүүлэх	Стратеги 1. Хүүхэд, эцэг эх, ах дүү, төрөл төрөгсөд, иргэд, албан бус хэвшилд ажиллагсад, ажил олгогчдын хүүхдийн хөдөлмөр, түүний тэвчишгүй хэлбэрүүдийн тухай ойлголтыг дээшлүүлж хандлагыг төлөвшүүлэх. Стратеги 2. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад хүүхэд, өсвөр үеийнхний оролцоог нэмэгдүүлэх.
Зорилт 5. Хүүхдийн хөдөлмөрийн харилцааг зохицуулж байгаа үндэсний хууль тогтоомжийг олон улсын конвенц, эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгон хэрэгжүүлэх	Стратеги 1. Хүүхдийн хөдөлмөрийг зохицуулсан хууль тогтоомжийг олон улсын конвенц, эрх зүйтэй нийцүүлэн боловсронгуй болгох

Хүүхдийн хөдөлмөрийн асуудалтай холбоотой олон улсын конвенц, зөвлөмж болон Монгол улсын хуулиуд

- ➔ Ажилд авах насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 138-р конвенц
- ➔ “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай” ОУХБ-ын 1999 оны 182-р конвенц, 190-р зөвлөмж
- ➔ Монгол улсын Үндсэн хууль
- ➔ Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль
- ➔ Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль
- ➔ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- ➔ Боловсролын тухай хууль
- ➔ Иргэний хууль
- ➔ Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль
- ➔ Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль
- ➔ Садар самуунтай тэмцэх тухай хууль
- ➔ Монгол улсын Эрүүгийн хууль
- ➔ Тамхины хор хөнөөлтэй тэмцэх хууль

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа нь бусад нийгмийн бодлого, хөтөлбөрүүдтэй уялдаатай хэрэгжих шаардлагатай юм. Тухайлбал:

- ➔ Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого
- ➔ Монгол Улсын Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө
- ➔ Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого
- ➔ Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөр 2002-2010
- ➔ Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого
- ➔ Зохистой хөдөлмөрийн үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр
- ➔ Хүүхдийн хөдөлмөр, түүний тэвчишгүй хэлбэрүүдийг устгах талаар МҮЭХ-ноос баримтлах бодлого 2004
- ➔ Монголын Боловсрол Шинжлэх ухааны Үйлдвэрчний Эвлэлээс “Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг Монголын багш нарын өдөр”-ийг жил бүрийн 9 сарын 27 нд хийхээр шийдвэрлэсэн шийдвэр
- ➔ Монгол улсад хүүхдийн хөдөлмөр, түүний тэвчишгүй хэлбэрүүдийг устгах, урьдчилан сэргийлэхэд ажил олгогч эздийн оролцоог идэвхжүүлэх тухай МАОЭНХ-ны стратегийн чиг баримтлал,
- ➔ Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр,
- ➔ 2015 он гэхэд уул уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийг устгах 3 талт үйл ажиллагааны уриалга ба үйл ажиллагааны төлөвлөгөө гэх мэт бодлогын баримт бичгүүд байна.

II БҮЛЭГ

НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ

БҮЛГИЙН ТОВЧ АГУУЛГА:

- 2.1 Нөлөөллийн тухай үндсэн ойлголт**
- 2.2 Нөлөөллийн ажилд шаардагдах ур чадварууд**
- 2.3 Нөлөөллийн үйл ажиллагаа явуулах хэлбэрүүд**
- 2.4 Нөлөөллийн ажлын ёс зүйн асуудлууд**
- 2.5 Нөлөөллийн түвшин**

2.1 Нөлөөллийн тухай үндсэн ойлголт


Нөлөөллийн ажлыг дараах 2 үндсэн шалтгаанаар явуулдаг. Үүнд:

1. Бодлого, шийдвэр, хөтөлбөр, хууль тогтоомжийг өөрчлөх, шинэчлэх
2. Зан үйл, дадал хэвшлийг өөрчлөх


Нөлөөллийн ажил нь дараах үйл ажиллагааг хамардаг. Үүнд:

Зургаар илэрхийлсэн байдал


Нөлөөлөл нь ямарваа үзэл бодлыг өргөн мэдүүлэх, хамгаалах эсвэл шийдвэр гаргагч нарт танин мэдүүлэх үйл ажиллагаа юм.




Нөлөөлөл гэдэг бол асуудлыг ил тод зоригтой гарган ярих, чухал асуудалд хүмүүсийн анхаарлыг хандуулах, шийдвэр гаргагч нарыг тухайн асуудлыг шийдвэрлэх алхам руу чиглүүлэх үйл ажиллагаа юм.



Нөлөөлөл гэдэг нь нөхцөл байдлыг эерэгээр өөрчлөхийн тулд бусад хүмүүс, байгууллагуудтай холбоо сүлжээ тогтоож, хамтран ажиллана гэсэн үг юм.



Нөлөөлөл гэдэг нь хувь хүмүүсийн хооронд болон мэдээллийн хэрэгслээр тодорхой зорилготой мэдээллийг дамжуулах үйл ажиллагаа юм.



Нөлөөлөл нь хүмүүсийн ойлголт, зан үйл, асуудалд хандах хандлагыг өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагаа юм.



Нөлөөлөл нь бүлгийн гишүүдийг өөрсдийгөө төлөөлөхөд нь тусалж, дэмжих, чадваржуулах үйл ажиллагаа юм.



Нөлөөллийн үйл ажиллагааг амжилттай явуулахад харгалзах дараах хүчин зүйлүүд байна. Үүнд:

- ➔ Чадварлаг багаар ажиллах
- ➔ Нөлөөлөх асуудлын талаар сайн судалсан, баримт нотолгоо сайтай байх
- ➔ Нөлөөллийн цар хүрээг тодорхойлж, нөлөөллийн үйл ажиллагаа чиглэгдэж байгаа бүлэгт тохируулсан гол илгээмж мэдээллийг сайтар боловсруулсан байх
- ➔ Нөлөөллийн үйл ажиллагааны стратеги тактикийг сонирхогч талууд, зорилтот бүлгийг аль алиныг харгалзан тохируулан сонгох
- ➔ Нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг сайн боловсруулах
- ➔ Сонирхогч талуудтай хамтын ажиллагааг өрнүүлэх, өөрөөр хэлбэл шийдвэр гаргах нөлөө бүхий хүмүүс, байгууллагатай хамтрах ажиллагаа, ижил төстэй үйл ажиллагааг явуулдаг байгууллага, хүмүүстэй хамтрах
- ➔ Зорилтот бүлгийг оролцуулах тухайлбал хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд, тэдний гэр бүлийнхнийг үйл ажиллагаандаа оролцуулах
- ➔ Нөлөөллийн үйл ажиллагаа явуулах цаг хугацааг оновчтой сонгох
- ➔ Төсөв хөрөнгө бүрдүүлэх
- ➔ Тууштай, уйгагүй ажиллах

2.2 Нөлөөллийн ажилд шаардагдах ур чадварууд

Нөлөөллийн үйл ажиллагааны төрлүүдээс харахад нөлөөллийн ажлыг явуулахын тулд хэд хэдэн ур чадвар зайлшгүй шаардлагатай нь харагдаж байна. Тухайлбал:

- ➔ Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар судалгаа, дүн шинжилгээ хийх чадвар
- ➔ Нөлөөллийн ажлыг төлөвлөх, удирдах, хяналт шинжилгээ хийх ур чадвар
- ➔ Олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлын ур чадвар
- ➔ Лоббидох ур чадвар
- ➔ Мэдээллийн хэрэгслийг үр дүнтэй ашиглах, харилцаа холбоо тогтоох ур чадвар
- ➔ Олон нийттэй ажиллах, тэдний оролцоог дайчлах чадвар
- ➔ Эвсэл холбоо байгуулах, бусад байгууллага, оролцогч талуудтай хамтран ажиллах ур чадвар
- ➔ Урьдчилан тооцоогүй нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлэх чадвар

Эдгээр ур чадварыг хэрхэн бий болгох, хэрхэн ашиглах талаар тодорхой аргачлалыг энэхүү гарын авлагын дараа дараагийн бүлгүүдэд өгүүлнэ. Дараах хүснэгтийг харна уу.

Нөлөөллийн ажил явуулахад шаардагдах ур чадварууд	Тодорхойлолт
Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар судалгаа, дүн шинжилгээ хийх чадвар	- Нөлөөлөх, өөрчлөх шаардлагатай асуудлыг тодорхойлох, - Асуудалд дүн шинжилгээ хийж мөн чанар, цар хүрээг тодорхойлох, - Бодлого, эрх зүйн байдалд дүн шинжилгээ хийх, - Бодлогын боловсруулалт, хэрэгжилтийн уялдаа холбоог тогтоох, - Давуу ба сул тал, гадаад ба дотоод орчны дүн шинжилгээ хийх, - Баримт тоо мэдээлэлд дүн шинжилгээ хийх, - Судалгааны аргууд ашиглан судалгаа явуулах - Сонирхогч талуудыг тодорхойлох чадваруудыг хамруулна.
Нөлөөллийн ажлыг төлөвлөх, удирдах, хяналт шинжилгээ хийх ур чадвар	-Бодлогын түвшинд болон байгууллага, хүмүүст нөлөөлөх ажлын зорилго, зорилтыг тодорхойлох, төлөвлөгөө гаргах, - Нөлөөллийн арга техникээ сонгох, илгээмжийг боловсруулах, ашиглах, шаардлагатай нөөцийг тодорхойлох, -Нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, үнэлэх, -Манлайлах, удирдах, зохион байгуулах чадваруудыг хамруулна.
Олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлын ур чадвар	Олон нийттэй харилцах, хурал цуглаан зохион байгуулах, илтгэл, мэдээлэл хийх, сурталчилгааны материал боловсруулах, түгээх, сурталчилгааны хэлбэрүүдийг сонгож ашиглах зэрэг чадваруудыг хамруулна.
Лоббидох ур чадвар	Шийдвэр гаргагчдад нөлөө үзүүлэхийн тулд тэдэнтэй харилцаа холбоо тогтоох, нөлөөллийн ажлын хэрэгцээг ойлгуулах, асуудлыг танилцуулах, мэдээллээр хангах, ятган үнэмшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадварыг хэлнэ.
Мэдээллийн хэрэгслийг үр дүнтэй ашиглах, харилцаа холбоо тогтоох ур чадвар	Олон нийтэд хүрэх хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, мэдээлэл дамжуулах сувгуудыг сонгох, ашиглах, нөлөөллийн илгээмжийг боловсруулан, асуудлыг танилцуулах, бичих ур чадваруудыг хамруулна.
Олон нийттэй ажиллах, тэдний оролцоог дайчлах чадвар	Олон нийтийн уулзалт цуглаан зохион байгуулах зэрэг аргуудыг ашиглан нөлөөлөх асуудалд олон нийтийн анхаарлыг татах, нөлөөллийн үйл ажиллагаанд дэмжигч, хамтрагч хүмүүс, байгууллагын оролцоог хангах үйл ажиллагааг зохион байгуулах чадвар болно.
Эвсэл холбоо байгуулах, бусад байгууллага, оролцогч талуудтай хамтран ажиллах ур чадвар	Нөлөөллийн ажлыг үр дүнтэй явуулах баг эвсэл бүрдүүлэх, сонирхогч талууд, дэмжигчдийн оролцоог хангах, тэдэнтэй хамтран ажиллах чадварыг хэлнэ.

2.3 Нөлөөллийн үйл ажиллагаа явуулах хэлбэрүүд

Хүүхдийн хөдөлмөрийн чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа нь:

- ➔ Хүмүүсийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх
- ➔ Хүүхдийн хөдөлмөрийн үр дагавар, тулгамдсан асуудалд олон нийтийн анхаарлыг татах
- ➔ Хүүхдийн хөдөлмөрийг устгах, хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх, хууль журамд өөрчлөлт оруулах
- ➔ Хүүхдийн хөдөлмөрийг устгах үйл ажиллагаанд хамтын ажиллагааны сүлжээ бий болгож, хамтран ажиллах
- ➔ Хөдөлмөр эрхэлж буй хүүхэд, тэдний гэр бүлд тусламж дэмжлэг үзүүлэх
- ➔ Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн эрхийг хамгаалах, тэдний нийгмийн оролцоог дээшлүүлэх
- ➔ Хөдөлмөр эрхэлж буй хүүхэд, гэр бүлийг чадваржуулах
- ➔ Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх, хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх,
- ➔ Хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай хөрөнгө нөөцийг төвлөрүүлэх, нэмэгдүүлэх
- ➔ Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар бодлого боловсруулагчид, ажил олгогчид, хүүхдийн байгууллагын ажилтнууд, нийгмийн ажилтнууд зэрэг албан хаагч, мэргэжилтнүүдийн мэдлэг чадвар, үйл ажиллагааг дээшлүүлэх зэрэг үйл ажиллагааг хамруулна.

Нөлөөллийн үйл ажиллагааг хэн, хэний төлөө явуулж байгаагаас нь шалтгаалан 3 ангилалд хуваана.

Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх нөлөөллийн үйл ажиллагаа нь:

- Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн ТӨЛӨӨ хийх
- Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдтэй ХАМТРАН, тэдний оролцоотой хийх
- Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд ӨӨРСДӨӨ нөлөөлөл хийх гэсэн хэлбэрүүдээр явагдаж болно.

Хүснэгт: 2.3. Нөлөөллийн 3 хэлбэрийг харьцуулах нь:

	I. Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн ТӨЛӨӨ нөлөөлөл	II. Хүүхдүүдтэй ХАМТРАН хийх нөлөөлөл	III. Хүүхдүүдийн ӨӨРСДИЙН хийх нөлөөлөл
ХЭН ХИЙХ ВЭ?	Мэргэжлийн хүмүүс, ТББ-ууд, эцэг эхчүүд	Мэргэжлийн баг, ТББ, олон нийтийн бүлэг	Орон нутгийнхан ба хүүхдүүд
ӨӨРЧЛӨЛТНИЙН ГОЛ ЗОРИЛТ	Хууль, бодлого, үйл ажиллагааг өөрчлөх	-Шийдвэр гаргахад үйл явцад оролцох боломжоор хангах -Хууль, бодлого, практикийг өөрчлөх -Тухайн нөхцөл байдалд байгаа хүмүүсийн нөлөөлөл хийх чадавхи бий болно.	Нөлөөлөх боломж ба нөлөөллийн ур чадвар, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх
ҮНДСЭН ШИНЖҮҮД	Асуудлыг гол төлөв гадны хүмүүс тодорхойлно Албан ёсны шийдвэр гаргагчдад чиглэдэг.	Асуудлыг олон нийт, хүүхдүүд өөрсдөө тодорхойлдог. Төлөвлөх, хэрэгжүүлэх явцыг хамтран хэрэгжүүлдэг. Нөөцөө хуваалцана. Гаднаас оролцогчид чадавхийг бэхжүүлдэг.	Асуудлыг олон нийт, хүүхдүүд өөрсдөө тодорхойлдог. Оролцох явцдаа суралцдаг. Гаднаас дэмжлэгтэй-гээр эхэлж болно.
ДАВУУ ТАЛ	Шийдвэр гаргагчдад хурдан хүрэх Өргөн агуулга бүхий мэдээлэл олж авдаг.	Шийдвэр гаргагчдад эмзэг бүлгийнхэн дуу хоолойгоо хүргэх нь нэмэгддэг. Нөлөөлөл явуулах ур чадвар ба чадавхи сайжирдаг.	Хүүхдүүд болон нийгмийн эмзэг бүлгийнхэн өөрсдийгөө өөрчлөлт хийх чадвартай гэдэгтээ итгэж чадваржина Тогтвортой үргэлжилнэ Эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг засаж болно.
ДУТАГДАЛТАЙ ТАЛ	Эрх мэдлийн одоогийн бүтэц хэвээр байна. Орон нутгийн бүлгийн үйл ажиллагааны чадавхи өсөхгүй	Мэргэжлийн хүмүүс, ТББ нь зорилгоо тодорхойлж, үйл ажиллагаагаа өөрсдөө хэрэгжүүлэх магадлалтай. Талуудын хоорондын тохиролцоонд хүрэхэд цаг зарна	Нөөц хөрөнгө ба мэдээлэл олж авах боломж бага Хариу арга хэмжээнд өртөх, өс хонзон үүсэх эрсдэлтэй Бодлогын өөрчлөлт удаан явагдана.

Эх үүсвэр: Gordon, Graham. (2002) Advocacy toolkit: Understanding advocacy. UK: TearFund. x.24.

2.4 Нөлөөллийн ажлын ёс зүйн асуудлууд

Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдтэй хамтран болон тэдний төлөө хийх нөлөөллийн үйл ажиллагаа явуулахад ёс зүйн асуудлыг анхаарах нь чухал бөгөөд энэ нь хүүхдийн амьдралд сөрөг үр дагавар учруулахаас хамгаална.

Хамгийн чухал ёс зүйн зарчим нь Хүүхдэд хор хохирол учруулахгүй байх зарчим юм. Үүнийг тодруулбал:

- ➔ Хүүхдийг эрсдэлд оруулахаас хамгаалах
- ➔ Хүүхдийн нэр төр, тэдний гаргасан шийдвэрийг хүндэтгэх
- ➔ Нөлөөллийн үйл ажиллагаанд хүүхдийн зураг, бодит түүхийг ашиглах бол тэднээс зөвшөөрөл авах
- ➔ Хамгийн тохиромжтой, боломжтой мэдээллийг ашиглах хэрэгтэй. Энэ нь хэвлэл мэдээлэлд ялангуяа хамааралтай бөгөөд сэтгүүлч нийтлэлчид судлагдсан, баталгаатай мэдээллийг ашиглах хэрэгтэй. Хүүхдийг дарлан мөлжиж байгаагаа хүлээн зөвшөөрөхийг хүсэхгүй байгаа ажил олгогчид, хүмүүс бүрэн бус, үнэн байдалд нийцээгүй мэдээллийг өөртөө ашигтайгаар ашиглаж болох юм.
- ➔ Хүүхдийг ойшоогоогүй, ялгаварлан гадуурхсан, сөргөөр харуулсан ямарваа зураг, дүрслэлийг ашиглахгүй байх, үг хэллэг хэрэглэхгүй байх
- ➔ Хүүхдийн нэр төрийг тэдний зөвшөөрөлгүй бусдад мэдэгдэхгүй байх, ингэснээр хүүхдийг бусдын дарамт шахалтад орохоос хамгаална.
- ➔ Хүүхдийн нөхцөл байдлыг хэтрүүлэн дүрсэлж хүмүүст сэтгэл хөдлөл төрүүлэх байдлаар ашиглахгүй байх. Жишээ нь хэвлэл мэдээлэл хүмүүст гүн сэтгэгдэл төрүүлэх үүднээс хүүхдүүдийн нөхцөл байдлыг эмгэнэлтэйгээр хэтрүүлэн дүрслэх нь буруу юм. Энэ нь нэр төрөө хамгаалуулах, бусдаар хүндэтгүүлэх хүүхдийн эрхийг зөрчиж байгаа хэрэг юм.
- ➔ Биелэгдэхгүй зүйлийн талаар хүүхдэд амлалт өгөхгүй байх
- ➔ Хэрэгжих боломжгүй зүйлийн талаар хүүхдэд хүлээлт төрүүлэхгүй байх

Дээрх ёс зүйн зарчмыг зөрчсөнөөр ямар сөрөг үр дагавар гарах вэ?

- ➔ Сонин өгүүллэг, хэвлэмэл материалаас хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн талаар ажил олгогч нь мэдвэл хүүхдийг дарамтлах, ажлаас халах эрсдэлтэй.
- ➔ Биеэ үнэлдэг хүүхдүүдийн талаар хэт нарийвчлан бичсэн тохиолдолд секс сонирхсон жуулчид ямар үнээр, хаанаас хүүхдийг олж болохыг мэдэх аюултай.
- ➔ Хүүхдийг хохирогч, биеэ үнэлэгч, гудамжинд амьдардаг гэх мэтээр дүрслэн түүх, зургийг нь ашиглан бичсэн бол тэд ичдэг. Хүүхдүүд хүмүүсээр өрөвдүүлэх объект болох дургүй.
- ➔ Хүүхдүүд өөрсдийн тухай томчуудад мэдээлж дэмжлэг хүсдэг боловч нөхцөл байдал нь өөрчлөгдөхгүй болохоор сэтгэлээр унадаг.
- ➔ Хүүхдийн талаар биеэ үнэлдэг, архи мансууруулах бодис хэрэглэдэг, ХДХВ, өвчинтэй гэх мэтээр хэтрүүлэн бичсэнээс болж тэднийг гадуурхах, хавчих, тэр ч байтугай ингэж хариуцлагагүй бичсэнээс болж хүүхэд амь насаа алдсан тохиолдол гарчээ.

2.5 Нөлөөллийн түвшин

Нөлөөллийн ажлыг зөвхөн бодлого боловсруулах түвшинд явуулдаг гэсэн нийтлэг ойлголт байдаг. Тэгвэл дор өгөгдсөн зургаас бид нөлөөллийн ажлыг ямар ч түвшинд явуулж болдгийг харж болно. Аль ч түвшинд гаргасан шийдвэр, үр нөлөө нь бусад түвшинд мөн адил нөлөөлнө. Тиймээс нөлөөлөхийг зорьж буй асуудлын онцлог, өөрийн байгууллагын үйл ажиллагааны туршлага, чиглэлийг харгалзан аль түвшинд ажиллахаа сонгодог.

Зураг 1.1. Нөлөөллийн түвшин²



²Эх үүсвэр: Gordon, Graham. (2002) Advocacy toolkit: Understanding advocacy. UK: TearFund. x.36.

III БҮЛЭГ

НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨХ НЬ

БҮЛГИЙН ТОВЧ АГУУЛГА

- 3.1 Төлөвлөлтийн үе шатууд**
- 3.2 Асуудалд дүн шинжилгээ хийх аргачлал**
- 3.3 Зорилго, зорилтоо тодорхойлох нь**
- 3.4 Сонирхогч талуудыг тодорхойлох нь**
- 3.5 Зорилтот бүлгийг тодорхойлох нь**
- 3.6 Нөлөөллийн стратеги, тактикийг сонгох нь**
- 3.7 Нөлөөллийн ажлын төлөвлөгөө боловсруулах нь**

3.1 Төлөвлөлтийн үе шатууд

(1) Асуудалд дүн шинжилгээ хийх

- ➔ Тухайн асуудал хэнд, хэрхэн нөлөөлж байна вэ? Хүн амын бүлгүүдэд өөр өөрөөр нөлөөлж байна уу?
- ➔ Асуудлын учир шалтгаан нь юу вэ?
- ➔ Тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хэн илүү үүрэг, хариуцлага хүлээх вэ?
- ➔ Асуудлыг шийдэх боломжтой ямар шийдвэр, үйл ажиллагаа байна вэ?
- ➔ Эдгээр шийдвэр, үйл ажиллагаанууд хүн амын бүлэгт бүхэлд нь болон дэд бүлгүүдэд хэрхэн нөлөөлөх вэ?

(2) Зорилго, зорилтоо тодорхойлох

- ➔ Бид юуг өөрчлөхийг хүсэж байна вэ? Ямар аргаар?
- ➔ Ямар асуудлаас эхлэх нь зүйтэй вэ?
- ➔ Энэ нь чухал асуудал мөн үү?
- ➔ Энэ асуудлаар нөлөөллийн ажил явуулах бодит боломж байна уу?

(3) Зорилтот бүлэг болон бусад сонирхогч талуудыг тодорхойлох

- ➔ Хэний төлөө өөрчлөлт хийх вэ?
- ➔ Шийдвэр гаргагчид ба шахалт үзүүлэгчид, болон дэмжигчид ба эсэргүүцэгчдийг хэрхэн тодорхойлох вэ?

(4) Нөлөөллийн стратеги ба тактикаа сонгох шат

- ➔ Хамтрах, олон нийтэд чиглэсэн компанит ажил ба өрсөлдөх стратеги ба тактикуудаас алийг сонгох вэ?

(5) Хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах шат

- ➔ Хэн юуг хэзээ хийх вэ?
- ➔ Хэрхэн нөлөөллийг үйл ажиллагааг зохион байгуулах вэ?
- ➔ Ямар нөөцөд тулгуурлан хэрэгжүүлэх вэ?

3.2 Асуудалд дүн шинжилгээ хийх аргачлал

Дор өгөгдсөн аргачлал нь нөлөөлөхийг хүсч буй асуудалдаа дүн шинжилгээ хийх болон асуудлаа илүү сайн ойлгоход тань хөтөч болно.

3.2.1 Асуудлыг нарийвчлан тодорхойлох нь

Ямар бэрхшээлтэй асуудлыг шийдэх гээд байгаа дээрээ санал нийлээгүй тохиолдолд түүнийг шийдэх боломжгүй юм. Иймээс тулгарч буй гол асуудлыг бүх оролцогч талын хүчин чармайлтаар тодорхойлох хэрэгтэй. Асуудлыг ийнхүү тодруулан дүн шинжилгээ хийх явцад нөлөөллийн үйл ажиллагаа нь илүү тодорхой болж ирдэг.

Хүүхдээ хөдөлмөр эрхлүүлж буй гэр бүлүүд хүүхдийн хөдөлмөрийг асуудал гэж үздэггүй, харин тэдний амьдрах нэг арга гэж үздэг. Иймээс хүүхэд хөдөлмөр эрхэлснээс үүдэн гарах ямар хүндрэлтэй асуудлыг шийдэх гэж байгаагаа аль болох тодруулах хэрэгтэй. Тэгэхгүй бол таны үйл ажиллагаа “хүүхдийн хөдөлмөрийг устгах” биш “хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн амьдрал, тэдний ирээдүйг ойлгохгүй байгаа” үйл ажиллагаа болж магадгүй юм.

Асуудлыг нарийвчлан тодорхойлохдоо дараах асуудлыг хөндөж буй эсэхийг анхаарна уу:

- ➔ Хүүхдийн нөхцөл байдал: боловсрол, эрүүл мэнд, хүсэл мөрөөдөл, ур чадвар гэх мэт
- ➔ Гэр бүлийн нөхцөл байдал: эцэг эхийн ажил эрхлэлт, амьжиргааны түвшин
- ➔ Соёлын хүчин зүйлс
- ➔ Жендерийн хүчин зүйлс
- ➔ Нийгэм эдийн засгийн орчин нөхцөл
- ➔ Хөдөлмөрийн нөхцөл: хэр хэмжээний цалин хөлс авдаг, цалин хөлсөө өөрөө авдаг уу, гэр бүлдээ өгдөг үү, хэнд өгдөг, урьдчилгаа мөнгө төлдөг үү, цалин хөлсийг хасах ямар тохиолдол байдаг, бэлэн бусаар төлөх /хувцас, хоол хүнс, эм, тариа, гэх мэт/ тохиолдол байдаг уу, бэлэг өгдөг үү, урьдчилан тохиролцсон гэрээ бий юу, хэн гэрээг хийсэн, хүүхдийн эцэг эх болон хүүхэд өөрөө гэрээний нөхцөлийг мэдэж байгаа юу г.м.
- ➔ Хөдөлмөрлөх орчин нөхцөл: ямар ажил хийдэг, аюултай нөхцөл байдал байна уу, санамсаргүй гэмтэл бэртэл авах тохиолдол байсан уу, хэдэн цаг ажилладаг, хэдэн удаа хэдэн минутаар амардаг, амралтын бүтэн өдөр байдаг уу, хүүхдэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх боломж байдаг уу, жилдээ хэдэн удаа гэртээ харьдаг вэ, хүүхэд хаана унтдаг, юу идэж уудаг, гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхэдтэй хэрхэн харьцдаг вэ, хүүхдийг хэрхэн шийтгэдэг гэх мэт

Шигтгээ: Нөлөөллийн ажилд тоо баримт хэрхэн нөлөөлөх вэ?

Нөлөөллийг амжилттай явуулахын тулд:

- ➔ Таамаглал дээр бус тодорхой тоо баримт дээр үндэслэн үйл ажиллагаа явуулах нь чухал.

Харин:

Тоо баримт ашиглахгүйгээр үйл ажиллагаа явуулж эхэлбэл нөлөөлөл амжилтгүй болоход хүрнэ.

3.2.2. Асуудал хичнээн хүнийг хамарч байна вэ?

Асуудал хичнээн хүнийг хамарсан цар хүрээг нь мэдэхгүй бол нөлөөлөгчид тухайн асуудлын талаар зөвхөн өнгөц ойлголттой байна гэсэн үг юм. Иймээс Хичнээн хүүхэд тухайн салбарт (жишээ нь уул уурхайд, хөдөө аж ахуйд, гэрийн үйлчилгээнд г.м.) ажиллаж байна вэ? Хичнээн хүүхдэд таны тусламж дэмжлэг хэрэгтэй байна вэ? гэх мэт тодорхой мэдээллийг зайлшгүй цуглуулах шаардлагатай.

Тухайлбал дараах салбарт хичнээн хүүхэд ажиллаж байна вэ? гэсэн мэдээллийг цуглуулж болно.

Албан бус салбар дахь ажил

“Албан бус салбар” нь хот, суурин газрын ядуу иргэдийн дийлэнх нь эрхэлдэг, орлого бий болгох үйл ажиллагааг өөртөө агуулсан эдийн засгийн үйл ажиллагааны нэг хэлбэр юм. Энэ салбар нь орлого багатай жижиг үйл ажиллагаанаас эхлээд (жишээ нь хог түүх, гутал тослох гэх мэт) цөөн ажиллагсадтай жижиг аж ахуй (загас агнуурын жижиг аж ахуй, уул уурхай, хөдөө аж ахуй болон жижиг худалдаа, чулуу цохих) хүртэлх бараг бүх төрлийн үйл ажиллагааг хамардаг.

Тэдний хийж буй ажил нь “албан” биш учраас төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ болон татварын байгууллагын хяналтаас гадуур байдаг. Тэднийг ажиллуулдаг хүмүүс нь ажил олгогч гэж ихэнхдээ бүртгэгдээгүй хүмүүс байдаг. Зарим хүүхдүүд ямар ч хөлс авдаггүй, зөвхөн хоол, унтах орон байрны төлөө ажилладаг. Албан бус салбарт ажиллаж буй хүүхдүүдэд ажлын байрны баталгаа байхгүй, хэрэв өвчлөх юм уу, гэмтэл бэртэл авбал ямар ч хөлс авахгүй. Ажил олгогчийн дарамт шахалтнаас хамгаалах хамгаалал огт байдаггүй. Хэдийгээр тухайн улсад хүүхдийн хөдөлмөрийг хориглосон хууль тогтоомж байсан ч ийм хүүхдүүд ажилласаар л байдаг байна.

Хот суурин газарт ажил эрхэлж буй хүүхдүүд

Хөгжиж буй орнуудын том, жижиг бараг бүх хотууд болон ихэнх хөгжингүй орнуудад хүүхдүүд хөдөлмөр эрхэлж байдаг. Үүний нэг шалтгаан нь хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн их байгаагаас үүдэн ажил хийх шаардлагатай хүүхэд олширч байгаагаар холбоотой. Үүнээс болж хотын ядуурал нэмэгддэг ба ажил эрхэлж буй хүүхдүүд эрүүл ахуйн нөхцөл бүрдээгүй орчинд амьдарч, ажиллахаас өөр аргагүй болдог байдаг.

Ажил эрхэлж буй хүүхдүүдийн тоог хамгийн томоохон бүлгээс нь эхлэн дурьдвал: бусдын гэр оронд үйлчилгээний ажил хийдэг хүүхдүүд хамгийн өндөр хувийг, үүний дараагаар зоогийн газар, зочид буудал, дэлгүүрт ажилладаг хүүхдүүд, жижиг үйлдвэрлэлийн газар ажилладаг хүүхдүүд, гэр бүлтэйгээ хамтран гэрээрээ жижиг бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажил хийдэг, охидын хувьд дүү нараа асрах (эцэг эхчүүд нь гэртээ юм уу гэрээсээ гадуур орлого олох ажил эрхэлдэг учраас) зэрэг үйл ажиллагаа эзэлж байна.

Хөдөө аж ахуйн салбарт ажиллаж буй хүүхдүүд

Олон улсын хэмжээнд авч үзвэл хөдөө орон нутагт хот суурин газраас илүү олон хүүхэд ажилладаг. Хүүхдүүд ихэнхдээ тариалангийн талбай, фермүүдэд ажилладаг ба мал маллах болон бусад олон төрлийн ажлыг хийдэг. Зарим хүүхдүүд гэр бүлийнхэнтэйгээ хамт ажиллаж, өөрийн гэртээ амьдардаг. Нөгөө нэг хэсэг нь ажил олгогч, малчин, газар эзэмшигчид рүүгээ өдөр бүр очиж ажилладаг. Бусад нь гэр бүлээсээ хол газар ажилладаг ба энэ тохиолдолд хууль бус тохиролцоогоор эсвэл тэдэнд ямар ч ашиггүй нөхцөлтэйгээр ажиллахад хүрдэг. Хөдөө аж ахуйн салбарт хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэх, өрийн төлөөс болгон ажиллуулах явдал тохиолддог. Ийм төрлийн албадан хөдөлмөрөөс хүүхэд

өөрөө зугтаж чаддаггүй тул өөр хүмүүс хүүхдийг “аврах” шаардлагатай болдог юм. Дээрх мэдээллийг дараах эх үүсвэрүүдээс олох боломжтой байдаг. Үүнд:

- **Төр захиргааны байгууллага, яам болон агентлаг** –Үндэсний болон орон нутгийн түвшний засаг, захиргааны байгууллагын тайлан, мэдээллээс зорилтот хүн амын тоо, энэ чиглэлээр зарцуулсан төсөв, хөрөнгө, засгийн гарын хөтөлбөр, төслийн тухай мэдээллийг олох боломжтой.
- **Их дээд сургууль болон нийгмийн судалгааны байгууллагууд** –Нийгмийн асуудлууд, тухайлбал эрүүл мэнд, эдийн засгийн асуудлууд, орон нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар олон нийтэд зориулсан мэдээ нийтлэхээс гадна тухайн салбарын бусад мэргэжилтнүүдэд зориулан сэтгүүлүүд гаргадаг.
- **Төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллага болон иргэний нийгмийн байгууллагыг хамарсан нөлөөллийн бүлэг** – олон байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааны чиглэлээр мэдээлэл бэлтгэх, мэдээ, заавар нийтлэхэд зориулан судалгаа явуулах ба тусгай мэдээллийг эрж олох ажлыг зохион байгуулдаг.
- **Сурвалжлагч, сэтгүүлчид** – зарим нэг нь таны хайж буй сэдвээр гүнзгийрүүлсэн, сайтар судалсан нийтлэл бичсэн байдаг.
- **Компаний тайлан, мэдээлэл** (захирлуудын нэрс, удирдах зөвлөлийн гишүүдийн нэрс, компанийн эзэмших хувьцаа, зарим нэг хууль ёсны асуудал гэх мэт) –ийг олон нийтэд мэдээлсэн байж болно.
- **Санхүүжүүлэгч байгууллага** – Дэлхийн банк, Олон Улсын Валютын Сан зэрэг олон улсын хандивлагч байгууллагууд болон хувийн сангууд өөрсдийн санхүүжүүлж буй төслүүдтэй холбогдолтой мэдээллийг нийтэлдэг.
- **Бусад байгууллага** – НҮБ гэх мэт.
- **Интернет** – и-мэйл болон веб хуудас нь дээрх эх үүсвэрүүд болон шинээр бий болгосон мэдээллийг сайтар судалж багтаасан баялаг эх үүсвэр болдог.

Хүүхдийн хөдөлмөрийн талаар мэдээлэл бүхий интернетийн веб хуудаснууд

Олон улсын байгууллагууд:

Хүүхдийн Эрхийн Мэдээллийн Сүлжээ: www.crin.org

Хүүхэд-Хүүхдэдээ байгууллага: www.child-to-child.org

Олон улсын Хүүхдийн тусламжийн байгууллага: www.childwatch.uio.no

Ази дахь Хөдөлмөр Эрхлэгч Хүүхдүүд байгууллага: www.cwa.tnet.co.th

Олон улсын ECPAT байгууллага: www.ecpat.net

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн хөдөлгөөн: www.globalmarch.org

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага: www.ilo.org

Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр (АЙПЕК): www.ilo.org/public/english/standards/ipecc/index.htm

Зүүн Өмнөд, Зүүн Ази Номхон Далайн бүс нутгийн Хүүхдийг Ивээх Сан: www.seapa.net

Их Британий Хүүхдийг Ивээх Сан: www.savethechildren.org.uk

НҮБ-ын Хүүхдийн Сан: www.unicef.org

Үндэсний байгууллагууд:

Хүүхдийн Төлөө Үндэсний Газар: www.nac.gov.mn

Монгол дахь АЙПЕК хөтөлбөр: www.ipeccmon.mn

Монголын Үйлдвэрчний Эвлэлүүдийн Холбоо: www.cmtu.mn

Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо: www.monef.mn

Хүүхдийн биеийг үнэлэх, дамжуулан худалдаахыг зогсоохын төлөө олон улсын сүлжээний

Монгол дахь сүлжээ: www.ecpat.mn

Эх сурвалж: Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх Азийн бүсийн ажлын хэсэг. Хамтран ажиллахад суралцахуй. УБ.2007, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах нөлөөллийн стратеги. УБ. 2007.

3.2.3 Асуудлын шалтгаан, үр дагавар нь юу вэ?

Асуудлын шалтгаан, үр дагавар нь юу болохыг судалгаа явуулах, дүн шинжилгээ хийх, архив, сонин хэвлэлийн мэдээлэлтэй танилцах, олон нийтийн төлөөлөгч, удирдагчидтай уулзаж ярилцах, сонгосон бүлгийн уулзалт хийх замаар мэдэж болно. Нөлөөлөгчид өөрсдөө тухайн асуудлынхаа шалтгаан, үр нөлөөний талаар ойлгосон, энэ талаар сайтар баримт мэдээлэлтэй байх нь бусдын анхаарлыг энэхүү асуудал хандуулах, тэдэнд нөлөөлөхүйц сэтгэгдэл төрүүлэхэд тус болдог.

Хүснэгт 3.2. Хүүхдийн аюултай ажил ба эрүүл мэндэд үзүүлэх үр нөлөө

Үйлдвэрлэлийн салбар	Эрхэлдэг үйл ажиллагаа	Аюултай нөхцөл байдал	Эрүүл мэндийн үр дагавар
Хөдөө аж ахуй	Хурц иртэй багаж, цахилгаанаар ажилладаг машин техниктэй ажиллах, ХАА-д ашигладаг химийн бодистой харьцах, цацах, мал маллах, хонь хариулах, жимс ногоо хураах, зэрлэг түүх, өвс тэжээл бэлтгэх, ачих, зөөх.	Зориулалтын бус, хамгаалалтгүй машин техник, багаж хэрэгсэл; хөдөлгүүрт машин техникийн осол, дуу чимээ, чичиргээ ихтэй нөхцөл; үр цэвэрлэх машинаас унах, даруулах; аюултай ан амьтан; биологийн хорт хаягдал; аюултай химийн бодис; хэт хүнд ажил хийх; хамгаалах хэрэгсэлгүйгээр ажиллах; халуун хүйтэнд ажиллах; хүнд ачаа өргөх, буулгах;	Гар хөлөө зүсэх, гэмтэл авах, амь насаа алдах, гар, хөлийн хуруу, үе мөчөө таслах; толгойдоо гэмтэл авах, болон машин техникийн бүрэн бус ажиллагаанаас шалтгаалсан гэмтэл бэртэл, дүлийрэх; нүдээ гэмтээх; вирусны гаралтай болон бусад халдварт өвчин тусах; арьсны өвчин; халуунд цохиулах; химийн бодист хордох
Хивс нэхэх	Ноос ялгах, угаах, гараар суурь машин эргүүлэх, нэхэх, будах, тэгшилж хайчлах.	Эвгүй байрлалд ажиллах, гэрэлтүүлэг ба агааржуулалт муутай орчинд ажиллах, эрүүл ахуйн нөхцөл муу байх, аюултай химийн бодистой ажиллах, нэг хөдөлгөөнийг байнга давтдаг ажил хийх	Булчин шөрмөс, нуруу нугасны өвчин, хараа муудах, амьсгалын замын өвчин, ядаргаа, химийн бодист хордох
Керамик, шилний үйлдвэр	Шил ялгах, зүсэх, керамикийг шатаах, шил будах, хэвэнд оруулах, халуун шил зөөх	Халуун газар ажиллах, халуунд цохиулах, хагарсан халуун шил дээр гишгэх, барьж явах, агааржуулалт муутай орчинд ажиллах, тоосжилтийн аюултай түвшинд ажиллах, тугалганд хордох	Түлэгдэх, хагарсан шилнээс гар хуруугаа зүсэх, нүдээ гэмтээх, халуунд цохиулах, амьсгалын замын өвчин, тугалганд хордох
Мал нядлах, мах боловсруулах, эвдэх	Мал нядлах, мөчлөх эвдэх, арьсыг нь хуулах, үхсэн малыг зөөх	Машин техник, тоног төхөөрөмжийн зүй бус ажиллагаа, биологийн хорт бодистой харьцах, температурын хэт өөрчлөлт, эрүүл ахуйн муу нөхцөлд, боловсруулаагүй шингэн болон хатуу хаягдал, агааржуулалт муутай нөхцөлд ажиллах	Унаж гэмтэх, гар хөлөө зүсэх, хөрөө болон бусад багаж зэвсгээс болж гэмтэл авах, түлэгдэх, бруцелоз, уушигний сүрьеэгээр өвчлөх, халуурах, халуунд цохиулах, ясны үртэст цохиулж нүдээ гэмтээх, биеийн хүч их шаардах, амьсгалын замын өвчин

Усны гүнээс загасчлах	Сувд түүх, загас үргээх зэргээр 60 метрээс гүн шумбах.	Агаарын өндөр даралтанд ажиллах, хүчилтөрөгч дутагдсанаас осолд орох, хор аюултай загастай харьцах, эрүүл ахуйн шаардлага хангахгүй нөхцөлд хэт олуулаа байрлах, удаан цагаар ажиллах	Агаарын өндөр даралтаас шалтгаалах өвчин; хүчилтөрөгчийн дутагдлаас шалтгаалан өвчин тусах, нас барах; ходоод гэдэсний өвчин; уушигний болон зүрх судасны өвчин
Гудамжны ажил	Барааг явж хашгирч зарах, жижиглэн худалдах, хар тамхи зөөх, сонин зарах, гутал тослох, гуйлга гуйх, машин угаах, дуу дуулах, бараа хүргэж өгөх, мэдээ хүргэх.	Мансууруулах бодис, хүчирхийлэл, гэмт хэрэг, биеэ үнэлэхтэй холбоотой үйл ажиллагаанд оролцох; авто машины осолд орох, эрүүл мэнд, ёс суртахуунаараа доголдох, олон цагаар ажиллах	Хөдөлгүүрт техник хэрэгслийн осол гэмтэл; мансууруулах бодис хэрэглэх; нийгмээс гадуурхагдах /гэмт хэрэгт дахин дахин өртөх/; ядаргаа, хоол тэжээлийн дутагдал; ДОХ болон бусад бэлгийн замын халдварт өвчин; нийгэм-сэтгэл зүйн асуудал; хүсээгүй жирэмслэлт

Эх үүсвэр: ОУХБ.Хүүхдийн хөдөлмөр: Их дээд сургуулийн оюутнуудад зориулсан сурах бичиг УБ 2007

Шигтгээ

Ширмэнбаатар хүү анх 5 настай байхдаа асрамжийн газар ирсэн бөгөөд 8 настай байхад нь Ганбат хэмээх хүн хууль ёсны дагуу өргөж авсан. Ширмэнбаатар хүү одоо 10 настай. Иргэн Ганбат өөрийн уяач болох Улаанбаатар хотын Өлзийт хорооны иргэн Болд гэдэг хүнийд морь унуулж, мал хариулуулхаар авчирчээ. 2007 оны 3 сард түүнийг уяач хөөжээ. Хөөх болсон шалтгаан нь уралдааны үед морниосоо унаж түрүүлэх ёстой байсан морь 6-д орууллаа гэж уурлан хөөсөн байна. Уг морь нь уралдааны үед түрүүлсэн бөгөөд хүүхэдгүй орж ирсэн учраас хойшлуулан 6-д оруулжээ. Хүү хурдан морины уралдааны үеэр олон удаа унаж гэмтэл, бэртэл их авдаг байжээ. 8 настай байхдаа нурууныхаа хэсгийг хугалж эмнэлэгт хэвтэж байсан.

Эх үүсвэр: (ХЭҮК-ийн мэдээлэл, 2004)

Нөлөөллийн ажиллагаагаа эхлэхэд эхний алхам болох асуудлаа сонгож үүндээ дүн шинжилгээ хийхдээ "Яагаад?" асуулт ба Асуудлын модыг ашиглан асуудалд дүн шинжилгээ хийх аргыг ашиглах нь үр дүнтэй. Тус аргыг хэрхэн ашиглах аргачлалыг тайлбарлая.




Аргачлал: 3.1 "Яагаад" асуулт ба Асуудлын модыг ашиглан хүүхдийн хөдөлмөрийн асуудалд дүн шинжилгээ хийх нь:

Зааварчилгаа:

- ➔ Хүүхдийн хөдөлмөртэй холбоотой тодорхой нэг асуудлыг сонгож ав. Тухайн асуудал "яагаад", юунаас болоод бий болж байгааг бич. Шалтгаан тус бүрийн ард мөн "яагаад?", "юунаас болоод?" гэдэг асуултыг тавих байдлаар хэлэлцүүлгийг үргэлжлүүл.
- ➔ Үүний дараа асуудлын гол шалтгааныг модны үндэс дээр байрлуулж бичнэ.
- ➔ "Хүүхдийн хөдөлмөрийн үр дагавар юу вэ?" гэдгийг модны мөчрүүд дээр бичнэ: Тухайлбал:
 - Хүүхдийн гэр бүл, найз нөхөдтэйгээ харилцах харилцаа
 - Хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл санаа, зан байдал
 - Хүүхдийн боловсрол, ирээдүйн ажил эрхлэлтэнд гарах үр дагавар
- ➔ Эцэст нь "Хүүхдийн хөдөлмөртэй холбоотой энэхүү асуудлын шалтгааныг арилгахын тулд юу хийх ёстой вэ?" сэдвээр хэлэлцүүлэг, ярилцлага зохион байгуулах нь зүйтэй.

Ажлын хуудас: Асуудлын мод



3.2.4 Асуудлыг шийдэхэд саад болж буй ямар хүчин зүйлс байна вэ?

Нөлөөлөгчид нь хүүхдийн хөдөлмөрийг устгахтай холбоотой шийдвэрлэх асуудлыг сонгоод тухайн асуудлыг шийдэхэд саад болж буй хүчин зүйлс, хувь хүмүүс, нөхцөл байдал, үнэт зүйлсийг тодорхойлно. Саад бэрхшээл үргэлж тохиолдох бөгөөд тэдгээрийг мэдсэнээр цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа тодорхой болж өгнө. Асуудлыг шийдэхэд саад болж буй хүчин зүйлсийг тодорхойлоход Хүчин зүйлсийн дүн шинжилгээний аргыг ашиглаж болно.




Аргачлал 3.2. Асуудалд нөлөөлж буй хүчин зүйлсийн дүн шинжилгээ хийх аргачлал

Зааварчилгаа:

1. Хийх гэж буй өөрчлөлтийн талаар бодож цаасны гол хэсэгт бичнэ.
2. Тухайн үйл ажиллагааг явуулахад дэмжлэг болж буй хүчин зүйлсийг бичнэ.
3. Мөн тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд саад болж байгаа ямар хүчин зүйлс байна гэдгийг тодорхойлж холбогдох хүснэгтэнд бичнэ.
4. Хүчин зүйл бүрийг нөлөөлөх байдлыг нь харгалзан 1-5 оноогоор үнэлнэ.
5. Дэмжих болон саад болж буй хүчин зүйлсийн онооны нийлбэрийг гаргана
6. Дэмжиж байгаа хүчин зүйлийг хэрхэн сайн ашиглах болон саад болох хүчин зүйлсийг хэрхэн хязгаарлах талаар эцэст нь дүгнэлт гаргана.

**Өөрчлөлтийг дэмжиж
буй хүчин зүйл**

**Өөрчлөлтөнд саад болж
буй хүчин зүйл**



3.2.5 Асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах эрх мэдэл, боломж хэнд байна вэ?

Эрх мэдэл нь бусдыг өөрсдийн үйлдлээ өөрчлөхөд хүргэх боломж чадавхийг илэрхийлнэ. Нөлөөлөгчид аливаа нэг шийдвэрийг боловсруулахын өмнө, төрийн болон олон нийтийн байгууллагын гол нөлөөтэй хүн хэн бэ гэдгийг олж мэдэх ёстой. Нөлөө бүхий хүмүүстэй хамтарч ажиллах стратеги эсвэл тэдний эсрэг явуулах үйл ажиллагааг бодож олох, цаашид гаргах шийдвэрт анхаарна. Эрх мэдэлтэй хүмүүсийг таньж мэдэх нь аль ч тохиолдолд ихээхэн чухал байдаг.

Доорх ажлын хүснэгтийг ашиглан эрх мэдэл бүхий ямар хүмүүс, байгууллагад нөлөөллийн үйл ажиллагаагаа чиглүүлж хамтран ажиллахаа тодорхойлно. “Эрх мэдэл, нөлөө” өндөртэй мөртлөө тухайн асуудлаар “төвийг сахих” байр суурьтай байгаа шийдвэр гаргагчдад нөлөөлөх үйл ажиллагааг төлөвлөнө.



Аргачлал 3.3 Маш чухал шийдвэр гаргагчдыг тодорхойлох нь

	Маш чухал шийдвэр гаргагчид	Чухал шийдвэр гаргагчид	Шийдвэр гаргахад чухал үүрэгтэй биш
Хүчтэй дэмжигч			
Дундын зэргийн дэмжигч			
Төвийг сахигч			
Дунд зэргийн эсэргүүцэгч			
Хүчтэй эсэргүүцэгч			

Энэ хүснэгтээс нөлөөллийн ажлын хүрээнд:

- Хэнтэй хамтран ажиллах /хүчтэй дэмжигч, дунд зэргийн дэмжигч/
- Хэнд нөлөөлөх / төвийг сахигч/
- Хэний зүгээс эсэргүүцэл тулгарч болохыг тодорхойлно.

3.2.6 Энэхүү асуудлыг шийдвэрлэхэд амжилт олох боломж хэр зэрэг байна вэ?

Нөлөөлөгчид амжилттай шийдвэрт хүрэх магадлалтай асуудлыг анхнаасаа л тодорхойлсон байх ёстой. Хэрэв хүчний харьцаа тэнцвэргүй, ялагдал хүлээх нь ойлгомжтой бол өөр асуудалд шилжихийг зөвлөж байна. Нөлөөлөлд оролцогчид ялах боломж байгааг олж харах ёстой. Эс тэгвээс удалгүй сэтгэлээр унах болно. Мөн зорилгодоо хүрэхэд төлөвлөсөн хугацаа нь бодит байдалд нийцэх учиртай.

“Бид хэн бэ?” гэсэн асуултанд хариулах шаардлагатай болно. Эдгээрийг авч үзвэл:

- ➔ Бид хэн бэ? Хэтийн ямар зорилго болон уламжлал энэ ажлыг хийхэд хүргэв?
- ➔ Бид өөрсдөөсөө гадна хэн нэгнийг төлөөлж байна уу? Хэрвээ тийм бол бид тэдгээр хүмүүсийн өмнө ямар үүрэг, хариуцлага хүлээх вэ?
- ➔ Бидний эрх мэдлийн эх сурвалж юу вэ?
- ➔ Бидний хууль ёсны болон итгэл үнэмшлийн эх сурвалж юу вэ? Бидний үзэл бодол уу? Шийдвэр гаргагчдын үзэл бодол уу?
- ➔ Бидэнд ямар эрсдэл тулгарах вэ? Бид юунаас эмээж байна вэ? Хэрвээ бид ямар нэг арга хэмжээ авбал юу тохиолдож болох вэ?
- ➔ Бидний үнэт зүйл юу вэ? Яагаад бид нөлөөлөх үйл ажиллагаанд оролцож байна вэ? Бид хэрхэн хамтарч ажиллавал зүйтэй вэ?

Нөлөөллийн ажлыг явуулахын тулд хэд хэдэн үр чадвар зайлшгүй шаардлагатайг бид 1-р бүлэгт үзсэн. Нөлөөллийн ажлын чадвартаа тулгуурлан нөлөөлөх үйл ажиллагааны арга стратегийг сонгох нь зүйтэй. Иймээс нөлөөллийн ажлын чадвартаа үнэлгээ хийж хамтран ажиллах байгууллага, мэргэжилтнүүдийг сонгох арга ашиглаж болно.

3.2.7 Нөлөөлөх чадвараа үнэлэх аргачлал

Нөлөөлөл хийх баг, хүмүүс нь өөрсдийн чадавхи боломжоо бодитой үнэлэх нь нөлөөллийн үйл ажиллагаагаа явуулахад ач холбогдолтой. Нөлөөллийн ажилд шаардлагатай дээр дурдсан чадваруудыг хэрхэн эзэмшсэн байдлаар өөрийн үнэлгээг хийж болно. Өөрийн үнэлгээний торон диаграммын аргыг ашиглах зааврыг толилуулъя.



Аргачлал 3.4 Нөлөөллийн чадавхид хийх өөрийн үнэлгээний аргачлал

Зааварчилгаа:

1. Нөлөөллийн чадваруудыг бичсэн торон диаграммыг том дэлгэц цаасан дээр урьдчилан бэлтгэсэн байна. Өөрийн үнэлгээг өөрсдөө хийж болох ба гадны дэмжигчийн заавар дэмжлэгийн дагуу багаар хийх нь үр дүнтэй байдаг байна.
2. Чадвар тус бүрээр хэлэлцэж 0-3 гэсэн онооноос тохирох оноог тухайн чадварын харалдаа зураасан дээр тэмдэглэнэ.
3. Бүх чадваруудаар өөрийн үнэлгээ хийсний дараа тэмдэглэсэн зураасаа холбож үзнэ.
4. Холбогдсон зураасаар илэрхийлэгдэх дүрсэнд дүн шинжилгээ хийнэ. Нөлөөлөгч баг нь тойргийн гадна руу тэмдэглэгдсэн чадвартаа тулгуурлах, тойргийн дотор руу тэмдэглэгдсэн чадвараа хөгжүүлэх, эсвэл энэ чиглэлээр өөр бусад байгууллага, мэргэжилтнүүдээс туслалцаа дэмжлэг авч болно гэж дүгнэж болно. Жишээ нь хэрэв танай баг, байгууллага лоббидох үйл ажиллагааны чадвар хангалттай бус үнэлгээтэй


бол лобби хийх талаар зөвлөх мэргэжилтэн ажиллуулах, эсвэл лоббидох чадвар сайн өөр байгууллагатай хамтран лоббидох үйл ажиллагааг тэднээр гүйцэтгүүлэн хамтарч ажиллах боломжтой гэж дүгнэж болно.

Нөлөөллийн чадавхид хийх өөрийн үнэлгээ

Өөрийн үнэлгээний оноо:

- 0 – Чадваржихийн тулд маш их ажиллах шаардлагатай
- 1 – Чадваржихийн тулд ихээхэн ажиллах шаардлагатай
- 2 – Цаашид зарим талаар чадваржих боломжтой сайн нөхцөл байдал
- 3 – Бага хэмжээгээр чадваржих боломж бүхий төгс нөхцөл байдал

Нөлөөллийн чадавхиа үнэлэх өөрийн үнэлгээний торон диаграммын арга



3.3 Зорилго, зорилтоо тодорхойлох

3.3.1. Зорилго гэж вэ?

Зорилго гэдэг нь энгийн үгээр тодорхойлбол бидний өмнө тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэснээр эсвэл өөрчлөлтийг хийснээр гарах үр дүнг хэлнэ.

Зорилго та бүхнийг юу бүтээхийг хүсэж байгаагаа “олж харах”-д туслах бөгөөд хэрвээ үүнийг харж чадвал, хүрэх боломжоо илүүтэй мэдрэх болно. Нөлөөллийн үйл ажиллагааны явцад эрс өөрчлөлт бий болох эсвэл бүтэлгүйтэх тохиолдолд зорилго нь хүмүүсийг чиглүүлж идэвхижүүлэн урам зориг өгөх тустай байдаг.

Нөлөөллийн ажлын зорилгыг тодорхойлоход анхаарах асуудлууд

- Бид юуг өөрчлөхийг хүсэж байна вэ? Ямар аргаар?
- Ямар асуудлаас эхлэх нь зүйтэй вэ?
- Энэ нь чухал асуудал мөн үү?
- Энэ асуудлаар нөлөөллийн ажил явуулах бодит боломж байна уу?
- Энэ асуудал ур чадварыг бий болгож, хүмүүсийг оролцуулах бололцоо олгож байна уу?

Шигтгээ: Нөлөөллийн ажилд зорилго хэрхэн нөлөөлөх вэ?

Нөлөөллийг амжилттай явуулахад:

- ➔ *Урт ба богино хугацааны сайтар төлөвлөсөн стратеги төвөөлөгөө чухал.*

Харин амжилтгүй болоход:

- ➔ *Эцсийн зорилго тодорхойгүй байх явдал нөлөөлдөг.*

Хэрэв тодорхой зорилгод хүрэхийн тулд олон хүн ажилладаг бол зорилгоо тодорхойлохдоо хамтран ажиллаж эсвэл зорилгоо тодорхойлсны дараа тэдэнд танилцуулж, харилцан зөвшилцөлд хүрэх хэрэгтэй.

Зорилгын жишээ

- ➔ 14-өөс доош насны хөдөлмөр эрхэлж буй бүх хүүхдийг хөдөлмөрөөс нь чөлөөлөх
- ➔ Уул уурхайн салбарт хөдөлмөр эрхэлж буй бүх хүүхдийг боловсролд хамруулах
- ➔ Гэрийн үйлчилгээнд хөдөлмөр эрхэлж буй хүүхэд бүрийг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, дэмжих бүлэгт харьяалуулах
- ➔ Зах дээр хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалсан захирамж гаргуулах
- ➔ Хүүхдийг ажил хийлгэхээр нэг газраас нөгөө рүү зөөвөрлөх явдлыг зогсоох

Эх үүсвэр: Black, 2002. A handbook for advocacy.
London: Anti-slavery International.

3.3.2. Зорилт гэж юу вэ?

Зорилт: *Урт хугацааны зорилгод хүрэхэд юуг өөрчлөх, энэ өөрчлөлтийг хэнээр, хэрхэн, ямар нөөцөөр хийлгэхийг хүсч байгааг зорилт гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл зорилт бол зорилгод хүрэх арга зам гэсэн үг.*

Зорилтын жишээ

- ➔ 2009 он гэхэд улсын хэмжээнд хөдөлмөр эрхэлж буй 6000 хүүхдийг хөдөлмөрөөс хөндийрүүлсэн байна.
- ➔ Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах үйл ажиллагааны аймгийн дэд хөтөлбөрийг 2008-2009 онд хэрэгжүүлнэ.

Зорилтуудаар юунд, ямар хүн амд өөрчлөлт гарах тухай тодорхойлно. Үйл ажиллагааны зорилтууд нь хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга замуудыг тодорхойлж өгнө.

Зорилт нь SMART буюу дараах таван шалгуурыг хангасан байх нь зүйтэй байдаг байна. Үүнд:

- Тодорхой байх (Шийдэх гэж байгаа асуудал тодорхой байх)
- Хэмжигдэхүйц байх (хийх гэж буй өөрчлөлтийг хэмжиж болохуйц байх)
- Хэрэгжих боломжтой байх (хийх гэж буй өөрчлөлтийг хийж болохуйц байх)
- Бодитой байх (байгаа нөөцийг ашиглан тодорхой хугацаанд өөрчлөлт хийхээр бодитой байх)
- Хугацаатай байх (өөрчлөлт хийгдэх хугацаа тодорхойлогдсон байх)

3.4 Сонирхогч талуудыг тодорхойлох нь

Өөрчлөлтийг хийж чадах хүмүүс ба байгууллагыг дайчлах, сургах, ухуулах, шахалт үзүүлэх зэрэг үйл ажиллагаа нийлээд нөлөөллийн үйл ажиллагааг бүрдүүлдэг. Эдгээр үйл ажиллагаанд оролцох хүмүүс болон байгууллагуудыг цаашид “сонирхогч тал” хэмээн нэрлэе.

Хүүхдийн хөдөлмөрийн нөлөөллийн үйл ажиллагаанд оролцох сонирхогч талууд:



3.4.1. Сонирхогч талуудыг ангилах нь

Сонирхогч талаа үнэлэхдээ “Сонирхогч тал бүр өөрчлөлтийг дэмжиж байна уу?” гэсэн асуулт тавьж сонирхогч талуудын дэмжлэг болон эсэргүүцлийн түвшинд тулгуурлан үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг боловсруулна.

Сонирхогч талуудын дэмжлэг болон эсэргүүцлийн түвшингээс хамааран дараах төрлүүдэд хуваана.

- Өөрчлөлтийг хүчтэй дэмжигч
- Төвийг сахигч эсвэл сул дэмжигч/эсэргүүцэгч
- Өөрчлөлтийг хүчтэй эсэргүүцэгч



Аргачлал 3.5 Сонирхогч талуудыг ангилах ба эрэмбэлэх аргачлал

Зааварчилгаа:

- ➔ Асуудалд дүн шинжилгээ хийх явцад тухайн асуудлаар нөлөөлөл хийхэд хамааралтай гэж тодорхойлогдсон бүх сонирхогч талуудаа жагсаана.
- ➔ Жагсаалтаа шийдвэр гаргагчид /албан болон албан бус/ болон шахалт үзүүлэгчид гэж ангилна.
 - Шийдвэр гаргагчид: Өөрчлөлтийг хийх эсвэл түүнд саад болох эрх мэдэл, хүч чадал хэнд байна вэ? Тулгамдсан асуудлыг авч хэлэлцэх эсвэл үл хайхрах эсэхийг хэн шийдэх вэ? Тэд ямар үүрэг, даалгавар хүлээдэг вэ? Тэд юуны төлөө хариуцлага хүлээдэг вэ?
 - Шахалт үзүүлэгчид: Хэн шийдвэр гаргагчдад нөлөөлж чадах вэ? Тухайн асуудлаар олон нийтийн санаа бодолд хэн нөлөөлж чадах вэ? Яагаад тэд нөлөөтэй байна вэ? Тэдний эрх мэдлийн эх сурвалж нь юунд орших вэ?
- ➔ Үүний дараа сонирхогч тал бүрийг дараах ангилалд хуваана. Үүнд:
 - Энэ асуудлыг шийдэхэд маш чухал
 - Зарим талаараа чухал
 - Чухал биш

Ажлын хүснэгт 3.5 Сонирхогч талуудыг эрэмбэлэх нь.

	Албан ёсны шийдвэр гаргагчид	Албан бус шийдвэр гаргагчид	Шахалт үзүүлэгчид
Маш чухал			
Зарим талаараа чухал			
Чухал биш			

“Маш чухал” гэж тодорхойлсон тал нь гол сонирхогч тал бөгөөд тэдэнд үйл ажиллагааны төлөвлөгөө тань чиглэх юм.

“Чухал” өөрчлөлтийг дэмжих эсвэл саад хийх эрх мэдэл, боломж нөхцөлтэй, өөрчлөлтөнд шууд автах буюу аль эсвэл олон нийтийн санаа бодолд маш нөлөөтэй шийдвэр гаргагчид, шахалт үзүүлэгчдийг тэмдэглэнэ.

3.5 Зорилтот бүлгийг тодорхойлох нь

3.5.1. Хэний төлөө өөрчлөлт хийх вэ?

Нийгмийн өөрчлөлтийн төлөө алхам нь хүмүүсийн амьдралд нөлөөлөх, шийдвэр гаргах эрх мэдлээ хуваалцах сонирхолгүй болон өөрчлөлтөөс зайлсхийж буй хүмүүсийн эсэргүүцэлтэй тулгардаг. Хэний төлөө ажиллаж байгаагаа тодруулах нь энэхүү эсэргүүцлийн даван туулахад тусална.

Хэнд өөрчлөлт хэрэгтэй вэ гэдгийг тодорхойлоход анхаарах асуултууд:

- Одоогийн нөхцөл байдлаас хэн хохирол амсаж байна вэ? Тэдний нийгэмд эзлэх байр суурь нь ямар байна вэ? Тэдэнд ямар саад, бэрхшээл тулгарч байна вэ?
- Одоогийн нөхцөл байдлыг хэвээр хадгалахыг хэн хүсэж байна вэ?
- Өөрчлөлтийн үр шимийг нь хэн хүртэх вэ?
- Өөрчлөлт хэнд аюул учруулж болох вэ? Өөрчлөлтийг эсэргүүцэгчид нь хэн байх вэ?

Жишээ 3.5 Зах дээр тэрэг түрдэг хүүхдийн хөдөлмөрийн жишээ

	Хэн хохирол амсаж байна вэ?	➔ Хүүхдүүд хүйтэнд даарч, хүнд ачаа өргөж, эрүүл ахуйн шаардлага хангахгүй нөхцөлд ажилласнаар бэртэж гэмтэх, бусдад зодуулах, доромжлуулах, хичээлээр хоцрох, сургууль завсардах зэргээр хохирч байна.
Одоогийн нөхцөл байдал	Хэн энэ байдлыг хэвээр хадгалахыг хүсэж байна вэ?	➔ Хүүхдийн эцэг эх, ар гэрийнхэнд нь хүүхдийн орлого чухал учраас ➔ Хүүхэд өөрөө гэр орондоо хувь нэмэр оруулж байна гэж үздэг учраас
Өөрчлөлтийн дараа яах вэ?	Өөрчлөлтийн үр шимийг хэн хүртэх вэ?	➔ Хүүхдүүд сургуульдаа явж, хүчирхийлэл дарамтаас хөндийрнө ➔ Тэрэг түрдэг насанд хүрсэн хүмүүст ашигтай. Учир нь тэдний өрсөлдөөн багасна.
	Өөрчлөлт хэнд ямар аюул учруулж болзошгүй вэ?	➔ Хүүхдийн гэр бүлийнхнийг орлогын эх үүсвэргүй болгож болно.

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд нөлөөллийн үйл ажиллагааг шат дараатай тодорхой зорилтот бүлэгт чиглүүлэн хэрэгжүүлэх нь чухал. Ихэнх тохиолдолд “Олон нийт манай зорилтот бүлэг” гэж тодорхойлдог. Гэтэл олон нийт гэдэг нь ерөнхий ойлголт бөгөөд нөлөөллийн үйл ажиллагааны зорилтот бүлэг нь чухам хэн болохыг нарийвчлан тодорхойлох нь үр дүнтэй. Олон нийтийн дундаас нөлөөллийн үйл ажиллагаа илүү чиглэгдэх зорилтот бүлгүүд нь хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд ба тэдний эцэг эхчүүд, ажил олгогчид, бодлого боловсруулах, шийдвэр гаргах нөлөө бүхий албан тушаалтан байна.

Зорилтот бүлгүүдэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа нь тодорхой илгээмж мэдээлэл өгөх үйл явц дээр тулгуурладаг. Тухайн зорилтот бүлэгт тохирсон арга стратегийг ашиглан, тустусаднь тохирсон илгээмж өгөх нь нөлөөллийн ажлыг үрдүнтэй болгоно. Зорилтот бүлэгт тохирсон илгээмжийг хэрхэн үр дүнтэй боловсруулж хүргэх талаар Бүлэг 4-өөс үзнэ үү.

3.5.2. Зорилтот бүлгийн мэдлэг, дадал, хандлагыг хэрхэн тодорхойлох вэ?

Зорилтот бүлгийн мэдлэг, дадал, хандлагыг тодорхойлсны үндсэн дээр хүүхдийн хөдөлмөрийн эсрэг нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь үр дүнтэй. Дараах ажлын хүснэгтийг ашиглан зорилтот бүлгийн мэдлэг дадал хандлагыг тодорхойлж болно.

Чиглүүлэх асуултууд:

- Хүүхэд болон тэдний эцэг эх, ажил олгогчид нь хүүхдийн эрх болон хүүхдийн хөдөлмөрийн талаар ямар ойлголттой байдаг вэ?
- Тэд ямар мэдээлэлтэй байна вэ?
- Тэдэнд ямар мэдээлэл дутагдаж байна вэ?
- Тэдний хандлага юу вэ?
- Тэдний сонирхол юу вэ?



Аргачлал 3.6 Зорилтот бүлэгт үнэлгээ хийх аргачлал

Зорилтот бүлэг	Тэд тухайн асуудлаар ямар мэдлэгтэй байна вэ?	Тэд юуг мэдэхгүй байна вэ?	Тэдний хандлага, үзэл бодол юу вэ?	Тэд юуг сонирхож байна вэ?

Жишээ:3.5

Хүүхдээ хөдөлмөр эрхлүүлж буй гэр бүлүүд хүүхдийн хөдөлмөрийг асуудал гэж үздэггүй, харин тэдний амьдрах нэг арга гэж үзэж буй тохиолдолд:				
Зорилтот бүлэг	Тэд тухайн асуудлаар ямар мэдлэгтэй байна вэ?	Тэд юуг мэдэхгүй байна вэ?	Тэдний хандлага, үзэл бодол юу вэ?	Тэд юуг сонирхож байна вэ?
Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн эцэг эхчүүд	Ажил хийх нь хүүхдэд өөрт нь хэрэгтэй, ур чадвар сурна гэж үздэг.	Хүүхэд хүчирхийлэл, дарамтанд өртдөг,ирээдүйд боловсрол багатай-гаасаа болоод бага цалинтай ажил хийж, ядуу зүдүү амьдарна. Яваандаа эрүүл мэнд нь муудна гэдгийг тэр болгон мэдэхгүй байж болно.	Хүүхдийн хөдөлмөрийг амьдралаа залгах, орлого олох эх үүсвэр гэж үздэг.	Хангалттай орлоготой болох сонирхолтой.
Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд	Бие даасан, ар гэрээ тэжээж байгаа гэж үздэг	Сурч боловсрол эзэмших эрхтэй гэдгээ;эрүүл мэнд биеийн хөгжилд сөрөг нөлөөтэйг мэдэхгүй байж болно	Эцэг эхдээ тусалж, ачийг нь хариулж байгаа хэлбэр гэж үздэг.	

Шигтгээ

Монголын сайн дурынхны нийгэмлэгээс хэрэгжүүлсэн “Үндсэн ордноос алт олборлож, боловсруулж буй хүүхдүүдийг аюултай хөдөлмөрөөс хөндийрүүлэх, орон нутгийнхний ойлголтыг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд 2004 оны хичээлийн жилээс ЕБС-ийн Эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрт “Мөнгөн ус ба түүнээс урьдчилан сэргийлэх нь “ сэдвийг оруулж өгсөн мөн “Мөнгөн ус аюултай “ гэсэн гарын авлагыг хэвлэн гаргаж ЕБС-ийн хичээлд хэрэглэх болсон.

Эх үүсвэр: АЙПЕК .“Сайн туршлага ба сургамж “ номноос ,2006

3.6 Нөлөөллийн стратеги ба тактикаа сонгох нь

3.6.1 Стратеги ба тактик гэж юу вэ?

Стратеги ба тактик нь “юу хийх ёстой” буюу зорилго ба “хэрхэн гүйцэтгэх вэ?” гэдэг асуудлыг цогц байдлаар илэрхийлнэ. Стратеги гэдэг нь зорьж буй өөрчлөлтөнд хүрэхийн тулд ашиглах ерөнхий төлөвлөгөө юм. Стратеги нь тодорхой хугацаанд хийгдсэн судалгаа болон нөхцөл байдлын үнэлгээн дээр тулгуурлан боловсруулагддаг. Харин тактик нь стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга техник юм. Хүсч буй өөрчлөлтөнд хүргэх стратеги ба тактикийг сонгох нь нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хамгийн чухал нөхцөл мөн. Төлөвлөж буй өөрчлөлтөнд хүргэх магадлалыг өндөрсгөх стратегийн загварыг тодорхойлох нь төвөгтэй боловч дийлэнхи тохиолдолд эсрэг хүчнийхэн хэн бэ, ямар нөөц бололцоо байна вэ, эсрэг талынхан өөрчлөлтийг хэр сонирхож, эсэргүүцэж байна вэ гэдгийг харгалзан үзэх шаардлагатай.

Нөлөөллийн үйл ажиллагааны дараах 3 стратеги байдаг. Үүнд:

- Хамтрах стратеги
- Олон нийтийг дайчлан зохион байгуулах стратеги
- Өрсөлдөх стратеги

3.6.2. Хамтрах стратеги

Нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах үед нөлөөлөгчидтэй ижил үнэт зүйлс баримталдаг, санаа зовоож буй олон асуудлаар санал нийлдэг, эсвэл ихэвчлэн хамтарч ажилладаг хувь хүмүүс болон бүлгүүдийн хүрээнд хамтрах стратегийг хэрэглэнэ. Хамтрах үйл ажиллагаа нь мэдээлэл хуваалцах болон эсрэг талаа үндэслэл сайтай, туршилт судалгаанаас авсан мэдээ баримтаар хангах, гэгээрүүлэх, асуудлыг хамтарч шийдэх, ялгаатай үзэл бодол, ойлголтын талаар харилцан зөвшилцөн, хамтын хүчин чармайлтын үр дүнд нөлөөллийн зорилгодоо хүрэхэд чиглэнэ.

Хамтрах стратеги:

- Ажлын хэсэг буюу дэд хороодыг бүрдүүлэх
- Эсрэг талтайгаа тогтмол харилцаатай байх
- Семинар уулзалт зохион байгуулах
- Баримт мэдээний хүснэгтүүд болон боломжит хувилбаруудыг санал болгох

Шигтгээ

Цагдаагийн Ерөнхий Газрын (ЦЕГ) Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэсээс хэрэгжүүлсэн “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдтэй тэмцэх цагдаагийн ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд ЦЕГ, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн академийн төлөөлөл бүхий ажлын хэсэг МУ-ын “Садар самуунтай тэмцэх” тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахыг хориглосон хэд хэдэн заалт бүхий хуульд нэмэлт өөрчлөлт хийх саналыг боловсруулан ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

Эх үүсвэр: АЙПЕК.” Сайн туршлага ба сургамж” номноос, 2006

3.6.3. Олон нийтийг дайчлан зохион байгуулах стратеги

Нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах явцад асуудлын талаар нөлөөлөгчтэй цөөн зүйл дээр л санал нийлдэг, нийтлэг үнэт зүйлс багатай хувь хүмүүс болон олон нийттэй ажиллах шаардлага түгээмэл тохиолддог. Ийм нөхцөлд нөлөөлөгчид олон нийтийг дайчлан зохион байгуулах стратегийг хэрэглэх нь зохимжтой байдаг. Энэхүү стратеги нь итгүүлэх, ятган ухуулах замаар эсрэг талын баримталдаг байр суурь, үнэт зүйлсийг өөрчлөхөд чиглэдэг.

Олон нийтийг зохион байгуулах стратеги

- Шийдвэр гаргагчдыг лоббидох
- Олон нийтийг сургах
- Хэвлэл мэдээлийн хэрэгсэлтэй ажиллах
- Захидал бичих аян зохион байгуулах
- Агентлагууд болон шийдвэр гаргагчдыг хянах
- Хамтын ажиллагаа
- Эсрэг талын эвсэлтэй харилцаа холбоо тогтоох

Олон нийтийг дайчлах үндсэн зарчмууд:

- Тухайн асуудалд нөлөө үзүүлж байгаа хүмүүсийг оролцуулах
- Юунд хүрэх гэж байгаагаа оновтой тодорхойлох
- Үйл ажиллагаандаа хэрэглэх аргаа нягт нямбай сонгох
- Оновчтой томьёолсон илгээмжтэй байх
- Хялбар үйл ажиллагааг илүү дэмжих
- Үйл ажиллагааг хөгжилтэй байдлаар зохион байгуулах/ марш, багт наадам г.м
- Хүчирхийллээс зайлсхийх

Шигтгээ

Тэгш мөр ТББ-аас зах дээр хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахын тулд захын удирдлага, зах дээр худалдаа эрхэлдэг хүмүүст хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар ойлголт мэдлэгийг дээшлүүлэх нөлөөллийн үйл ажиллагаа явуулан хүүхдээр ачаа зөөлгөх, хөдөлмөр хийлгэхдээ хөнгөлөх нөхцөлүүдийн талаар хэлэлцэн зөвшилцөлд хүрч зах дээр ажиллагсдын хөдөлмөрийн гэрээнд холбогдох заалтуудыг тусгуулсан байна.

Эх үүсвэр: Тэгш мөр ТББ-ын үйл ажиллагааны танилцуулгаас

3.6.4. Өрсөлдөх стратеги

Нөлөөллийн асуудлын талаар нийтлэг үнэт зүйл байхгүй, илэрхий санал зөрдөг, эрх мэдлээ хуваалцах дургүй хувь хүмүүс болон бүлгүүдтэй ажиллах үед өрсөлдөх стратегийг хэрэглэдэг. Нөлөөлөгчид нь эсрэг талынхаа зан үйл, хандлагыг өөрчлөхийг зорьдог. Тэд улс төрийн болон олон нийтийн шахалт, эсрэг талынхны байр суурийг эсэргүүцэх, хууль эрх зүйн баримт бичгийг биелүүлэхийг шаардах зэрэг аргыг хэрэглэдэг. Өрсөлдөх стратегийг хэрэглэх нь зарим тохиолдолд нөлөөллийн үйл ажиллагаанд оролцогчдыг аюултай байдалд оруулж болзошгүй гэдгийг анхааралдаа авч эрсдлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай.

Өрсөлдөх стратеги:

- Томоохон жагсаал цуглааныг зохион байгуулах
- Иргэний хөдөлгөөн ба идэвхгүй эсэргүүцлийг зохион байгуулах
- Хуулийн үйл ажиллагааг эхлүүлэх
- Ажил хаялт, суулт, хориг эсэргүүцлийн бичиг зэргийг зохион байгуулах
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэр төрд нь халдах
- Зууч буюу зохицуулагчийг эрж хайх

Шигтгээ

АЙПЕК-ийн олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, нийгмийн хүчийг дайчлах чиглэлээр хэрэгжүүлдэг 3 том санаачилгын тухай танилцуулъя.

АЙПЕК-ийн гурван чухал санаачилга**Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх дэлхийн өдөр**

ОУХБ-аас жил бүрийн 6-р сарын 12-ны өдрийг хүүхдийн хөдөлмөрийг нэн даруй устгах хэрэгцээ шаардлагад бүх дэлхийн анхаарлыг хандуулах зорилгоор “Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх дэлхийн өдөр” хэмээн сонгосон юм. Энэ өдөр нь хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдэд туслах, хүүхдийн хөдөлмөргүй дэлхий ертөнцийг бий болгохын төлөө ажиллаж буй хүмүүсийг алдаршуулах өдөр болдог. Энэ өдрөөр дэлхий даяар олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулагддаг ба тухайлбал хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд, тэдний найз нөхдийг хамруулсан уулзалтаас эхлээд сургуулиуд дээр хүүхдийн гар урлалын үзэсгэлэн гаргах, жүжигчилсэн тоглолт хийх, хүүхэд-томчуудын мэдээлэл солилцох уулзалт, ажиллагсад болон ажил олгогчдоос зохион байгуулах үйл ажиллагаа, хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа гэх мэт төрөл бүрийн үйл ажиллагааг зохион явуулдаг.

Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх дэлхийн өдөр-Монголд

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг Дэлхийн өдөр нь ухуулга сурталчилгааны чухал хэрэгсэл болдог. Ээлжит Дэлхийн өдөр бүрийг хүүхдийн хөдөлмөрийн тодорхой асуудалд тусгайлан чиглүүлж иржээ. Монгол улсад жил бүрийн 6 сарын 12-ны Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг Дэлхийн өдрийг 2004 оноос хойш тэмдэглэж байна.

2004 онд – “Хүүхэд насыг хүнд хөдөлмөрт бус хөгжилд зориулъя” уриан дор,

2005 онд – “Уул уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийг халъя” уриан дор

2006 онд – “Хүүхдийн хөдөлмөрийг устгах: Хүрч болохуйц зорилт” Хөдөлмөрийн хүрээний суурь зарчмууд, эрхийн тухай ОУХБ-ын Тунхаглалын мөрөөр бэлтгэсэн Дэлхийн илтгэлийг танилцуулах зорилгоор

2007 онд- “Хөдөө аж ахуй дахь хүүхдийн хөдөлмөрт анхаарлаа хандуулъя” уриан дор,

2008 онд – “Боловсрол- Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг хамгийн зөв шийдэл” уриан дор тус тус тэмдэглэв.

SCREAM
(Боловсрол, Урлаг, Хэвлэл Мэдээллээр Дамжуулан
Хүүхдийн Эрхийг Дэмжих нь)

2002 оны хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх дэлхийн өдрөөр ОУХБ-аас “SCREAM –Хүүхдийн хөдөлмөрийг зогсоо” нэртэй боловсрол олгох, нийгмийн хүчийг дайчлах шинэ санаачилгыг гаргасан. SCREAM нь Боловсрол, Урлаг, Хэвлэл Мэдээллээр Дамжуулан Хүүхдийн Эрхийг Дэмжих гэсэн үгний эхний үсгүүдээс бүрддэг. SCREAM нь жүжигчилсэн тоглолт, зохион бичлэг, зураг зэрэг сургалтын аргыг ашиглан хүүхэд залуучуудад хүүхдийн хөдөлмөрийн асуудалтай холбоотой цогц асуудлуудыг ойлгуулан тэдгээрийг бүтээлчээр шийдэх арга замыг нээн илрүүлэхэд нь тусалдаг. Ийм урлагын авъяастай хүүхдүүд өөрсдийн олж авсан мэдлэгээ олон нийтэд түгээх боломжтой юм. SCREAM-ээс гаргасан боловсролын багц нь 14 модуль, Ашиглах заавар, фото зурагтай СД багтдаг бөгөөд энэхүү санаачилгын талаар үндсэн мэдээллийг авч болно. Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.ilo.org/childlabour> -аас авна уу.

“Хүүхдийн хөдөлмөрт улаан карт өгье” компанит ажил

АЙПЕК-аас Африкийн хөл бөмбөгийн холбоотой хамтран 2002 онд Мали-п болсон Африкийн хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээний үеэр хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүдэх зорилготой компанит ажлыг зохион байгуулсан. Энэхүү компанит ажил нь “хүүхдийн хөдөлмөрт улаан карт өгье” гэсэн шууд илэрхийлсэн, энгийн илгээмжтэй байсан нь хөл бөмбөг сонирхдог хүн бүр маш ойлгомжтой байжээ. Энэхүү компанит ажил нь видео, дуу хөгжим, зураг гэх мэт төрөл бүрийн сурталчилгааны материалыг телевиз, радио, олон улсын нислэг, хөлбөмбөгийн тэмцээнээр дамжуулан цацсан нь Африкийн болон дэлхийн сая сая хүмүүст хүржээ. Энэ үйл ажиллагааг Африкийн 21 оронд зохион байгуулсан ба Кени улсад л гэхэд 12 сая хүн, Замбиад 5 сая хүнд хүрсэн гэсэн мэдээ байна. Египет, Гана гэх мэт Африкийн зарим улс оронд энэхүү үйл ажиллагааг цаашид явуулах тэмцээн, уралдаан болон олон нийтийн үйл ажиллагааны үеэр явуулж байхаар болсон байна.

Энэ үйл ажиллагаа нь амжилттай болсон учраас үүнийг цаашид үргэлжлүүлэх төлөвлөгөөнүүд гарсан. Тухайлбал 2002 онд болсон Мадридийн 100 жилийн ой, Жинхэнэ Мадридийн төлөө жагсаалын нэг хэсэг болгон зохион байгуулсан байна. Цаашидаа Дэлхийн хөл бөмбөгийн залуучуудын аварга шалгаруулах тэмцээн, Азийн хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн, Дэлхийн хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээний үеэр энэ ажлыг зохион байгуулах болсон байна.

Эх үүсвэр: ОУХБ. Хүүхдийн хөдөлмөр : Их дээд сургуулийн оюутнуудад зориулсан сурах бичиг. УБ 2007

3.6.5 Сонирхогч талуудтай ажиллах стратеги тактикийг сонгох аргачлал

Дараах ажлын хүснэгтийг ашиглан хамтран ажиллах боломжтой сонирхогч талууд буюу байгууллага, хүмүүстэй хэрхэн ажиглах арга стратегиа сонгож болно.



Аргачлал 3.7. Түншлэгчидтэйгээ ажиллах тактикийг тодорхойлох нь:

Түншлэгч байгууллагын нэр	Тэдний гол нөлөө	Хандлага ба гол сонирхол	Хамтарч ажиллах тактик



Аргачлал 3.8 . Эсэргүүцэгчидтэй ажиллах тактикийг тодорхойлох нь:

Эсэргүүцэгчийн нэр	Тэдний нөлөө	Гол сонирхол	Сааруулах тактик

3.7 Нөлөөллийн ажлын төлөвлөгөө боловсруулах нь

3.7.1 Бид ямар ажлын төлөвлөгөөтэй байх вэ?

Урт хугацааны үйл ажиллагаанд зохион байгуулалттай арга хэмжээ үр дүнтэй байдаг. Ажлын төлөвлөгөө нь үйл ажиллагаа, тусгай үүрэг даалгавар, шаардлагатай нөөц боломж, гүйцэтгэж дуусах цаг хугацаа зэргийг багтаадаг.

Ажлын төлөвлөгөө боловсруулахдаа дараах зүйлсийг анхаарна уу.

- ➔ Бид ямар үйл ажиллагаа хэрэгжүүлэх вэ?
- ➔ Үйл ажиллагаа хэрэгжүүлэхийн өмнө ямар алхам буюу үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэрэгтэй вэ?
- ➔ Байгууллагын үйл ажиллагааны хүрээний хаана нь бид байна вэ? Бид ямар нэг тодорхой ажил явуулахаасаа өмнө өөрсдийн чадавхи, нөөцийг бий болгох хэрэгтэй юу?
- ➔ Өөрчлөлт хэрхэн явагдаж байна вэ? Шийдвэр гаргах үйл явцад хүмүүсийн оролцоог хангах боломж, бололцоо хэр байна вэ? Эсвэл ийм боломжийг бий болгохын тулд бодлогод тодорхой өөрчлөлт хийх нөлөөллийн ажлаасаа өмнө өөр үйл ажиллагаа явуулах хэрэгтэй юу?
- ➔ Хэлэлцэж буй асуудлыг авч үзэх хүрээний хаана нь бид байна вэ? Бид тодорхой шийдвэр, хувилбарыг санал болгохоос өмнө олон нийтийн баталгаа, нотолгоог бий болгох хэрэгтэй юу?
- ➔ Үйл ажиллагаа тус бүрийн хувьд дараах зүйлсийг тунгаан бодох хэрэгтэй. Үүнд:
- ➔ Холбогдох ямар үүрэг даалгавар байна вэ?
- ➔ Ямар нөөц хэрэгтэй байна вэ?
- ➔ Хэн хийх вэ?
- ➔ Аливаа үүрэг даалгавар тус бүр бодитой цаг хугацаанд төлөвлөгдсөн үү? Хэрвээ тийм бол ямар хугацаанд гүйцэтгэх хэрэгтэй вэ?
- ➔ Үйл явцын үр дүнг хэзээ үнэлж болох вэ?

3.7.2 Үйл ажиллагаа эхлэхэд шаардлагатай зүйлс бидэнд байна уу?

Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь танай бүлгийн чадвар эвсэл холбооны хүчин чадавхиас шалгаална. Үйл ажиллагаагаа эхлүүлэхээсээ өмнө дараах асуултыг тунгаан бодно уу. Үүнд:

- Үйл ажиллагаа эхлэхэд шаардлагатай зүйлс бидэнд байна уу? Ямар нэг зүйл дутагдаж байна уу?
- Бидэнд хэрэгтэй зүйлийг хэрхэн олж болох вэ?
- Бид хэнтэй хамтарч ажиллах хэрэгтэй вэ? Бүлэгт тулгарсан төвөгтэй асуудлыг шийдвэрлэхэд хэнд ямар давуу тал байна вэ?
- Хэлэлцэж буй асуудлын талаар байр сууриа хадгалах ба үр дүнтэй мэдээлэл түгээхэд нэмэлт мэдээлэл шаардлагатай юу?

3.7.3 Нөлөөллийн ажлын төлөвлөгөө боловсруулах аргачлал

Ажлын төлөвлөгөө боловсруулахдаа үйл ажиллагаа, гүйцэтгэх үүрэг даалгавар, шаардагдах боломж нөөц, ажиллах хүн хүч ба тогтоосон хугацаагаа нарийвчлан төлөвлөнө үү. Бусад үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхийн өмнө зарим нэг алхам болон үйл ажиллагаа хэрэгтэй эсэхийг дахин нэг нягтална уу.



Аргачлал 3.9 Нөлөөллийн ажлын төлөвлөгөө боловсруулах нь

Бидний хийх үйл ажиллагаа ба холбогдох арга хэмжээ	Яагаад бид үүнийг хийх гэж байна вэ?	Гүйцэтгэх үүрэг даалгавар	Шаардагдах нөөц	Хэн хийх	Эхлэх ба дуусах хугацаа



Аргачлал 3.10

НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ ЗАГВАР

Нөлөөлөх үндсэн асуудал:

Нөлөөллийн зорилт:

Үйл ажиллагаа	Шаардагдах нөөц	Хариуцах хүмүүс	Хугацаа

3.7.4 Хөрөнгө өсгөх аргууд

Нөлөөллийн үйл ажиллагааг явуулахад цаг хугацаа, идэвх санаачилгаас гадна хөрөнгө мөнгө их шаардагддаг. Иймд нөлөөлөгчдөд хөрөнгө мөнгө өсгөх үйл ажиллагааны талаар мэдлэг чадвартай байх хэрэгцээ тулгарна.

Хөрөнгө өсгөх олон аргууд байдаг. Үүнд:

- ➔ Гишүүдээсээ мөнгө цуглуулах
- ➔ Мөнгөн бус туслалцаа авах(техник тоног төхөөрөмж , ажиллах хүчний г/м)
- ➔ Үзэсгэлэн худалдаа, оройн хоол, кино үзүүлэх г/м арга хэмжээг зохион байгуулж хөрөнгө өсгөх
- ➔ Хувь хүнээс хандив тусламж авах
- ➔ Хандивлагч байгууллага хайх
- ➔ Өөрсдийн бүтээсэн гар урлалын зүйлээ худалдах
- ➔ Төсөл хэрэгжүүлэх
- ➔ Тэмдэглэлт өдрийг ашиглан хандивлагч хайх
- ➔ Өөрсөддөө байгаа зүйлийг худалдах(бэлэг дурсгалын зүйл, ном г/м)
- ➔ Өөрсдийн хэвлэн гаргадаг сонин болон хэвлэл дээр зар байрлуулах

IV БҮЛЭГ

ЗОРИЛТОТ БҮЛЭГТ НӨЛӨӨЛӨХ СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛ БОЛОВСРУУЛАХ НЬ

БҮЛГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- 4.1 Зорилтот бүлэгт тохирсон илгээмж боловсруулах аргачлал**
- 4.2 Мэдээллийн хэрэгслээ сонгох нь**
- 4.3 Мэдээллийг хүмүүст ойлгомжтойгоор илэрхийлэх зарим аргууд**

4.1. Зорилтот бүлэгт тохирсон илгээмж боловсруулах аргачлал

4.1.1. Илгээмж гэж юу вэ?

Нөлөөллийн ажлын гол цөм бол зорилтот бүлэгт чиглэсэн гол мэдээлэл буюу илгээмжийг тодорхойлох явдал бөгөөд энэ нь нөлөөллийн үйл ажиллагаа амжилттай болоход чухал ач холбогдолтой. Нөлөөллийн баг нь зорилтот бүлгийнхээ мэдлэг, хандлага, ойлголт, хэрэгцээний талаар сайтар судалснаар нөлөөллийн ажлаа тэдэнд тохируулан боловсруулан хэрэгжүүлэх боломжтой болно.

Тодорхой санаа дэвшүүлсэн, цөөн тооны үгээр илэрхийлэгдсэн, товч тодорхой гол дамжуулах мэдээлэл мэдэгдлийг нөлөөллийн илгээмж гэж тодорхойлж болно.

Илгээмж нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- ➔ Асуудлыг задлан шинжилсэн үнэлгээ
- ➔ Асуудлын учир шалтгаан
- ➔ Асуудал шийдэх хариуцлагыг хэн хүлээх тухай
- ➔ Хэрэв танд асуудлыг шийдэх талаар санал байгаа бол санал болгож буй шийдэл
- ➔ Тухайн шийдлийг дэмжих талаар бусдаас хүсч буй үйл ажиллагаа зэрэг багтана.

Тодорхой нэг зорилтот бүлэгт зориулан боловсруулагдсан илгээмж нь захиалгат илгээмж бөгөөд дараах дүн шинжилгээнд үндэслэдэг.

- ➔ Тухайн сонирхогч талд хамгийн их итгэл төрүүлэх зүйл юу байж болох вэ?
- ➔ Тэд ямар мэдээлэл сонсох хэрэгтэй вэ?
- ➔ Тухайн сонирхогч тал ямар үйл ажиллагаа явуулаасай гэж та хүсч байна вэ?

Илгээмжийн жишээ:

Таны хүү айлд мал маллаж байна.

Хүүхэд сурч боловсрох эрхтэй ба хүүхдийг боловсролд хамруулах нь эцэг эх бидний үүрэг билээ. Хэрэв таны хүүхэд сургуульд сурахгүй, мал малласаар байх юм бол тэр ирээдүйд боловсролгүй ажилгүй хүн болж гэр бүлийнхээ амьдралд хувь нэмэр оруулж чадахгүй байх болно. Тиймээс бидний ирээдүй болсон хүүхдээ сургуульд суралцуулж тэднийхээ төлөө өөрсдөө хөдөлмөрлөн зүтгэхийг танаас хүсч байна.

Эх үүсвэр: Дорнод аймагт явагдсан хүүхдийн ажилтнуудын сургалтанд оролцоогчид (2007 оны 11 сар)

4.1.2. Илгээмж боловсруулах үндсэн зарчмууд

Нөлөөллийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулахын тулд нэн түрүүнд анхаарал хандуулах шаардлагатай мэдээлэл боловсруулах дараах үндсэн зарчмууд байдаг. Үүнд:

- Энгийн байх
- Асуудлыг тодорхой хүрээнд авч үзэх
- Зорилтот бүлгийн мэдлэг, зан үйл, хандлагад тохируулсан байх
- Боломжит шийдэл санал болгох
- Илгээмж боловсруулахдаа зорилтот бүлгийг оролцуулах

А. Энгийн байх

Энэ нь дамжуулж буй мэдээллийг хүлээж авахад хялбар, үл мэдэх нэр томъёо хэрэглэхгүй, харьцангуй богино, эмх цэгцтэй илэрхийлнэ гэсэн үг юм.

Танай бүлгийн тогтмол хэрэглэдэг “тогтвортой хөгжил” эсвэл “орчны арьс өнгөөр ялгаварлах байдал” гэх мэтийн хэллэг нь олон нийтийн хувьд танил бус байж болно. Иймэрхүү хэллэгийг олон нийтийн хэлэлцүүлэгт анх удаа танилцуулахдаа байнга давтан тайлбарлах хэрэгтэй болно.

Мөн таны илгээмж болох тухайн асуудлын талаарх таны баримталж буй байр суурийг тайлбарлах эсвэл эсрэг талынхаа байр суурьтай сөргөлдүүлэн тавих зорилготой биш гэдгийг бодож явах нь зүйтэй. Илгээмж нь энгийн байх тусам сонирхогч тал тань илүү хурдан ойлгож, хүлээж авах болно. Мөн хүмүүс илгээмж ойлгож авахын тулд дахин дахин сонсох хэрэгтэй байдаг.

Б. Асуудлыг тодорхой хүрээнд авч үзэх

Асуудлыг тодорхой хүрээнд зааг ялгаатай авч үзэх гэдэг нь нэг ёсны асуудлын хил хязгаарыг тогтоож асуудлын зарим хэсгүүдийг тодотгож, үлдсэн хэсгийг нь хойш тавьж дараа хэлэлцэх, эсвэл бүр орхигдуулах хэрэгтэй болно гэсэн үг юм. Эдгээр нь сонирхогч талуудад тухайн асуудлын талаар хэнд хандах, хэн хариуцах, түүнчлэн боломжтой шийдлүүд юу байж болох зэргийг тогтооход нөлөө үзүүлдэг.

Сургамжтай жишээ:

1996 онд Колорадо мужийн Дэнвер хотод Шинэтгэлийн төлөө олон нийтийн байгууллагуудын холбоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэхийн төлөө компанит ажил болон аян зохион байгуулжээ. Энэхүү аян амжилтгүй болсон гол шалтгаан нь үр өгөөжтэй, хүмүүст нөлөөлөхүйц мэдээлэл боловсруулж чадаагүй явдал байв...

Өөр нэг алдаа бол тус аян нь хэт өргөн хүрээг хамарсан мэдээ ашигласан явдал байв. Тэд “хэрэв та ажиллаж байвал ядуу байх ёсгүй” гэдэг тодорхойлолтоос эхлээд “Статистикийн судалгаагаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлснээр ажилгүйдлийг нэмэгдүүлдэггүй” гэсэн мэдээг хүртэл хамруулан өргөн асуудал хөндөж байв. Хэдийгээр тэдний нотолгоо бүгд үнэн боловч аль нь ч дангаар тодорхой сайн томъёологдож чадаагүй байв...

Нийгмийн Хөгжлийн Төв. Нөлөөллийн ажлын арга зүй цуврал, 2006 он.

В. Зорилтот бүлгийн мэдлэг, хандлага, зан үйлд тохируулсан байх

Та зорилтот бүлгийнхээ талаар хэдий чинээ их мэдэх тусам, тэдний сэтгэл зүрхэнд хүрч чадахуйц мэдээг илүү сайн боловсруулах ба зорилтот бүлгийнхээ мэдлэг, үнэт зүйлс, итгэл үнэмшил, сэтгэл санаа, хэрэгцээ болон таамаглалд тохируулж болно. Сонирхогч талын бодож байсан зүйлтэй давхцсанаар “голыг нь олсон” мэдээг сонирхогч талынхан чинь хүлээж авч түргэн шуурхай зөвшөөрөх магадлал нь өндөр болно. Сонирхогч талын талаар илүү сайн мэдэхийн тулд тэдний мэдлэг, үнэт зүйлс ба итгэл үнэмшил, сэтгэл санаа, хэрэгцээ болон анхаардаг зүйлсийн талаар бодох хэрэгтэй болно. Үүнд дараах асуулт таньд тус болно:

- Мэдлэг: Сонирхогч талын тань мэдэхгүй боловч түүний байр суурийг өөрчилж болох ямар нэг зүйл байж болох юу? Таны мэдээлэлд олон нийтийн боловсролын асуудалд анхаарсан гэж бодъё. Энэ тохиолдолд боловсролын талаар сэтгэл хөндсөн баримт буюу харьцуулалтууд сонирхогч тал тань өөрийн байр сууриа эргэн харах шалтгаан болж болно.
- Үнэт зүйлс ба итгэл үнэмшил: Сонирхогч тал ямар үнэт зүйлсийг хамгийн их эрхэмлэдэг вэ?
- Сэтгэл санаа мэдрэмж: Сонирхогч талыг тань юу уярааж, юу сэтгэлийг нь өвтгөж, эсвэл дургүйцэхэд хүргэдэг вэ?
- Хэрэгцээ болон нэн тэргүүнд хийх зүйлс: Сонирхогч тал юунд илүү анхаарч санаа тавьдаг вэ? Ямар учраас? Асуудлын талаар таны баримталж буй байр суурь тэдний айдсыг намжаахад туслах уу?

Г. Тодорхой боломжит шийдэл санал болго

Судалгаанаас үзэхэд хүмүүс асуудлын шалтгаанд анхаарал хандуулахыг уриалсан илгээмжээс илүүтэйгээр тодорхой шийдлүүд санал болгосон мэдээлэлд анхаарал илүү хандуулдаг байна.


Д. Илгээмж боловсруулахдаа зорилтот бүлгийг оролцуул

Шварц өөрийн “Оновчтой илгээмж” онолоор илгээмжинд хандах хандлагыг нэг алхам урагш ахиулсан юм. Энэ онолын дагуу сонирхогч талаас анхаарал татсан тухайн асуудлын талаар санал бодлыг нь асууж энэ талаар бодох үйл явцыг идэвхжүүлснээр сонирхогч тал мэдээг хүлээж авах буюу мэдээтэй санал нийлэх магадлал нь өндөр болох нь тогтоогджээ.

4.1.3. Илгээмж боловсруулах аргачлал

Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар нөлөөллийн ажлыг явуулахад өөр өөр сонирхолтой бүлгүүдэд мэдээллийг түгээх шаардлага гардаг. Эдгээр мэдээ мэдээллийг нөлөөллийн үйл явцын янз бүрийн шатанд сонирхогч тал тус бүрийн хэрэгцээ сонирхолд зориулан боловсруулдаг. Мэдээлэл дамжих схемээс илгээмж хэрхэн дамжих арга зам, ямар хүчин зүйлийг тооцох хэрэгтэйг харж болно.

Мэдээлэл дамжих схем:



Аргачлал 4.1 Нөлөөллийн илгээмж боловсруулах аргачлал

Зорилтот бүлэгт хүргэх илгээмжийг боловсруулахдаа дараах ажлын хүснэгтийг ашиглаж болно.

Илгээмж боловсруулах чиглэл:

- ➔ Асуудал/Юу хэлэхийг зорьж байгаа
- ➔ Баримт Нотолгоо
- ➔ Жишээ, түүх
- ➔ Юуг санал болгож байгаа

Ажлын хүснэгт 4.1 Нөлөөллийн илгээмж боловсруулах аргачлал :

Асуудал/ Юу хэлэхийг зорьж байгаа	Баримт Нотолгоо	Жишээ, түүх	Юуг санал болгож байгаа

Жишээ:

Асуудал: Хүүхдийг гэрийн үйлчилгээнд ажиллуулах зорилгоор зөөвөрлөх асуудлыг үл хайхарснаас хүүхдүүд хохирох нь элбэг байна. Иймээс энэ үйлдлийг зогсоох ёстой.

Баримт нотолгоо: Филиппинд 3 өдөр тутам 1 хүүхдийг өөр газар луу зөөвөрлөж байгаа бөгөөд 6 минут тутам нэг хүүхэд ажил олгогч эзэндээ зодуулж байна.

Жишээ, түүх: Манай байгууллагын үйлчилгээнд хамрагдаж байсан нэгэн охинд ийм явдал тохиолдсон юм. Түүний нэг таньдаг хүн нь хотод очиж 3000 песогийн цалинтай рестораны үйлчлэгч хийх үү гэхэд нь тэрээр зөвшөөрчээ. Харин түүнийг хотод ирэхэд нь ресторан дампуурч байгаа учраас нэгэн айлд гэрийн үйлчлэгч хийлгэжээ. Түүнд сард 800 песо төлнө гэж амласан боловч ямар ч мөнгө төлөөгүйгээр барахгүй өдөрт 20 цаг ажилуулж, зодож, хэл амаар байнга доромжилдог байснаас оргон зугтаж манай байгууллагад хүргэгдэн ирсэн юм. Ийм түүх өнөөдөр мянга мянган хүүхдэд тохиолдож байна.

Юуг санал болгож байна. Хүүхдийг гэрийн үйлчилгээнд ажиллуулж буй өрх, ажил олгогчийг хотын захиргаанд бүртгүүлж байхыг шаардсан хууль, тогтоомж гаргах шаардлагатай. Тэгвэл тэдний хөдөлмөрийн нөхцөлийг хянах боломжтой болох юм. Харин хууль зөрчигчдөд хатуу арга хэмжээ авах ёстой.

Орон нутгийн засаг захиргаанаас хүүхдийг гэрийн үйлчилгээнд ажиллуулах асуудлаар зөрчил гарсан, хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд мэдээлэх яаралтай утас болон

хүүхдэд үйлчилгээ үзүүлэх төвүүдийг бий болгох, хүүхдэд үйлчлэхэд бэлэн байлгах асуудлыг хариуцах ёстой.



Аргачлал 4.2 Зорилтот бүлэгт чиглэсэн нөлөөллийн илгээмж боловсруулах нь

Ажлын хүснэгт: 4.2

Асуудал:	Уул уурхайд ажиллаж буй хүүхдүүд боловсролд хамрагдах боломжгүй байна.
Зорилго:	Уул уурхайд ажилладаг бүх хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулах
Зорилт:	Сонгож авсан 3 хороо/багт оройн цагаар хичээллэдэг сургалт зохион байгуулах
Хэнд зориулсан:	Аль нэгийг нь сонгоно уу: ➔ Гэрийн үйлчлэгч хүүхдүүд ➔ Тэднийг ажилуулагч, ажил олгогчид ➔ Эцэг эх/олон нийт ➔ Засаг захиргаа
Тэдэнд юу хийхийг уриалж байгаа	
Илгээмжийн товч агуулга	
Илгээмжийг түгээх хэрэгсэл	
Түгээх цаг хугацаа ба байршил	

4.1.4. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах чиглэлээр мэдээллүүд

Хүүхдийн Төлөө Үндэсний Зөвлөлөөс 2007 онд батлан гаргасан Хүүхдийн хөдөлмөрийн нөлөөллийн стратегид өгөгдсөн сургалт сурталчилгааны гол мэдээллийг танилцуулъя.

Хүснэгт: 4.1 Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, хүүхдийн хөдөлмөрийн зарим асуудлын талаарх сургалт, сурталчилгааны гол мэдээлэл

АСУУДАЛ	ГОЛ МЭДЭЭЛЭЛ
Хүүхдийн хөдөлмөр	- Хүүхдийн хөдөлмөр, түүний тэвчишгүй хэлбэрүүдийн талаарх олон улсын конвенц, эрх зүйн баримт бичиг, Монгол Улсын хууль тогтоомжийг таниулах; - Хүүхэд бүр суурь боловсрол эзэмших, хуулиар зөвшөөрсөн насанд хүрсэн үед хөдөлмөрийн гэрээтэй ажиллах, ажлын хөлс, урамшуулал нь хийсэн ажилд нь тохирсон, ажлын цаг нь хуулиар тогтоосон хэмжээнд байх, амь нас эрүүл мэнд, ёс суртахуунд нь сөрөг нөлөө үзүүлэх ажил эрхлэх ёсгүйг сануулах; - Хүүхдээр тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлүүлж байгаа аж ахуйн нэгж, иргэн, эцэг эхэд буруутай үйл ажиллагааг ухааруулах, сануулах, дутагдлаа давтан гаргахгүй байхыг анхааруулах, удаа дараа дутагдал давтагдвал бизнесийн нэр хүндэд халдахыг сануулах; (Эдгээр гол мэдээллийг хүүхдийн хөдөлмөрийн талаарх аливаа сургалт, сурталчилгааны ажлын үед зайлшгүй суурь болгон өгвөл зохино)
Хүүхдийн бэлгийн мөлжлөг	- Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэд бол гэмт хэрэгтэн биш, харин хохирогч гэдгийг ойлгуулах; - Хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс хамгаалахын тулд хуулийн хариуцлагыг оновчтой тодорхойлох, хууль сахиулах, гэмт хэрэгтнүүдтэй тэмцэх, гэм буруутай хүнд хуулийн зохих хариуцлагыг оногдуулах нь нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ шаардлагатайг онцлох; - Бэлгийн мөлжлөг нь хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл санаанд хүнд хохирол, үр дагавар учруулдаг тул хүүхдийг нөхөн сэргээх чанартай үйлчилгээг зайлшгүй үзүүлэх ёстойг ойлгуулах; - Охид, эмэгтэйчүүдийг дамжуулан худалдах, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, тэдэнд эрсдэлийг таниулахын тулд айлган сүрдүүлэх биш, харин ухуулга шийдвэр гаргахыг ойлгуулах нь хамгийн үр дүнтэйг таниулах; - Хүүхэд эмэгтэйчүүдийг зөвхөн бэлгийн мөлжлөгийн зорилгоор биш хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор дамжуулан худалдах эрсдэл байдгийг ч бас анхаарах шаардлагатайг таниулах.
Уул уурхай дахь хүүхдийн хөдөлмөр	18 нас хүрээгүй хүүхдийн ил, далд уурхайд хийх аливаа ажил нь “аюултай” ажилд багтах тул хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт тооцогдохыг тайлбарлах; - Уурхайд ажиллаж байгаа хүүхдүүд гэмтэж, хөгжлийн бэрхшээлтэй болж, амь насаа алдаж байгааг, мөн алтны үндсэн ордод ажиллаж байгаа иргэд, тэдний хүүхдүүд мөнгөн усны хурц болон архаг хордлогод орох, эрүүл мэндээ нөхөж баршгүйгээр хохироох эрсдэлтэй нөхцөлд ажиллаж, амьдарч байгааг таниулах; - Уурхайд эцэг эхтэйгээ хамт ажиллаж байгаа бага насны олон мянган хүүхэд уурхайн орчимд хортой, хүнд нөхцөлд амьдарч байгаад анхаарал хандуулах шаардлагатайг ч мөн онцлох.

Албан бус хэвшил дэх хүүхдийн хөдөлмөр	• Худалдаа, үйлчилгээний газар, бараа, хүнсний зах, түүний орчим болон гудамж, талбай, автобусны зогсоол, хог хаягдлын цэг дээр, эсхүл бүртгэлгүй, жижиг аж ахуйд хөдөлгөөнт хэлбэрээр, эсхүл ажлын тогтсон байранд ажиллаж байгаа хүүхдүүд албан бус хэвшилд ажиллаж байгаа хүүхдэд тооцогдохыг тайлбарлах; • Албан бус хэвшилд хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн дотор бага насны хүүхдийн эзлэх хувь өндөр байгаа тул тэдэнд нэн түрүүнд анхаарлаа хандуулахыг ойлгуулах; • Албан бус хэвшилд хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүд эцэг эхтэйгээ хамт ажиллах нь түгээмэл тул эцэг эхийн ухамсрыг нь дээшлүүлэхийг чухалчлах; • Албан бус хэвшилд ажиллаж байгаа хүүхдүүдийн, ялангуяа ахлах насны хүүхдийн хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хүүхдүүдийг гэмт урьдчилан сэргийлэх хэрэгцээг ойлгуулах; • Албан бус хэвшилд ажиллаж байгаа охид бэлгийн мөлжлөгт өртөх эрсдлийг таниулах.
Айлд мал маллаж, гэрийн үйлчлэгч хийх, хийж буй хүүхдүүд	• Хөдөө аж ахуйн салбар нь хамгийн олон тооны хүүхэд ажилладаг, нуугдмал, хөдөлмөрийн хүнд нөхцөлтэй, зохицуулалт үгүйлэгдсэн, хүүхдийг боловсролоос хөндийрүүлдэг учраас уг салбар дахь хүүхдийн хөдөлмөрийн асуудалд нэн тэргүүнд анхаарлаа хандуулах ёстойг ухуулах; • Малчин айлд мал маллаж байгаа хүүхдийн хөдөлмөрийг мөлжсөн, эрхийг нь ноцтойгоор зөрчсөн, тэр ч бүү хэл эрүүл мэнд, амь насыг нь хохироосон тохиолдлууд гарч байгаа тул эдгээр хүүхдийн асуудалд анхаарал хандуулах цаг болсныг ойлгуулах; • Өөр айлд ажиллаж байгаа хүүхдүүд эцэг эхийн асрамж, хууль сахиулах байгууллага, олон нийтийн хараанаас нуугдмал ажиллаж байгаа тул хүүхдийн эмзэг байдал, ялангуяа охид, айлд байнга амьдарч ажилладаг хүүхэд илүүтэй эрсдэлд өртдөг тул тэднийг хамгаалахад онцгойлон анхаарах шаардлагатайг таниулах; • Бусдын хүүхдийг хөлслөн малаа маллуулж байгаа малчин, гэрийн ажлаа хийлгэж байгаа эзнийг ажил олгогч гэж үзэх ёстойг тайлбарлах; • Мал маллах ажилд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн наад захын хэм хэмжээг мөрдөх, ажлын таатай нөхцлөөр хангагдах, хийсэн ажилдаа тохирсон хөлс, урамшуулал авах ёстойг ажил олгогчоор хүлээн зөвшөөрүүлэх; • Өөр айлд байнга амьдарч, хөлслөгдөн ажиллахыг 18 хүртэлх насны хүүхдийн хувьд татгалзах нь хүүхэд гэр бүлдээ, эцэг эхийн асрамж, халамж дор өсч хүмүүжих ёстой гэсэн төрийн бодлоготой нийцэхийг тайлбарлах.
Газар тариалан	• Өрхийн газар тариалангийн аж ахуйд ажиллаж байгаа хүүхэд сургуулиас завсардах ёсгүйг таниулах; • Өрхийн аж ахуйд ажиллаж байгаа ч хүүхэд химийн бордоо, трактор, комбайн зэрэг техникийн эргэх эд анги бүхий тоног төхөөрөмж, машин механизмтэй ажиллах ёсгүйг ухуулах; • Хаврын тариалалтын бэлтгэл, намар хүнсний ногоо хураалтад ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийг санал бодлыг үл харгалзан, хичээлээс нь чөлөөлж, зохион байгуулалттайгаар, шийтгэлийн ямар нэг хэлбэрээр сүрдүүлэх замаар ургац хураалтад дайчлах нь хууль бус үйлдэл, албадлагын хөдөлмөрт тооцогдож болохыг таниулах, таслан зогоох шаардлагыг гаргаж тавих.

Хурдан морины унаач хүүхэд	- Хурдан морины уралдааны бэлтгэл үе болон уралдааны явцад хүүхдийн эрүүл мэнд, амь нас, эрхийг хамгаалах ёстой гэсэн байр суурийг илэрхийлэх; - Хурдан морины уралдааны бэлтгэл үе, уралдааны явцад хүүхдийн эрүүл мэнд, амь насанд аюул учруулах эрсдэлийг бууруулах, хязгаарлахад чиглэсэн арга хэмжээг уралдааныг зохион байгуулж байгаа албан тушаалтан, уяачид болон морин уралдааны холбоод хэрэгжүүлэх үүрэгтэйг шаардах; - Хурдан морины үсэргээ, сунгаа, уралдааны явцад хүүхдийн амь нас эрсдэх, гэмтэхийг хэн ч, ямар ч тохиолдолд хүлээн зөвшөөрөх ёсгүй, хүүхдийг хамгаалах бололцоотой бүх арга хэмжээг авах нь уралдааныг зохион байгуулагчид болон уяач, морины эзний хүлээх хариуцлага болох, энэ хариуцлагыг хууль тогтоомжоор бий болгоход анхаарлаа хандуулах; - Хурдан морины уралдааны улмаас хүүхэд гэмтсэн, амь насаа алдсан тохиолдлыг нуун дарагдуулах оролдлогыг эсэргүүцэх; - Морин уралдааны олон төрөл, хэлбэрүүдийн эрх зүйн зохицуулалтыг иж бүрнээр бүрдүүлэх шаардлагыг таниулах, бизнесийн ашиг, нэр хүнд олох зорилгоор зохион байгуулж байгаа болон мэргэжлийн морины уралдаанд оролцох хүүхдийн насны хязгаарыг ажил эрхлэх насны доод хязгаартай нийцүүлэн тогтоох ёстойг шаардах; - Хурдан морины унаач хүүхдийн хамгаалах хувцас, хэрэгслийн стандартыг боловсруулж мөрдүүлэх шаардлага, хүүхдийн хамгаалах хувцас хэрэгслийн зардлыг уяач, морины эзэн хариуцах үндэслэлийг таниулах; - Уралдааны явцад хүүхэд бэртсэн тохиолдлын тоо, түүний учир шалтгааны талаарх дүн мэдээг байнга авч байх, уралдааныг цаашид аюулгүй зохион байгуулах, гэмтэл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг улам боловсронгуй болгохыг шаардах.
Урлагийн үзүүлбэрт оролцох	Хүүхэд урлагийн үзүүлбэр (уран нугаралт, циркийн үзүүлбэр, кинонд тоглох, ТВ-ийн нэвтрүүлэг хөтлөх гэх мэт)-т оролцох тохиолдолд холбогдох байгууллагаас зөвшөөрөл авч байх, хүүхдийн ажлын цаг, нөхцлийг гэрээгээр тодорхойлж, хүүхдийн төлөө хариуцлага хүлээх этгээдийг тогтоох шаардлагатайг таниулах, шаардах.
Бусад	- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг гудамж, үерийн далан, траншей, шефийн холбоотой аливаа аж ахуйн нэгжийн агуулах, талбай зэргийг цэвэрлэх ажилд дайчлах нь хүүхдийг албадлагаар хөдөлмөрлүүлж байгаа хэрэг болохыг таниулах; - Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг улирлын болон зуны амралтын үеэр хаягдал хуванцар сав, шил цуглуулах, тарвага, зурам агнуулах даалгаврыг өгдөг нь хүүхдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрт санаатай түлхэж байгаа, хүүхдийн нэрээр ашиг олох гэж буйн илрэл болохыг ойлгуулах; - Гудамжны золбин нохой устгуулах ажилд хүүхэд оролцож байгааг буруушаах; - Хөдөлмөр зуслан нь амьдрах ухааны сургалтын хэлбэр боловч хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө учруулж болзошгүй ажлыг хамгаалах хувцас хэрэгсэлгүйгээр, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны мэдээлэл, зааварчилга өгөлгүйгээр хийлгүүлэх ёсгүйг таниулах.

4.2. Мэдээллийн хэрэгслээ сонгох нь



Мэдээллийн хэрэгсэл гэдэг нь нөлөөлөгчдөөс зорилтот бүлэгт хүргэх мэдээлэл, илгээмжийг түгээх сувгуудыг хэлнэ. Мэдээлэл дамжуулах сувгуудыг дараах ангилалд хувааж болно. Үүнд:

А. Хүнээр дамжуулах арга

- ➔ Биечлэн уулзах
- ➔ Лоббидох уулзалт
- ➔ Бүлгийн болон олон нийтийн цуглаан
- ➔ Сургалт семинар
- ➔ Олон нийтийн яриа, хэлэлцүүлэг
- ➔ Эсэргүүцэл, олон нийтийн жагсаал цуглаан болон олон түмнийг хамарсан үйл ажиллагаа
- ➔ Аман яриа болон хов жив

В. Зураг, үзүүлэн, хэвлэмэл материал ашиглах арга:

- ➔ Сонин, сэтгүүл
- ➔ Танилцуулга
- ➔ Зурагт хуудас, видео бичлэг, үзүүлэн, фото зураг, гар зураг
- ➔ Зарлалын самбар

С. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглах: (Бүлэг 6-аас үзнэ үү)

- ➔ Радио, телевиз
- ➔ Сонин, сэтгүүл
- ➔ Кино, видео, слайд
- ➔ Интернет

Д. Олон нийтийг хамарсан компанит ажлыг зохион байгуулах

- ➔ Жүжигчилсэн болон хүүхэлдэйн тоглолт,
- ➔ Дуу бүжиг, олон нийтийн баяр, өдөрлөг
- ➔ Гудамжны театр болон хүүхэлдэйн шоу
- ➔ Дуу, хөгжим, яруу найраг

4.2.1. Мэдээллийн хэрэгслийн төрөл хэлбэр

Мэдээллийн сувгийг ашиглахдаа өөрийн зорилтот бүлэгт тохируулан сонгоно.

- ➔ Таны зорилтот бүлгийнхэн /нас, хүйс, боловсрол, хэлний мэдлэг зэргийг харгалзан үзнэ үү/ өдөр тутмын мэдээллээ ямар эх үүсвэрээс авдаг вэ? Тэд телевиз үздэг үү, эрчим хүчинд холбогдсон уу? Олон нийтийн хуралд ирэх унааны боломжтой юу, энэ нь улирлын чанартай юу гэх мэт.
- ➔ Хүмүүс аль болох олон эс үүсвэрээс таны мэдээллийг авахаар эсвэл аль нэг суваг нь хүрч чадаагүй тохиолдолд нөгөө нь хүрэхээр тооцож олон сувгийг ашигла.
- ➔ Аль болох олон хүнд хүрэхүйц сувгийг ашигла.
- ➔ Чанартай материал боловсруул. Муу бэлтгэсэн, чанар муутай материал хүмүүсийн анхаарлыг татаж чадахгүй. Зөвхөн мөнгөний гарз болно.

4.2.2. Мэдээллийн сувгийг сонгоход юуг анхаарах вэ?

Мэдээллийн сувгийг сонгохдоо хэнд мэдээлэл зориулагдаж байгаа буюу зорилтот бүлэг, тэдэнд хэрхэн хүрэх арга зам, мэдээллийн сувгуудыг яаж ашиглах буюу хэрхэн мэдээллийн хэлбэрээ сонгох асуудлуудыг анхаарна.



Аргачлал: 4.3 Мэдээллийн суваг, хэлбэрийг сонгох нь:

Мэдээллийн зорилтот бүлэг	Мэдээллийн суваг	Мэдээллийн хэлбэр
Хүүхдүүд	Бусад хүүхдүүд Багш нар	Жүжигчилсэн тоглолт Зурагт хуудас Хичээлийн дасгал
Эцэг эхчүүд	Хүүхдүүд Багш нар Ажилтнууд Үзүүлэн материал хэвлүүлэх Нэг хүнээс нөгөө рүү дамжуулах	Эцэг эхчүүдэд зориулсан жүжигчилсэн тоглолт Сонин, сэтгүүл Танилцуулга Зурагт хуудас, видео бичлэг, үзүүлэн, фото зураг, гар зураг Зарлалын самбар Сургалт семинар Хэлэлцүүлэг
Олон нийт	Эрүүл мэндийн ажилтнууд Багш нар	Эмнэлэгт зурагт хуудас наах
Засгийн газар, захиргаа	Радио	Хөдөлмөр эрхэлдэг хүүхэдтэй хийсэн ярилцлагыг нэвтрүүлэх
Бизнесийн байгууллага	Интернет	
Үйлдвэрчний Эвлэл	Үзүүлэн материал хэвлүүлэх Нэг хүнээс нөгөө рүү дамжуулах	
Донор байгууллагууд	Тайлан мэдээ хэвлүүлэх	Жилийн тайлан, сонин, төслийн санал

4.2.3. Зорилтот бүлэгт нөлөөлөх төлөвлөгөөг боловсруулах нь

Дараах ажлын хүснэгтийг ашиглаж зорилтот бүлэгт нөлөөлөх төлөвлөгөөг гаргаж болно. Зорилтот бүлэгт хэрхэн, ямар арга замаар нөлөөлөх вэ гэдгийг тодорхойлоход тэдэнд ямар илгээмж хүргэх, илгээмжийг хэнээр хүргүүлэх, ямар мэдээллийн суваг ашиглах зэрэг асуудлууд хамаарна.



Аргачлал 4.4

ЗОРИЛТОТ БҮЛЭГТ НӨЛӨӨЛӨХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР

Ажлын хүснэгт: 4.4

Нөлөөлөх үндсэн асуудал:

Нөлөөллийн зорилт:

Зорилтот бүлэг	Гол илгээмж	Илгээмжийг хэнээр хүргүүлэх	Мэдээлэл харилцааны сувгууд
Зорилтот бүлэг 1:			
Зорилтот бүлэг 2:			

4.3 Мэдээллийг хүмүүст ойлгомжтойгоор илэрхийлэх зарим аргууд

Олон нийтийн үнэт зүйл, итгэл үнэмшлийг тодорхой баримт нотолгоогоор илэрхийлэх нь хүмүүст асуудлыг ойлгоход нь тусалдаг ба тэднийг идэвхгүй байр сууринаас биш харин асуудлыг өөриймсгөөр харахад тусалдаг.

Асуудлыг ойлгомжтой илэрхийлэхийн тулд дараах аргыг ашиглаж болно. Үүнд:

- ➔ Тоон утгыг багасгах арга
- ➔ Харьцуулах арга
- ➔ Жишээ ашиглах арга

Тоон утгыг багасгах арга - жилийн хугацаатай үзүүлэлтүүдийг хамгийн бага богино нэгж, эсвэл зарцуулсан мөнгөн дүнг хүний тоонд хуваах зэргээр тоог багасгах замаар тухайн тоо баримтыг аль болох хүмүүст ойлгомжтой болгохыг хэлнэ. “Тоон утгыг багасгах” жишээг үзнэ үү.

Жишээ: Тоон утгуудыг багасгах нь

*Монголд 5-14 насны 36727 хүүхэд хөдөлмөр эрхэлж байна гэсэн судалгааны дүн гарчээ. Энэ тоо их үү, бага уу гэдгийг хүн бүр харьцуулан ойлгож чадахгүй. Иймээс энэхүү тоо баримтыг дараах хэлбэрээр багасгаж болно. Үүнд:
Нэгдүгээрт, та хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн өсвөр насныхны дунд эзлэх хувийг үзүүлж болно. Хэрэв Монголын 5-14 насны нийт хүүхдийн тоо 506986 бол 36727-д хуваана. Тэгвэл: 5-14 насны 7,2 хувь нь буюу 14 хүүхэд тутмын нэг нь хөдөлмөр эрхэлж байна” гэж гарна.*

Харьцуулах арга: Аливаа асуудлын талаар тоо баримтыг дурьдахад хүмүүст “энэ нь хэр их гэсэн үг вэ” гэсэн асуулт тулгарна. Иймээс тухайн тоо баримтыг хүмүүст ойлгомжтой болгох үүднээс харьцуулах аргыг ашигладаг. Энэ аргыг ашигласан жишээг дурдъя.

Жишээ: Харьцуулах аргыг ашиглах нь

Саяхны нэг судалгаагаар дэлхий даяар 2015 он гэхэд чанартай бага боловсролыг хүн бүрт эзэмшүүлэх гэсэн зорилгыг биелүүлэхэд жил тутам 16 тэрбум доллар шаардлагатай гэжээ (Матз, 2003). Энэ нь маш их мөнгө мэт санагдаж болох юм. Иймээс дараах хүснэгтэнд бусад салбарт зарцуулдаг мөнгөний дүнг харьцуулан харуулав.

Хүснэгт . Суурь боловсрол болон бусад салбарт зарцуулдаг хөрөнгийн жилийн дүн /доллараар/

Дэлхийн хамгийн чухал асуудал юу вэ? /жилийн зарцуулалтаар авч үзвэл/	
Суурь боловсрол	6 тэрбум
Европ-д зайрмагт	11 тэрбум
Европ болон АНУ-д үнэртэй усанд	12 тэрбум
Европ болон АНУ-д гэрийн тэжээвэр амьтны хоол тэжээлд	17 тэрбум
Японд үзвэр үйлчилгээнд	35 тэрбум
Европт тамхинд	50 тэрбум
Европт архи, согтууруулах ундаанд	105 тэрбум
Дэлхий дахинд мансууруулах бодист	400 тэрбум
Дэлхий дахинд цэрэг дайны үйл ажиллагаанд	780 тэрбум

Тоон хэмжигдэхүүнийг харьцуулах буюу чанарын хэмжигдэхүүнд шилжүүлэх.

Энэ нь асуудалд холбогдолтой тоог мэдээг бидэнд илүү танил тоон утгуудтай харьцуулж аль нь бага байна гэдгийг харуулна. Ингэснээр их ялгаа байгаа эсвэл гайхалтай ойролцоо буюу адилхан байгааг тодорхой харуулж өгч болох юм.

Жишээ: Харьцуулалт хийх нь

АНУ-д 6 настай хүүхдүүд Уолт Диснейгийн Мики Маусыг таньдаг шигээ Жо Камелийн (Camel -ийн) зардаг тамхины таних тэмдгийг мэддэг байна.

Чилээс импортлодог хоёр төрлийн жимснээс цианид (хорт бодис) илэрснийг мэдээд АНУ-ын засгийн газраас Чилээс бүх төрлийн жимс импортлохыг хориглосон байна. Тамхины асуудлаар нөлөөлөгчид энэхүү хэргийг дараах байдлаар ашиглажээ. Үүнд:

“1ширхэг тамхинд агуулагдах цианидийн хэмжээ хэд хэдэн бушель муудсан жимсэнд агуулагдах цианидын хэмжээнээс их ажээ. Засгийн газар ийм үхлийн аюултай нэг бүтээгдэхүүнийг тоохгүй орхих мөртлөө нөгөө нэг бүтээгдэхүүнийг ийм хурдан хориглосон арга хэмжээ авахын учир юу вэ?”.

Энэхүү гайхалтай ялгааг тэд бодлогын чанартай асуудалтай холбож чадсан байна!

Эх үүсвэр: ОУХБ. Хүүхдийн хөдөлмөр : Их дээд сургуулийн оюутнуудад зориулсан сурах бичиг. УБ 2007

V БҮЛЭГ

НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АРГА ТЕХНИКУУД

БҮЛГИЙН ТОВЧ АГУУЛГА

- 5.1. Хамтран ажиллах арга техникүүд
- 5.2. Хүүхдээс хүүхдэд арга
- 5.3. Лоббидох аргыг ашиглах нь
- 5.4. Сургалт семинар зохион байгуулах
- 5.5. Эцэг эхчүүдэд нөлөөлөх нь
- 5.6. Хэвлэмэл материал ашиглах арга
- 5.7. Олон нийтийг дайчлах аргууд

5.1 Хамтран ажиллах арга техникүүд

Нөлөөллийн үйл ажиллагаанд хамтрах дараах арга техникүүдийг ашиглаж болох тухай өмнө нь дурдсан. Үүнд:

- ➔ Ажлын хэсэг буюу дэд хороодыг бүрдүүлэх
- ➔ Эсрэг талтайгаа тогтмол харилцаатай байх
- ➔ Лоббидох
- ➔ Семинар уулзалт зохион байгуулах
- ➔ Баримт мэдээний хүснэгтүүд, боломжит хувилбаруудыг санал болгох

Эдгээрийг зорилтот бүлэг, цаг хугацаа зэргээс хамаарч ямар арга техникийг ашиглахаа сонгоно. Хамтрах арга техникүүд нь хүн хүндээ нөлөөлөх арга зүйг ашиглан хүнээр дамжуулах арга бөгөөд биечлэн уулзах, аман яриа зэрэг нь хамаарна. Энэ бүлэгт хамтын ажиллагааны аргуудаас зарим аргуудыг хэрхэн ашиглах тухай авч үзлээ.

5.1.1 Хамтын ажиллагаа гэж юу вэ?

Хамтын ажиллагаа гэдэг нь нийтлэг сонирхолтой эвсэл нь нэг асуудалд анхаарал хандуулж буй хувь хүмүүс болон бүлэг хамтарч ажиллахыг хэлнэ. Хамтын ажиллагааны зорилго нь мэдээлэл хуваалцахаас эхлээд хамтарч үйл ажиллагаа явуулах хүртэл өргөн хүрээг хамардаг. Хамтын ажиллагаа нь олон янзын хэлбэртэй байна. Үүнд: албан ба албан бус, түр ба урт хугацааны хамтын ажиллагаа хамрагдах бөгөөд түүнийг янз бүрээр тухайлбал, сүлжээ, эвсэл, компани, холбоо гэх мэтээр нэрлэдэг. Хэдийгээр нэр томьёо байнга өөрчлөгдөж байдаг ч хамтын ажиллагааны шугамын нэг тал нь сүлжээ, нөгөө тал нь эвсэл хэмээн авч үзэж болно.

Зураг 5.1.1: Хамтын ажиллагааны хүрээ

Сүлжээ

(зорилго, чиглэл)

- Мэдээлэл хуваалцах
- Түр зуурын
- Албан бус
- Нарийн бүтэц зохион байгуулалт шаардахгүй
- Бие даасан байдалтай

Эвсэл

(зорилго, чиглэл)

- Хамтарч үйл ажиллагаа явуулах
- Байнгын тогтвортой байх магадлал өндөртэй
- Албан ёсны
- Нарийн бүтэц зохион байгуулалттай
- Шийдвэр гаргах болон хөрөнгийн эх үүсвэрийг хамтарч гаргах шаардлагатай
- Үйл ажиллагааг нь зохицуулах шаардлагатай

Хүснэгт 5.1.1. Хамтын ажиллагааны хоёр хэлбэрийн тухай

Сүлжээний тухай товч өгүүлэх нь	Эвслийн тухай товч өгүүлэх нь
Сүлжээ нь аливаа мэдээлэл, шинэ санааг хуваалцах, дэмжлэг туслалцаанаас хамтран хүртэхийн тулд бий болдог. Сүлжээний гишүүнчлэлийн хамгийн гол шаардлага нь нийтлэг ашиг сонирхолтой байх явдал бөгөөд гишүүдийн бусад ялгаатай байдлыг аль болох ялгаварлахгүйгээр хамтарч ажиллах боломж бүрдүүлэх хэрэгтэй. Сүлжээний бүтэц зохион байгуулалт нь ихэнх тохиолдолд албан ёсны бус байх ба гишүүд нь өөрсдөө ашиг хүртэх, хувь нэмрээ оруулах эсэхээ шийдэхээс гадна хүссэн үедээ сүлжээнээс гарч болдог.	Эвсэл нь хамтарч нэгдмэл үйл ажиллагаа явуулахын тулд бий болдог. Нэгдсэн зорилгодоо хүрэхийн тулд гишүүд ихээхэн хэмжээний нөөц бололцоогоо хувь нэмэр болгон оруулах ба шийдвэр гаргах эрх мэдлийг хуваалцаж, өөрсдийн нэгдсэн стратеги, олон нийтэд хүргэх мэдээлэл болон үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хамтран боловсруулдаг. Эвслийн гишүүдэд нийтлэг ашиг сонирхлоос гадна итгэлцэл шаардлагатай байдаг. Эвслийн бүтэц зохион байгуулалт нь илүү албан ёсны шинжтэй байх бөгөөд эвсэл үйл ажиллагаагаа хэвийн явуулахын тулд гишүүдийн ялгаатай талыг зохицуулж, чиглүүлж байх чадварлаг удирдлага шаардлагатай болно. Эвслийн зорилго биелсэн (эвсэл биелээгүй) үед эвслээс гарах, эвсэл өөр зорилт хэрэгжүүлэхийн төлөө үргэлжлүүлэн хамтарч ажиллах эсэхээ гишүүд өөрсдөө шийдэх ёстой байдаг.

Хамтын ажиллагааны ач холбогдол юунд орших вэ?

Сүлжээнд нэгдэхийн ач холбогдол нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- Ховор мэдээлэл олоход тусална.
- Сүлжээний бусад гишүүдээр дамжуулан шийдвэр гаргагчид болон бусад эрх мэдэлтнүүдтэй уулзах боломжоор хангагдана.
- Ямар үйл ажиллагаа нь хэрэгжих боломжтой, ямар нь хэрэгжих боломжгүй талаар бусад гишүүдийнхээ туршлагаас мэдэж авна.
- Ирээдүйн үйл ажиллагаанд хэрэг болох харилцаа холбоог бий болгоно.
- Тусгаарлагдмал байдлаас ангижирч өөртэйгээ ижил зорилготой олон нийттэй холбогдоно.

Эвсэлд ажиллахын ач холбогдол нь :

- ➔ Олон хүмүүс хамтарч ажиллах нь шийдвэр гаргагчдад үзүүлэх нөлөөг нэмэгдүүлдэг. Хувь хүмүүс дан ганцаараа биш бүлгээр хамтарснаар эрсдэл даах чадвар нэмэгдэнэ.
- ➔ Янз бүрийн хүмүүс, олон талт арга барил нь асуудлыг олон талаас нь харах боломжийг бүрдүүлдэгээс асуудлыг шийдэх, олон нийтэд хүргэх, үр нөлөө гаргах боломжийг нэмэгдүүлнэ.
- ➔ Авъяас чадвар, ажлын арга барил, хөрөнгийн эх үүсвэр, нөөцийн олон талт байдал нь олон төрлийн үйл ажиллагаа явуулах боломж олгохын зэрэгцээ нэг байгууллагад ачаалал хэт төвлөрөхөөс сэргийлнэ.
- ➔ Үнэт зүйлс, зорилго болон туршлагаа хуваалцах нь нөлөөллийн ажилтнуудад тусгаарлагдмал байдлыг даван туулах, итгэлцэл бий болгох, улмаар өөрчлөлт хийх боломжтой гэсэн найдварыг бий болгодог.

- Эвсэл нь ардчилалд шаардлагатай чадвар болон байр суурийг жижиг хүрээнд хэрэглэх боломж олгоно. Эдгээр чадварууд нь бие биеийн үзэл бодол, байр суурийг хүндэтгэх, ил тод байдал, хариуцлагатай байх, тэгш байдал болон янз бүрийн бүлгийн хүмүүстэй хамтран ажиллах чин сэтгэл зэрэг болно.

5.1.2 Хамтран ажиллагчаа сонгох нь

Дэмжигчдийг хэрхэн таних вэ?

- Зорилтыг хэн дэмжиж байна вэ?
- Таны зорилт биелвэл хэнд ашигтай вэ? / Ашиг тусыг шууд хүртэгсэд, хэрэгжүүлэгч үүрэг бүхий хүмүүс/
- Таны зорилт биелэснээр санхүүгийн ашигтай байж чадах уу?
- Хэрэв зорилт биелбэл ямар байгууллагад ашигтай вэ?
- Засгийн газар, яамд, тэдгээрийн агентлагуудад ашигтай юу?
- Иргэний нийгмийн ямар бүлэгт ашигтай байх вэ?
- Ямар улс төрийн хүчинд ашигтай байх вэ? Ямар бүлэг, хувь хүнд ашигтай байх вэ? / Улс төрийн хүчин, засгийн газар, төрийн захиргааны ажилтнууд, ТББ, хувийн хэвшил/



Аргачлал 5.1 Дэмжигчдийн мэдлэг, хандлагын зураглал

Зааварчилгаа

- Дор өгөгдсөн хүснэгтийг ашиглан дараах асуултуудад хариулснаар дэмжигч түншлэгчдийнхээ талаар илүү тодорхой мэдээлэлтэй болох боломжтой.
- Нөлөөллийн ажил хийхээр сонгон авсан асуудлынхаа хүрээнд та бүхний үйл ажиллагааг ямар хүмүүс илүү дэмжинэ гэж бодож байна вэ?
- Тэдний дэмжлэг та бүхний үйл ажиллагаанд ямар нөлөө үзүүлэх вэ?
- Тэдний гол сонирхол нь юу вэ зэргийг тодорхой бичнэ.

Дэмжигч бүлэг	Тэд юу мэдэж байна вэ? Хангалттай мэдээлэлтэй юу?	Тэдний дэмжлэг ямар байна вэ?	Тэдний гол сонирхол юу вэ?

5.1.3 Хамтрагч байгууллагаа сонгох нь



Аргачлал 5.2 Хамтрагч байгууллагаа сонгох тактик:

- **Хэн та нартай адил үнэт зүйл, итгэл үнэмшилтэй байна вэ?** Хамтран зүтгэгчид нь ихэвчлэн ижил үзэл санааг дэмждэг, үнэт зүйл, итгэл үнэмшилтэй хүмүүс байдаг. Иймээс ийм хүмүүс байгууллагад эхлээд хандаарай. Гэхдээ та нарынхаас ялгаатай үнэт зүйл, итгэл үнэмшилтэй хүмүүс байгууллагыг анхаарахгүй орхиж болохгүй. Олон янзын бүлэг, сонирхогч талуудтай ажиллах шаардлагатай болно. Хамгийн гол нь хамтын ажиллагааны чиглэлээ тодорхойлох хэрэгтэй.
- **Тухайн асуудлаар хэн ажиллаж байна?** Та нарын ажиллаж буй асуудлаар өмнө нь туршлагатай байгууллага хүмүүсээс суралцахыг эрмэлзэх нь чухал. Та нарын байр суурийг тэд дэмжиж байгаа бол тэдэнтэй сайн харилцаа холбоо тогтоох.
- **Та нарт шаардлагатай зүйлийг хэн өгч чадах вэ?** Мэдээлэл тоо баримт олох, хэвлэл мэдээлэлтэй ажиллах, шийдвэр гаргагчдад нөлөөлөх, компанит ажлаар идэвхтэй ажиллах гэх мэт үйл ажиллагаанд хэн тусалж болохыг тодруул. Өөрт хэрэгтэй зүйлийн талаар тодорхой мэдэж бай.
- **Хэн та нартай хамтарч ажиллах боломжтой байна?** Хамтрах боломжтой байгууллага хүмүүс ямар зорилготой байна гэдгийг ойлгож тэдэнтэй хэрхэн хамтарч ажиллах боломжтой талаараа тодорхой бай. Ямар чадвар та нарт байна, судалгаа мэдээ байна уу, юугаар хамтын ажиллагаанд өөрийн хувь нэмрээ оруулж болох талаар тодорхой бай.
- **Хэн идэвхтэй ажиллах чадвартай байна?** Хамтарч ажиллаж байгаа тал болгон ямар үүрэг оролцоотой байх талаараа тодруул.
- **Хамтарч ажиллаагүй тохиолдолд сөрөг тал нь юу вэ?** Хамтын ажиллагаа хангалтгүйгээс болж тавьсан зорилго, зорилтоо хэрэгжүүлэх, нөлөөллийн үр дүн буурах сөрөг талтай.

5.2 Хүүхдээс хүүхдэд арга

“Хүүхдээс-хүүхдэд” арга нь хэн нэгэн хүнээс нөгөө рүү хүнээр дамжуулах аргын нэг хэлбэр юм.

Хүснэгт 5.2 “Хүүхдээс-хүүхдэд” аргын давуу болон сул тал

Хүүхдээс хүүхдэд аргын давуу тал	Хүүхдээс хүүхдэд аргын хязгаарлагдмал талууд:
Тэдний итгэдэг хүмүүсээр дамжуулсан мэдээлэл хамгийн үр дүнтэй байдаг.	Хүүхдээс хүүхдэд хүрч ажиллах арга нь хүүхдийн оролцоог шууд хангах хэлбэр биш юм. Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд үе тэнгийн сургагчид, үйлчилгээнд татан оролцуулагч хүүхдүүд зэрэг харьцангуй цөөн тооны хүүхэд идэвхтэй оролцдог
Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдэд хүрч ажиллахад энэ арга нь тохиромжтой. Учир нь хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд “далд” байдаг учраас.	Хүүхдүүд харилцааны болон идэвхижүүлэлтийн ур чадвартай байх хэрэгтэйгээс гадна тодорхой арга техникийг сонгож ашиглах шаардлага тулгарна. Тэдний ур чадвар, туршлагаас зорилтот бүлгийн хүүхдүүдийн бодит оролцоог бий болгож чадах эсэх нь ихээхэн хэмжээгээр хамаарч байдаг.
Мэдээллийг энгийн үгээр ам дамжуулан тарааснаар ойлгомжтой болдог.	Байгууллагын зүгээс хүүхдээр дамжуулан хүүхдэд хүрэх үйл ажиллагааг дэмжих дэмжлэгийн систем, чадавхийг бий болгож, бэхжүүлэхэд анхаарах, сургалт хийх хэрэгтэй. Түүнчлэн хүүхдүүд бусад хүүхдүүдтэй хэрхэн ажиллаж буй байдалд, ялангуяа эхний үе шатанд тогтмол хяналт шинжилгээ хийж байх хэрэгтэй.
Хүүхэд хүүхдээ илүү сайн ойлгож хамтарч ажиллаж чадна.	Үе тэнгийн сургагч хүүхдүүдийг нээлттэй, ил тод, ардчилсан зарчмаар маш болгоомжтой сонгох ёстой.
Хүүхэд өөрсдөө өөрчлөлтийг хийж байгаа нь онцлог.	Хүүхдүүдийн эцэг, эхчүүд, орон нутгийнхан хүүхдийн хүлээж буй үүрэг, хариуцлагын талаар сайн мэдэж байх ёстой. Мэдээлээгүй тохиолдолд үе тэнгийн сургагчид цагдаад баривчлагдах эрсдэлтэй байж болно.

5.3 Лоббидох аргыг ашиглах нь

Лоббидох гэдэг нь шийдвэр гаргагчдын шийдвэрт нөлөөлөх үйл ажиллагааг хэлнэ. Тухайлбал бодлого боловсруулагчид, хууль тогтоогчдын /бүх шатны Иргэдийн Нийтийн Хурлын төлөөлөгчид, Их хурал, г.м / хууль, тогтоомжинд өгөх саналыг өөрийн асуудлаар нааштайгаар шийдүүлэх оролдлогыг хэлнэ. Энэ нь шинээр бодлого, хөтөлбөр боловсруулах, өөрчлөх, тодорхой эрхийг хангах, санхүүжилт хийх гэх мэт ямар ч шийдвэр байж болно.

Лоббидох дараах аргуудыг ашиглаж болно:

- ➔ Өөрийн байр сууриа илэрхийлсэн захидал, албан бичиг бичих, илгээх утсаар ярих
- ➔ Лобби уулзалт зохион байгуулах
- ➔ Олон нийттэй хийх уулзалт, хэвлэлийн бага хуралд оролцох
- ➔ Хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулсан тохиолдолд шүүхээр дамжуулан шийдүүлэх

Лоббидох уулзалтууд нь дараах боломжийг хангаж өгнө. Үүнд:

- Харилцаа холбоо тогтоох
- Мэдээлэл сонсох ба цуглуулах
- Сургах ба мэдээллээр хангах
- Итгүүлэн үнэмшүүлэх зэрэг боломжийг хангана. Эдгээр нь бүгд нөлөөллийн нэг хэсэг нь болдог.

Үр дүнтэй лобби хийх зөвлөмж

- ➔ Хууль боловсруулагч, шийдвэр гаргагчдын ажлын албаны хүмүүс буюу туслах ажилтнуудыг сайн мэдэж байх нь ач холбогдолтой. Учир нь тэд тодорхой асуудлын талаар нарийн мэдээлэлтэй байдаг. Тэднийг мэдээллээр хангаж холбоотой ажилласнаар шийдвэр гаргагчид мэдээлэл хүрэх боломжтой болно.
- ➔ Таны уулзалт төлөвлөснөөс богино байж болох учраас юу хүсэж байгаагаа богино хугацаанд илэрхийлэхэд бэлэн, бэлтгэлтэй бай.
- ➔ Судалгааны тоо баримтаас гадна бодит түүх ярихад бэлэн бай
- ➔ Санал нийлэхгүй зүйл байж болно. Гэхдээ уурлах хэрэггүй.
- ➔ Хэрэв ямар нэг зүйл мэдэхгүй бол худлаа ярьж болохгүй. Харин энэ талаар мэдээлэл олж өгнө гэж хэл.
- ➔ Юу хэрэгтэй байгаа, яагаад энэ үйл ажиллагаа чухал болохыг тодорхой, цаг алдалгүй, нуршихгүй хэлэх
- ➔ Холбогдолтой жишээг ашиглах. Шийдвэр гаргагчийн сонирхолтой өөрсдийн ашиг сонирхлыг холбож болохоор бол энэ боломжийг ашигла
- ➔ Сайн ятгагч бай. Лобби хийж байгаа гэдгээ сана.
- ➔ Өөрийн үзэл бодлыг өөртөө итгэлтэйгээр хэл, лекц унших хэрэггүй.
- ➔ Тулсан хэлэлцээрт бэлэн бай. Санаа бодол, мэдээлэл тайлбараа үндэслэлтэйгээр илэрхийлэх, маргаж тулахад өөрийгөө бэлд.
- ➔ Шийдвэр гаргагчид нь ямар нэг орон нутаг, олон нийтийн харьяалалтай болохыг санаж үүнийг ашигла.
- ➔ Нөлөөлөгчдийн багаас уулзалтыг хэн нь эхлүүлж, дуусгахыг тогт



Аргачлал 5.3 Лоббидох уулзалт зохион байгуулах аргачлал

Лоббидох уулзалтын өмнө

Лоббидох уулзалтын өмнө бэлдэх цаг гарга. Хэдийчинээ сайн бэлдсэн байна төдий чинээ ярилцлагыг гол асуудалд чиглүүлэн, гэнэтийн асуулт болон шалгууруудад хариулт өгөх чадвартай байна. Бэлтгэл нь танд өөртөө итгэлтэй байхад тусална. Ялангуяа хэрэв энэ нь таны хувьд анхны лоббидох оролдлого бол бүр ч чухал.

- ➔ Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг бэлтгэх:
 - Лоббидох уулзалтанд хэн оролцох хэрэгтэй вэ? Таны сонирхогч тал хэнд хамгийн их итгэх вэ? Хэн асуудлыг хамгийн сайн мэдэх вэ? Асуудалд хамгийн тайван хандах хүн хэн бэ? Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд асуудалд шууд хамаатай хэн нэгнийг багтаах уу? Ямар нэг мэргэжилтэн тухайлбал, академич, засгийн газрын хуучин ажилтан гэх мэт хэн нэгнийг байлцуулах шаардлагатай юу ?
 - Бүрэлдэхүүнд багтсан хүн бүр асуудлын талаар ижил үзэлтэй байна уу? Уулзалтын өмнө цаг гарган ялгаа зөрөлдөөнийг арилган зөвшилцөлд хүрэх хэрэгтэй. Энэ нь тухайн уулзалтын үеэр ойлгомжтой, сайтар бодож үзсэн мэдээлэл дамжуулахад тусална.
 - Хүн бүр хэдийд, хаана уулзахаа мэдэж байна юу? Мөн юу өмсөж, ямар зүйл авчрах ёстойгоо мэдэх үү?

- ➔ Танилцуулгаа бэлтгэх:
 - Бид ямар асуудлыг хөндөж байна вэ? Бид нэг л зүйлийг сонгож анхаарлаа хандуулж байна юу? Бид үүнийгээ товч тодорхой дэлгэж тавьж чадаж байна уу?
 - Бид сонирхогч талаасаа юу хүсч байна? Тэд ямар саналтай байна вэ? Асуудлыг дэмжихэд бусдыг ятгах хэрэгтэй уу? Сонирхогч талаас асуух зүйлээ нягталж тунгаагаарай.
 - Танилцуулгын гол санаа нь юунд агуулагдаж байна вэ? Ямар төрлийн мэдээллийг ашиглаж байна вэ? Статистик мэдээг үү? Тухайн асуудал нөлөөлсөн хэн нэгний мэдүүлэг үү? Тухайн хүнийг яаж ятгах талаар үнэлэлт өгсний үндсэн дээр мэдээллийг засаж, боловсруул.
 - Ямар асуудлыг ярилцахгүй орхих вэ? Хэрэв эдгээр асуудлаар ярилцаад эхэлбэл ярилцлагыг хэрхэн өөрсдийн асуудал руу хандуулах вэ?
 - Ямар асуудлаар хэлэлцэж болох вэ? Ямар асуудлыг хэлэлцэж болохгүй вэ? Үүнийгээ урьдчилан тодорхойлсноор хэрэв шаардлагатай бол буулт хийхэд бэлэн байх хэрэгтэй болно.
 - Бид сонирхогч талдаа юу санал болгох вэ? Мэдээлэл үү? Олон нийтийн дэмжлэг үү?
 - Уулзалтыг хэрхэн нээх вэ? Урьд өмнө нь дэмжсэн хэн нэгэнтэй уузах бол эхлээд талархлаа илэрхийлэх хэрэгтэй.
 - Уулзалтын үеэр хэн ямар үүрэг гүйцэтгэх вэ? Хэн юу хэлэх вэ? Ярилцлагыг хэн эхлүүлэх вэ? Тэмдэглэл хөтлөгчтэй байх уу?
 - Төлөөлөгчдийн бүрэлдэхүүний хэрхэн танилцуулах вэ?
- ➔ Танилцуулгаа давтаж үзэх:
 - Танилцуулгаа олны өмнө тавьж байгаа мэтээр дүр тоглож үзэх нь өөртөө итгэлтэй байдлыг нэмэгдүүлдэг.
- ➔ Материалуудаа бэлтгэх: Таны сонирхогч тал дараах зүйлстэй зайлшгүй танилцсан эсэхийг магадлаарай. Үүнд:
 - Асуудлын талаарх дүгнэлт болон таны гол санааны талаар мэдээлэл авсан эсэх
 - Тантай харьцах мэдээлэл авсан эсэхийг магадлан шалгах нь зүйтэй.

Лоббидох уулзалтын үеэр

Та нэгэнт сонирхогч талтайгаа уулзах гэж байгаа бол, уулзалтын дараах үндсэн дөрвөн зорилгыг санаж байх хэрэгтэй. Үүнд:

- ➔ Харилцаа холбоо тогтоох
 - Лоббидох уулзалтыг шинэ харилцаа тогтоох болон хуучнаа бэхжүүлэхэд ашиглаж болно.
 - Уулзалтын эхэнд бага зэрэг ярилцах цаг гарга. Гэхдээ хэтэрхий их биш. Энэ бол таны уулзалт гэдгийг санах хэрэгтэй.
 - Эелдэг боловсон, хүндэтгэсэн өнгө аясыг эрхэмлэ.
 - “Байнгын найз ч биш, байнгын дайсан ч биш” гэдэг эртний үгийг санаж яв. Хэрэв таньтай одоогийн асуудлаар зөвшилцөж чадахгүй ч магадгүй ирээдүйд өөр нэг асуудлыг тань дэмжиж болно. Харилцаа холбоо тогтоосноор өөр асуудлаар дахин уулзаж болно.
- ➔ Мэдээлэл сонсох ба цуглуулах
 - Таны сонирхогч талд ямар асуудал чухал вэ?

- Ямар зүйл дээр санаа нэгдэж байна вэ? Нэг зорилготой салбар мөн үү?
- Санаа зөрж буй ямар зүйлс байна вэ?
- Хэрэв таны сонирхогч тал “яриа муутай” хүн бол асуулт асуух замаар харилц
- ➔ Сургах ба мэдээллээр хангах
 - Сонирхогч талынхаа бодлыг бататгах эсвэл түүнтэй зөрөлдөх мэдээллийг санал болго.
 - Та асуудлын талаар мэргэжилтэн байх хэрэггүй. Таны сонирхогч тал мэргэжилтэн биш л байх. Ихэнх сонгогдсон албан тушаалтанууд ерөнхий мэдлэгтэй байдаг. Гэвч хэрэв шаардлагатай гэж бодож байвал, тухайн асуудлаар мэргэшсэн хэн нэгэнтэй хамтраарай.
 - “Би мэдэхгүй байна” гэж хэлэхэд буруудахгүй бөгөөд уулзалтын талаар мэдээлэл өгөхийг санал болгоорой.
- ➔ Ятгах
 - Боловсон бөгөөд хүндэтгэсэн өнгө аясыг хадгалж бай
 - Эсрэг нотолгоо, маргаанд нээлттэй, бэлэн бай. Нотлохыг оролдож эсвэл сөргөлдөх хэрэггүй.
 - Өөрийн санаан дээр тогт. Хэрэв сонирхогч тал тань хэтэрхий их ярьж байвал ярилцлагыг эргээд өөрийн санаа руу чиглүүлэх аргыг хай.
 - Зөв нотолгоог ашигла. Сонирхогч талыг тань логик нотолгоо итгүүлэх үү? Статистикийн тоо баримтууд итгүүлэх үү? Хувийн үйл явдлууд итгүүлэх үү?
 - “Хэлэлцээг хаах” – Хүсэлт шаардлага тавьж дуусаад сонирхогч талынхаа хариуг сонссоны дараа тусгай үйл ажиллагааг хүсээрэй. Жишээ нь хэрэв та шийдвэр гаргагчийн өгөх саналыг (санал хураалт дахь) баттай гэдгийг нь тодотгож батлаарай. “Тэгэхээр, бусаддаа таныг бидний төлөө саналаа өгнө гэдгийг бодолцож болохыг хэлж болох уу “ гэх мэтээр бататгаж болно.
 - Хамгийн багаар бодоход сонирхогч талд тань “үгүй” гэж хэлэхэд хэцүү байх болно.
- ➔ Уулзалтын явцад дараах зөвлөгөөнүүдийг санаж яваарай:
 - Цаг баримтал.
 - Нэг зүйл дээр хэт удаан цаг бүү зарцуул.
 - Энгийн бай.
 - Тэмдэглэл хөтөл.
 - Хэт их нотлох баримт ашиглахгүй эсвэл өөрийн санаагаа тулгахгүй бай.

Лоббидох уулзалтын дараа

Лоббидох уулзалт нь өөрөө төгсгөл биш юм. Үүнийг дараах үйл ажиллагаануудтай холбох хэрэгтэй.

- ➔ Төлөөлөгчдийн бүрэлдэхүүний сэтгэгдлийг сонсох: Уулзалт хэрхэн явагдав? Та юу сонссон бэ? Дараагийн алхам юу вэ?
- ➔ Хийж буй зүйлтэйгээ холбох. Хамтрагч нар болон бусаддаа мэдээлэх.
- ➔ Харилцаа холбоо хадгалах
 - Сонирхогч талдаа талархсан захидал явуулах
 - Санал болгосон эсвэл шаардсан мэдээг илгээх
 - Уулзалтад оролцох боломж олгосон бусад гишүүдэд талархсан захидал илгээх
- ➔ Тэмдэглэх - Чухал сонирхогч талтай уулзах бүрт энэ нь таны хувьд суралцах, өөртөө итгэлтэй болох боломж олгодгийг санаж яваарай. Энэ сонирхогч талын нүдэнд таны итгэлтэй байдлыг харуулна.

5.4 Сургалт семинар зохион байгуулах

Хүүхдийн хөдөлмөрийн нөлөөллийн үйл ажиллагаанд сургалт семинар зохион байгуулах замаар зорилтот бүлгийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, идэвхжүүлэх аргыг өргөнөөр ашигладаг.

Сургалт семинар зохион байгуулахад:

- ➔ Зорилтот бүлгийн мэдлэг ойлголт хандлагыг судалж сургалтын хэрэгцээг тодорхойлох,
- ➔ Сургалтын хөтөлбөр боловсруулах
- ➔ Гарын авлага, тараах материал боловсруулах, олшруулах,
- ➔ Шаардлагатай тохиолдолд багш мэргэжилтнүүдийн баг бүрдүүлж ажиллах
- ➔ Шаардлагатай бол сургагч багш бэлтгэх
- ➔ Сургалтын зар урилгыг зорилтот бүлэгт хүргэх
- ➔ Сургалтын байр, хэрэглэгдхүүнийг бэлтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хүүхдийн хөдөлмөрийн үйл ажиллагаанд хөдөлмөр эрхэлж байсан хүүхдүүдээс үе тэнгийн сургагч багш бэлтгэж сургалт явуулах аргыг ашигладаг туршлага байна.

Шигтгээ

ОУХБ-ын АЙПЕК хөтөлбөрийн дэмжлэгтэй Улаанбаатар хот болон Баянхонгор, Өвөрхангай, Дорнод, Дорноговь, Төв аймгуудад туршилтын төслийг хэрэгжүүлж “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдтэй тэмцэх нийслэл, аймгийн дэд хөтөлбөрүүд боловсруулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. Туршилтын төслүүдийн хүрээнд хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд, тэдний эцэг эхчүүд, ажил олгогчид, хөдөлмөрийн байцаагч, цагдаа, хүүхдийн байгууллагын болон орон нутгийн захиргааны ажилтнууд, нийгмийн ажилтнууд нарт сургалтуудыг өргөнөөр зохион байгуулж хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэхэд анхааран ажиллаж байна.

Жишээ нь:

- Нийслэлд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохицуулах, чадавхийг бэхжүүлэх нь төслийн хүрээнд нийслэл, дүүргийн удирдлага, хороо, сургуулийн нийгмийн ажилтнуудад хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар сургалт зохион байгуулсан.
- Дорнод аймагт “Хүүхдийн хөдөлмөр ба таны оролцоо” сургалтыг аймаг сумын засаг дарга, ЗДТГ, хөдөлмөр, мэргэжлийн хяналтын зэрэг холбогдох агентлагуудын ажилтнууд, хүүхдийн элч нарыг хамруулан хийсэн.
- Ажил олгогч эздийн холбооноос “Ажил олгогч ба хүүхдийн хөдөлмөр” сургалтыг зохион байгуулжээ.

Эх сурвалж: “Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар нөлөөллийн ажил явуулах арга зүй” сургалтын хэлэлцүүлгээс УБ 2008

5.5 Эцэг эхчүүдэд нөлөөлөх нь

Хөдөлмөр эрхэлдэг болон хөдөлмөр эрхлэх эрсдэлтэй хүүхдийн эцэг эхчүүд, асран хамгаалагчид нь хүүхдийг хөдөлмөр эрхлэхээс урьдчилан сэргийлэх, хөдөлмөр эрхэлдэг бол үүнээс хөндийрүүлэхэд нөлөө үзүүлэх нөлөөллийн гол зорилтот бүлэг болно.

Эцэг эхчүүдэд нөлөөлөл үзүүлэхэд ашиглах гол арга техник нь тэдний ойлголт мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэнэ. Эцэг эхчүүдэд хүүхдээ сургуульд явуулж боловсрол эзэмшүүлэх хэрэгцээ, ач холбогдлыг ойлгуулах, хүүхдээ эрсдэлд оруулж байгааг ойлгуулах нь тустай. Эцэг эхчүүдтэй ажиллахын тулд:

- Гэр бүлийн амьдралын нөхцөл байдлыг мэдэх, тэдний ойлголт хандлага, төсөөллийг олж мэдэх,
- Эцэг эхчүүдийн сэдлийг олж мэдэх,
- Боловсрол мэдээллийн үйлчилгээ боломжтой эсэхийг мэдэх,
- Хүүхдийг хэрхэн ажилд элсүүлдэг талаар тэднээс асууж судлах хэрэгтэй.

Эцэг эхчүүд, асран хамгаалагчидтай ажиллахад дараах арга техникүүдийг ашиглаж болно.

- Уулзалт зохион байгуулж бүлгээр хэлэлцүүлэг хийх,
- Плакат сурталчилгааны материал ашиглах
- Сургалтад хамруулах
- Нөлөөллийн илгээмжийг тодорхой кейс ашиглан хүргэх
- Хүүхдүүдийг өөрсдийг нь оролцуулах
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглах гэх мэт аргуудыг ашиглана.

Шигтгээ

Манайх ам бүл 9. 12-15 насны 2 хүүхэд шороо угаадаг. Хүүхдээ тун ч буруу юм руу явуулж байгаагаа ойлгож байна. Хүүхэд сургуулиас хөндийрөөд юм мэдэхгүй, мунхаг болчих юм. Зохих боловсролгүй хүн чинь олны дунд байж, олонтой харьцаж чадахгүй юм. Цаашдаа яана даа гэж санаа зовж байна. Яаж ийж байгаад эднийгээ боловсролтой болгох, эрүүл мэндийг нь сайжруулахсан гэж бодож явна даа.

Өвөрхангай аймгийн Уянга сумын иргэн М-ийн ярианаас

Эх сурвалж: Өвөрхангай аймгийн Хүүхдийн төлөө төв. "Өвөрхангай аймаг дахь хүүхдийн хөдөлмөрийг устгахад чиглэсэн орон нутгийн нэгдмэл үйл ажиллагаа" хөтөлбөрөөс гаргасан "Таны сонин" хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх мэдээллийн хуудас. 2007 он

Шигтгээ

Налайх дүүргийн ЗДТГ-аас эцэг эхчүүд, иргэдэд хандаж үр хүүхдээ хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, осол гэмтлээс хамгаалахад анхаарал тавьж хамтрахыг уриалж өрх гэрүүдэд захидал илгээсэн туршлага байна.

ИРГЭН ТАНД ХҮРГЭХ ЧИН СЭТГЭЛИЙН ЗАХИДАЛ

Эрхэм хүндэт эцэг эхчүүд асран хамгалаагч, багш сурган хүмүүжүүлэгчид ээ. Таны амар амгаланг айлтган мэндчилье.

Монгол улсын ирээдүй болсон хүүхэд багачууд маань хэрхэн эрдэм боловсролтой, өв тэгш хүмүүжилтэй эрүүл чийрэг бие бялдартай иргэн болж төлөвшихөөс “Айл өрхийн сайн сайхан амьдрал”, Эх орны хөгжил цэцэглэлт” хамаарна. Энхрий бяцхан үрс, хүүхэд багачууддаа хандах хараа хяналт, хайр халамж суларснаас хүүхдийн өвчлөл, золгүй тохиолдол /гал, усны аюул, төрөл бүрийн шалтгаант бүтэлт, гэмтэл, гэмт хандлага/ гарч хүүхдийн амь нас зуурдаар эрсдэх болсон нь олныг сэрдхийлгээсэн, сэтгэл эмзэглүүлсэн харамсалтай явдал болж байна.

Иймд хүүхэд багачуудаа:

- Уурхайн болон бусад хүнд хөдөлмөр эрхлүүлэхгүй байх
- Гал усны аюул
- Аливаа хүчирхийлэл
- Болзошгүй аюул
- Болгоомжгүй үйлдэл зэрэг аливаа ослоос нүдний цөцгий мэт хамгаалж, хайр халамжаар дутаалгүй Эх орон, аав, ээждээ энэрэлтэй амьдралын гярхай ухаанд сургаж, өсгөн хүмүүжүүлэхэд нь та бүхэн өөрсдийнхөө болон айл хөршийнхөө оролцоог идэхжүүлэн “Айл хүний амь нэг, саахалт айлын санаа нэг” монгол ардын зүйр үгийг амьдралдаа хэрэгжүүлж хамтран ажиллахыг уриалж энэ захидлыг илгээв.

Та бүхэнд элгээрээ энх амгалан, төрлөөрөө түвшин амгалан байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

Хүндэтгэсэн:

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА

Ш.ЭНХСАЙХАН

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ, ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ
ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ц. МИНЖИНХҮҮ

Монголчуудын хүүхдээ сурган хүмүүжүүлдэг 10 зарчим

1. Хүүхдээ зөв хайрлах
2. Хүүхдээ хамгаалж явах
3. Хүүхдэдээ амьдрах ухаан заах
4. Хүүхдэдээ сайнаар нөлөөлөх
5. Хүүхэдтэйгээ хамтран ажиллах
6. Хүүхэдтэйгээ хамт тоглож наадах
7. Хүүхдээ зөөлөн чихтэй, сониуч өсгөх
8. Хүүхдээ дууриах юмтай амьдарч сургах
9. Хүүхдээсээ амьралын эрээн барааныг үл нуух
10. Өрх гэр, төр улсын ёс заншлыг зааж өгөх эдгээр болой

5.6 Хэвлэмэл материал ашиглах арга



Аргачлал 5.4 Зураг үзүүлэн бэлтгэх аргачлал

Сурталчилгааны материал гэдэгт танилцуулга, товхимол, зурагт хуудас, мэдээллийн хуудас зэргийг оруулна. Сурталчилгааны материал боловсруулахын тулд та дараах асуудлыг анхааралдаа авч үзэх нь чухал байдаг. Үүнд:

1. Мэдээллийн зорилгоо тодорхойлох.

Хэнд хандах вэ?

Мэдээллийн зорилго юу вэ?

Хүргэх гол илгээмж юу вэ?

2. Формат хэлбэрээ сонгох

Ямар төрлийн сурталчилгааны материал сонгох вэ?

Ямар хэлбэртэй хийх вэ?

Өртөг зардал ямар болох вэ?

3. Зорилтот бүлэгтээ хандан бичих

Ямар жишээ, тоо баримт, эмблем, зураг ашиглах вэ?

Ямар үг хэллэг хэрэглэх вэ?

Ямар мэдээлэл бичих вэ? (хандах байгууллага, хүний нэр, утас, хаяг г.м)

4. Сурталчилгааны материалын дизайныг гаргах

Уншихад хялбар байна уу?

Танилцуулга, товхимолын хувьд 11-12 үсгийн хэмжээтэй текст ашиглах боломжтой байдаг. Харин зурагт хуудас, мэдээллийн хуудас хийхэд амархан уншигдах, том хэмжээгээр, дармалаар, харлуулж бичсэн байх шаардлагатай бөгөөд бичмэл текст тохиромжгүй байдаг.

Мэдээллийн зорилгыг илэрхийлсэн, сонирхол татах, чанарын шаардлага хангасан зураг дүрс ашигласан уу? Учир нь чимэглэл төдий зураг дүрс ашиглах нь тохирохгүй байна.

Сурталчилгааны материалын хэв загвар, дизайн ямар байна вэ?

Танай байгууллага, хөтөлбөрийг төлөөлөх сурталчилгааны материал ижил форматтай, ижил өнгөтэй байх нь зүйтэй бөгөөд хэн ч, хэзээ ч харахад танихуйц байхаар хийх.

5. Хөндлөнгийн хүнээр хянуулах

Боловсруулж бэлтгэсэн сурталчилгааны материалаа хөндлөнгийн хүнээр сайтар уншуулж хянуулав уу?

Илгээмж ойлгомжтой байна уу?

Байгууллага, хүний нэр, тоо мэдээлэл, он сар өдөр, утас хаягийг зөв бичсэн байна уу?

6. Сурталчилгааны материалаа хэвлүүлэх

Ямар төсөвт багтааж хэвлүүлэх болон олшруулах вэ?

Хэн санхүүжүүлж тусалж болох вэ?

7. Сурталчилгааны материалаа түгээх

Зорилтот бүлэгт ямар арга замаар түгээх вэ?

Зорилтот бүлэгт хүртээмжтэй болгоход хэн туслах вэ?

Сурталчилгааны материалын мэдээллийг хүмүүст хэрхэн

хүргэх вэ? Хэнд, ямар хаягаар, хэрхэн хүргэх вэ?

Хэвлэлийн бага хурал, уулзалт цуглаан, хүлээн авалт хийх үү

уралдаан тэмцээн зохиох уу?



5.6.2 Хүүхдийн фото зураг ашиглахад ёс зүйн ямар шаардлага тавигдах вэ?

- ➔ Хүүхдээс зөвшөөрөл авах шаардлагатай. Зөвшөөрөл авахдаа
- ➔ Зургийг хэрхэн, хаана, ямар зорилгоор ашиглах
- ➔ Хэнд зориулж ашиглах
- ➔ Ямар илгээмж өгөхөд ашиглахаа тайлбарлана.
 - Зургийн болон хэвлэгдсэн материалын хувийг хүүхдэд заавал өгөх
 - Тэднийг “ҮГҮЙ” гэж хэлбэл шууд хүлээн авах
 - Зургийг хэвлэснээр гарах бодит үр дагаврыг тайлбарлах, худал амлалт өгч болохгүй
- ➔ Ямар нэг зүйл амласан бол биелүүл /ялангуяа хүүхдэд/
- ➔ Дараах үйлдлийг хориглоно Үүнд:
- ➔ Хүүхдийн өмнөөс насанд хүрсэн хүний зөвшөөрлийг авах
- ➔ Урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр хүүхэд эсвэл томчуудтай сэтгүүлчийг уулзуулах

Ямар фото зургийг ашиглаж болохгүй вэ?

- ➔ Хүүхдийн нүүр, царай танигдахуйцаар гарсан
- ➔ Хууль бус үйл ажиллагаанд оролцож буй хүүхдийг /тухайлбал биеэ үнэлэхэд оролцдог/ ямар нэг байдлаар танигдахуйцаар илэрхийлэх: үүнд: зургийг хаана, ямар орон нутагт авсныг бичих, тэдний үйлчлүүлэгч, орон нутгийн хүнийх нь нэрийг бичих гэх мэт
- ➔ Хүүхдийн зургийг хэвлэхдээ олон нийтэд сөрөг ойлголт өгөхөөр нэрлэх: жишээ нь “ДОХ-ын улмаас өнчирсөн хүүхэд” гэх мэт
- ➔ Хүүхдийн зургийн дор өөр хүүхдийн болон өөр орон нутгийн нэр, өөр хүүхдийн түүхийг бичиж хэвлэх
- ➔ Хүчирхийлэл, дарамтанд байгаа хүүхдийн зургийг зориудаар авсан, жишээ нь хөлөндөө гинжтэй “боолчлогдсон” хүүхдийн зургийг авах

5.7 Олон нийтийн дайчлах нь

5.7.1 Олон нийтийг дайчлах аргууд

Арга	Бүрэлдэхүүн хэсэг	Үр ашиг	Дутагдалтай тал
Олон нийтийн уулзалт	➔ Хүмүүс хамтдаа мэтгэлцэнэ. ➔ Шийдвэр гаргагчид олон нийтийн асуултанд нээлттэй байна. ➔ Хүн бүр оролцож болно.	➔ Сайн сурталчилгаа болж болно. ➔ Шийдвэр гаргагчид үзэл бодлыг шууд сонсоно. ➔ Хэлэлцэх боломж олгоно.	➔ Зохион байгуулахад цаг хугацаа болон зардал их шаардана. ➔ Бутрал болон сөргөлдөөнд хүргэж болно.
Жагсаал, эсэргүүцлийн цуглаан	➔ Бүлэг хүмүүс цугларч шийдвэр гаргагчдад үзэл бодол болон эсэргүүцлээ илэрхийлнэ.	➔ Хүмүүст илэрхий ихээхэн хүчтэй нөлөө үзүүлж болно. ➔ Хэвлэл мэдээллээр сайн мэдээлдэг.	➔ Хүчирхийлэл гарч болзошгүй. ➔ Сөргөлдөөнтэй үед шийдвэр гаргагчдад дуу хоолой хүрэхгүй байж болно.
Шийдвэр гаргагчтай хийх уулзалт	➔ Бүлэг хүмүүс шийдвэр гаргагчид, орон нутгийн удирдлагатай уулзаж гол илгээмжээ хүргэдэг.	➔ Шийдвэр гаргагчид хүмүүсийн үзэл бодлыг шууд сонсдог. ➔ Компанит ажил явуулах орон нутгийн дэмжлэг бий болно.	➔ Илгээмжийг зохицуулахад хүндрэлтэй.
Хэвлэлийн бага хурал, илтгэл материал бэлтгэх	➔ Компанит ажлын зэрэгцээгээр гол төлөв бодлогын зөвлөмж бүхий баримтуудыг үзүүлдэг.	➔ Дэмжигчид болон шийдвэр гаргагчдад итгэл төрүүлдэг. ➔ Бусад хүмүүст ойлголт мэдлэг олгоно.	➔ Зохион байгуулахад цаг хугацаа болон зардал их шаардана. ➔ Материалыг уншихгүй байж болох талтай.
Хэвлэл мэдээллийн анхаарлыг татах үйл ажиллагаа	➔ Хэвлэл мэдээллийн анхаарлыг өөрсдийн асуудалд хандуулахад чиглэсэн тоглолт зохион байгуулах	➔ Хэвлэлийнхний анхаарлыг сайн татна. ➔ Олон нийт болон шийдвэр гаргагчдад илгээмжийг хүргэнэ.	➔ Хэт санал зөрөлдөөнтэй байвал олон нийтэд таагүй мэдрэмж төрүүлнэ.

Сонин	➔ Сонирхогч талдаа мэдээллийг тогтмол хүргэх	➔ Өнөөгийн байдлын талаар мэдээллийг хүмүүст хүргэнэ. ➔ Мэдээлэл болон үйл ажиллагааны өөр хувилбарын талаар тогтмол мэдээлнэ.	➔ Цаг хугацаа болон зардал их шаардана.
Ил захидал, гарын үсэг цуглуулах	➔ Хүмүүс шийдвэр гаргагчдад ил захидал бичих болон гарын үсэг цуглуулж илгээх	➔ Хурдан ба хийхэд амархан. ➔ Олон хүмүүс оролцоно. ➔ Олон нийтийг дайчлаж эхлэх сайн боломж юм.	➔ Шийдвэр гаргагчид үгүйсгэж болзошгүй.
Шийдвэр гаргагчдад захидал бичих	➔ Хүмүүс шийдвэр гаргагчдад хандан захидал бичих	➔ Захидлыг шийдвэр гаргагчид олон нийтийн санааг зовоож байгаа зүйлийн илрэл гэж үздэг.	➔ Бусад компанит ажлаас ялгахад хүндрэлтэй.
Интернетэд суурилсан компанит ажил	➔ Шийдвэр гаргагчдад гарын үсэг цуглуулах болон захидал илгээх	➔ Байрлуулахад хялбар. ➔ Уян хатан. ➔ Олон хүнийг оролцуулах боломжтой.	➔ Интернет хүртээмжгүй хүмүүс оролцохгүй. ➔ Шийдвэр гаргагчид үгүйсгэж болзошгүй
Үзэсгэлэн	➔ Ойлголт мэдлэгийг нэмэгдүү-лэхийн тулд хүн олон цуглардаг газар зохион байгуулдаг. ➔ Хэвлэл мэдээллийн анхаарлыг татах үйл ажиллагаатай холбох.	➔ Гэрэл зураг, видео, аудио зэрэг нь хүмүүст санал бодлоо илэрхийлэх сайн боломж олгодог.	➔ Цаг хугацаа их шаардана. ➔ Байгаль цаг уурын нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай байдаг.
Бойкот	➔ Тодорхой нэгэн компанийн бүтээгдэхүүнийг худалдан авахаас татгалзах	➔ Өөрчлөлтөнд эерэг нөлөө үзүүлэх боломжтой. ➔ Хэвлэл мэдээллээр сайн мэдээлдэг.	➔ Цөөхөн хүн оролцвол үр ашиг багатай.

5.7.2 Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэхэд компанит ажил зохион байгуулах нь

Гарын үсэг цуглуулах, үүнийг өргөн барих үйл ажиллагааг хүүхдийн хөдөлмөртэй тэмцэхэд зарим тохиолдолд ашигладаг. Компаний захиралууд эсвэл засгийн газрын бодлого боловсруулагчдад олон нийт захидал бичих, гарын үсэг цуглуулах эсвэл өөр хэлбэрээр дэмжлэгээ илэрхийлж болно. Эдгээр үйл ажиллагаа нь тухайн асуудалд нөлөөлөх боломжтой хүмүүст энэ компанит ажлыг хир олон хүн дэмжиж байгааг харуулах, тэднийг хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх үйл ажиллагаанд оролцуулах, олон нийтийн энэ асуудалд хандах хандлагыг өөрчлөхийг зорьж байгаагаа илэрхийлэх зорилготой.

Зарим жишээг дурдвал:

- Хүүхдийн Хөдөлмөрийн Эсрэг Олон Улсын Хөдөлгөөн байгууллагаас 1997-1998 онуудад хүүхдийн хөдөлмөрийг эсэргүүцэн 7 сая хүний эрхий хурууны хээг цуглуулжээ.
- Цэвэр Хувцас компанит ажлаар жижиглэн худалдаа эрхлэгчдэд үйл ажиллагааны хэм хэмжээгээ хэрэгжүүлэхийг шаардан гарын үсэг, ил захидал цуглуулжээ.
- 2003 онд Швецарь улсад хүүхдийг хил давуулан худалдаалах явдал нь хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэг хэмээн хуулинд тусгуулахын төлөө гарын үсэг цуглуулах үндэсний компанит ажил эхэлжээ.
- АНУ-ын оюутны хотхоны идэвхтэнүүд үйл ажиллагааны хэм хэмжээг хүндэтгэхгүй байгаа компаниудад захидал бичих, гарын үсэг цуглуулах ажлыг оюутнуудын оролцоотойгоор тогтмол явуулдаг байна.

Sailkot: Олон улсын шахалтын үр дүнд нэгэн корпорацийн явуулсан үйл ажиллагаа

Хөл бөмбөг бол дэлхийд хамгийн алдартай спортын төрөл бөгөөд нэг жилд дэлхий даяар 40 сая бөмбөг зарагддаг. Гар аргаар оёсон бөмбөгний 75%-ийг Пакистаны Сайлкотод үйлдвэрлэдэг. Хөл бөмбөг үйлдвэрлэх гэх мэт спортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хүүхдийн хөдөлмөрийг ашигладаг тухай мэдээ, тайлан 1995 онд анх удаа гарчээ. 1996 онд Олон Улсын Хөдөлмөрлөх Эрхийн Сан ба ОУХБ-аас ЮНИСЕФ, Хүүхдийн Ивээх Сан /Их Британи/, Сайлкотын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим зэрэг байгууллагуудтай хамтран Сайлкот мужийн тосгонуудад хүүхдүүд өдрийн турш бөмбөг оёж дэлхийн зах зээлд гаргаж байгаад олны анхаарлыг хандуулах зорилгоор компанит ажлыг зохион байгуулжээ. ОУХБ-аас Сайлкот мужид хийсэн судалгаагаар 5-14 насны 7000 Пакистан хүүхдүүд өдрийн турш бөмбөг оёдог, эдгээрийн зарим нь өдөрт 10-11 цаг ажилладаг гэжээ. Маш олон хүүхэд хичээлийн бус цагаар ийм хөдөлмөр эрхэлдэг байна.

Энэ судалгаанд үндэслэсэн компанит ажил нь дэлхийн олон хөл бөмбөгчдийг хамарсан ба 1997 оны 12 сард хэрэгжиж дууссан. Залуучуудын хөл бөмбөгийн лиг, хотын захиргаа болон бусад сонирхогч бүлгүүд хамтран хүүхдийг хөл бөмбөг үйлдвэрлэхэд ашиглахыг хориглох шийдвэр гаргахын төлөө ажилласан. Энэ үйл ажиллагааны үеэр хөл бөмбөг үйлдвэрлэлд мөлжлөгийн чанартай хүүхдийн хөдөлмөрийг ашиглаж буй талаар хэвлэл мэдээллийг хэрэгслээр өргөн цацсан. Жишээ нь 1996 оны 6 сард Европын хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээний өмнөх орой энэ эвсэлээс Пакистаны 9 настай хүүхэд Олон Улсын Хөл бөмбөгийн Холбоо /FIFA/ болон Европын Хөл бөмбөгийн Холбоодын эвслийн логотой хөл бөмбөгийг оёж байгаа тухай богино хэмжээний киноны нээлтийг хийсэн. Сайлкотын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, ОУХБ, ЮНИСЕФ-ийн хооронд энэ асуудлын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хамтран хэрэгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагааны төлөвлөгөө байгуулсан. Энэ гэрээний

зорилго нь Пакистаны хөл бөмбөг үйлдвэрлэх салбарт хүүхдийн хөдөлмөрийг устгах, энэ ажлыг хийж байсан хүүхдүүдийг өөр салбарт шилжин ажиллуулахгүйн тулд боловсрол олгох боломжийг бүрдүүлэх явдал байв. Хөл бөмбөг үйлдвэрлэгчдээс оёдлын төвүүд болон ажиллагсдаас мэдээлэл цуглуулах, дотоод хяналтыг хэрэгжүүлэхийг шаардсан. Нэр алдартай 50 гаруй үйлдвэрлэгчдээс бүрдэх Дэлхийн Спортын Бараа Үйлдвэрлэгчийн Холбооноос энэ компани ажлыг үргэлжлүүлэн явуулсан ба 1998 онд Олон Улсын Хөл бөмбөгийн Холбооноос Хөдөлмөрийн үйл ажиллагааны хэм хэмжээг боловсруулан гаргасан. Энэхүү баримт бичгийг үйлдвэрчний байгууллагуудаас шинэлэг үйл ажиллагаа хэмээн сайшаасан бөгөөд энэ баримт бичгийн дагуу хүүхдийн хөдөлмөрийг ашиглан үйлдвэрлэсэн хөл бөмбөгөн дээр Олон Улсын Хөл Бөмбөгийн Холбооны албан ёсны тамга тавихыг хориглосон ба энэхүү хэм хэмжээний хэрэгжилтэнд мониторинг хийх,, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох болсон байна.

Эх үүсвэр: ОУХБ. Хүүхдийн хөдөлмөр : Их дээд сургуулийн оюутнуудад зориулсан сурах бичиг. УБ 2007

5.7.3 Бойкот буюу хориг тавих

Хамтын хүчээр явуулж болох үйл ажиллагааны нэг хэлбэр бол бойкот буюу хориг тавих үйл ажиллагаа юм. Хориг тавих гэдэг нь компани ажлын шаардлагыг биелүүлэхгүй байгаа компани эсвэл улс оронд үйлдвэрлэсэн барааг худалдаж авахгүй байхыг хэрэглэгчдээс уриалахыг хэлнэ. Хүүхдийн хөдөлмөрийн хувьд, бойкотыг санхүүжүүлэгчид нь өөрийн үйлдвэрлэлийн үйл явцад хүүхдийн хөдөлмөрийн устгах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй компаний ямар ч бүтээгдэхүүнийг худалдан авахгүй байхыг хэрэглэгчдэд санал болгодог. Хэрэв аль нэг улс орон хүүхдийг багаасаа ажил эрхлэх аюулаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хууль тогтоомж гаргаагүй /эсвэл хэрэгжүүлэхгүй/ байвал тухайн улс орны эсрэг хориг тавих тохиолдол ч бий. Зарим хувь хүмүүс ийм том хэмжээний үйл ажиллагаанд албан ёсоор оролцоогүй боловч ёс зүйг баримтлах үүднээс тодорхой барааг худалдан авахгүй байх шийдвэрийг өөрсдөө гаргаж болно.

Хориг тавих үйл ажиллагаа нь аливаа компани /эсвэл улс орон/ зах зээлээ алдахгүй байхыг эрхэмлэдэгтэй холбоотой. Зах зээлээ алдахгүй байх эрмэлзэл нь тухайн компанийг өөрийн болон гэрээт гүйцэтгэгчдийнхээ үйлдвэрлэлд оршиж байгаа хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг шийдэхэд хүргэнэ гэж зохион байгуулагчид үздэг. Иймээс хориг тавих үйл ажиллагааны явцад хэрэглэгчдээс тухайн компаний бүтээгдэхүүнийг худалдан авахгүй байхыг уриалахаас гадна тухайн компаний удирдлагад мэдээлэх, хэвлэл мэдээллээр цацах зэргээр тухайн компанид мэдэгдэх шаардлагатай байдаг. Компани ажил амжилттай болвол тухайн компаний борлуулалт унаж, санхүүгийн алдагдалд орох ба олон улсын хэмжээнд нэр хүндээ алдахад хүрдэг.

Хориг тавих үйл ажиллагаа нь хүүхдийн хөдөлмөртэй тэмцэхэд их үр дүнтэй арга гэж тооцогддоггүй. Хориг тавих үйл ажиллагаа нь зөвхөн экспортын салбарт анхаарлаа хандуулдагаас энэ салбарт ажилладаг хүүхдүүдийг ажилгүй болгож, улмаар албан бус салбарт ажиллуулахад хүргэдэг учир тэдэнд болон гэр бүлд улам муугаар нөлөөлдөг гэж зарим хүмүүс үздэг. Ийм учраас хориг тавих аргаас нийгмийн хариуцлагатай байдлын илэрхийлэл болсон “хариуцлагын шошго” олгох болон хувийн секторын аж ахуйн нэгжүүдтэй шууд тулж ажиллахыг илүүтэйд үзэх болжээ.

Шударга Худалдааны санаачилга ба Нийгмийн хариуцлагын шошго

Хэрэглэгчдийн явуулж болох үйл ажиллагааны өөр нэг хэлбэр бол шударга хөдөлмөрийн стандартын дагуу үйлдвэрлэгдсэн гэж бүртгэгдсэн бүтээгдэхүүнийг худалдан авах явдал юм. Шударга худалдааны төлөө хөдөлгөөн нь 1980-аад оноос эхэлсэн бөгөөд хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хоорондын худалдаанд нийгэмд чиглэсэн хувилбарыг хэрэгжүүлж болно гэдгийг харуулахыг зорьсон.

Шударга худалдааны төлөөх хөдөлгөөн нь хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх үйл ажиллагаанд чухал үүрэгтэй. Учир нь үйлдвэрлэл явуулахтай холбоотой асуудлууд энд тусгагддаг. Шударга худалдааны төлөө сүлжээнээс зарж буй бараа бүтээгдэхүүн нь хүүхдийн хөдөлмөрийг ашигладаг орон нутгаас ирсэн байж болох боловч бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хүүхдийн хөдөлмөрийг ашиглаагүй байдаг. Эдгээр бүтээгдэхүүн нь дэлгүүрт зарагдаж буй бусад бараатай бараг ижил байдаг.

Шударга Худалдааны бүтээгдэхүүн нь үйлдвэрлэсэн аргачлалаараа ялгаатай. Энэхүү аргачлалыг Европын 12 томоохон Шударга худалдааны бүтээгдэхүүн импортлогч байгууллагуудаас бүрдсэн Европын Шударга Худалдааны Нийгэмлэг (EFTA)-ээс гаргасан ба тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд хүүхдийн хөдөлмөрийг ашиглаагүй, мөн түүнчлэн насанд хүрэгчдийн цалин хөлс, ажлын нөхцөл шударга байсан гэдэг баталгаа болж өгдөг. Энэ нь үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж ашиглан үйлдвэрлэсэн болон жижиг цех, үйлдвэрт гэрээгээр хийлгэсэн бүтээгдэхүүний аль алинд нь хамаарна.

Шударга хөдөлмөрийн асуудлын хүрээнд хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх үйл ажиллагаа нь үйлдвэрлэгчдээс шударга хөдөлмөрийн стандартыг баримталж буй эсэхэд хяналт тавихад чиглэдэг. Хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь насанд хүрсэн ажиллагсадад шударга цалин хөлс олгох замаар хүүхдийн хөдөлмөрөөс олох орлогоос хараат бус болгоход чиглэгдэнэ. Түүнчлэн хүүхдийн боловсролын асуудлыг чухалд авч үздэг. Шударга худалдааны бүтээгдэхүүн нь хөгжингүй орнуудын ихэнх хотууд болон хүнсний төрөлжсөн дэлгүүрүүдэд хүрч очсон.

Макс Хавелаар: Шударга худалдаа эрхэлдэг фирм

Европын ихэнх орнуудад түүнчлэн хойд Америкт Макс Хавелаар гэсэн шошготой бүтээгдэхүүн элбэг тааралддаг. Макс Хавелаарын кофений саван дээр наах зориулалт бүхий шударга худалдааны шошго бий болгосноор хэрэглэгчдэд энэхүү кофег жижиг фермээс зах зээлийн үнээс өндөр үнээр авсан гэдгийг баталгаажуулах зорилготой байсан. Энэ шошгыг одоогоор Шударга худалдааг баталгаажуулах олон улсын байгууллага буюу англиар Fairtrade Labelling Organizations International (FLO)-ын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний стандартад ашигладаг. (FLO) нь 40 гаруй орны 800 гаруй үйлдвэрлэгчдэд шударга худалдааны шошгоос ашиг хүртэх эрх өгчээ. (энэ талаар www.fairtrade.net хуудаснаас харна уу?) FLO-оос тавьж буй шаардлага нь ОУХБ-ын Албадан хөдөлмөрийн тухай 29-р конвенци /1930/ болон Хөдөлмөрлөх насны доод хязгаарын тухай 138-р конвенцид суурилсан байдаг.

Энэхүү шошго нь олон төрлийн бүтээгдэхүүнд хэрэглэгддэг. Үүнд: кофе, цай, шоколад, жимс, цагаан будаа, зөгийн бал, элсэн чихэр, цэцэг гэх. Мэт. Энэ шошгыг агуулсан бүтээгдэхүүн нь (FLO)-ын стандартын дагуу хүүхдийн хөдөлмөрийг мөлжихгүйгээр үйлдвэрлэсэн болохыг баталгаажуулж өгдөг.

Эх үүсвэр: ОУХБ. Хүүхдийн хөдөлмөр : Их дээд сургуулийн оюутнуудад зориулсан сурах бичиг. УБ 2007

Үүнтэй нягт холбоотой өөр нэг компани ажил бол **нийгмийн хариуцлагын шошго** юм. Зарим хэрэглэгчид хүүхдийн хөдөлмөрийг ашиглаагүй гэсэн “баталгаа”-тай бүтээгдэхүүн худалдан авахыг хүсдэг. Нийгмийн хариуцлагын шошго нь энэ баталгааг гаргаж өгөх нэг арга юм. Энэ шошгын зорилго нь худалдан авагчдад тэдний худалдан авч буй бүтээгдэхүүнийг нийгмээс хүлээн зөвшөөрсөн орчин нөхцөлд, тухайлбал хүүхдийн хөдөлмөрийг ашиглахгүйгээр үйлдвэрлэснийг баталгаажуулах явдал юм.

Abring сангаас 1992 онд эхэлсэн Бразил дахь “Хүүхдэд ээлтэй компани” хөтөлбөр нь хүүхдийн хөдөлмөрийг устгах, хүүхдийн амьжиргааг сайжруулах төсөлд хөрөнгө оруулахыг уриалдаг. Энэ шаардлагыг биелүүлсэн компани нь өөрийн бүх бүтээгдэхүүний сав баглаан дээр Хүүхдэд ээлтэй компани гэдэг тамга ашиглах эрх олж авдаг. Энэ тамгыг авахын тулд аливаа компани нь хүүхдийн хөдөлмөрийг ашиглахгүй хүүхдийг ажиллуулдаг хэн нэгэнтэй бизнес хийхгүй хүүхдийн сайн сайхан байдал, ажиллагсдын хүүхдийн халамж хамгаалал, боловсролд болон хүүхэд, өсвөр насныхны хамгаалалд чиглэсэн нийгмийн төслүүдэд хөрөнгө оруулах амлалт авдаг. Компаний энэ амлалтыг улс орон даяар сурталчилдаг.

Нийгмийн хариуцлагын шошго санаачилгуудаас хамгийн өргөн сурталчилагдсан, хүмүүсийн хамгийн сайн мэддэг хөтөлбөр нь “Хивсний шошго” хөтөлбөр юм. Rugmark гэдэг нь Энэтхэг болон Өмнөд Азийн бусад улс орны хивсний үйлдвэрлэл дэх хүүхдийн хөдөлмөрийг устгахын тулд хүүхдийн хөдөлмөрийг устгах, хүүхдийг нөхөн сэргээх, тэдэнд боловсрол олгох зорилготой олон улсын төрийн бус байгууллага юм.

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг Хивсний шошгоны хөтөлбөр

1970-аад онд Иранд хивсний үйлдвэрт хүүхдийг ажиллуулахыг хориглосны дараагаас Энэтхэг, Пакистан улсад гараар хивс нэхэх цехүүд эрс олиширчээ. 1982 онд хийсэн судалгаагаар эдгээр үйлдвэрийн ихэнх нь хүүхдийн хөдөлмөрийг ашигладаг гэдэг нь судалгаагаар тогтоогджээ. 1992 онд европ америкийн үйлдвэрчний, шашны болон хүний эрхийн байгууллага, хэрэглэгчдийн эрх ашгийг төлөөлөх бүлгүүд хамтран хэрэглэгчийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх компани ажлыг явуулснаар энэ нь компани ажил нь Энэтхэгийн эдийн засгийн чухал салбар болох хивсний үйлдвэрлэл дампуурч болзошгүй гэсэн айдас хүргэснээрээ маш том үр нөлөөтэй байсан. Хөгжлийн болон хүний эрхийн байгууллагууд Энэтхэгийн хивс экспортлогчид болон тэднээс бүрдсэн худалдааны нийгэмлэгүүд, ЮНИСЕФ зэрэг байгууллагууд хамтран хүүхдийн хөдөлмөрийг ашиглаагүйгээр гараар сүлжсэн хивсэнд тусгай шошго бий болгосон. Энэтхэгт хивс үйлдвэрлэгчид “Rugmark”-тай хүүхдийн хөдөлмөрийг ашиглахгүй, өөрсдийн бүх нэхмэлийн сууриудаа бүртгүүлнэ, хөдөлмөрийн байцаагчийг урьдчилан хэлэхгүйгээр ирэхэд ажлын байраа танилцуулна гэсэн гэрээтэй ажилладаг. “Rugmark” сангаас тусгай бэлтгэгдсэн байцаагчид авч ажиллуулдаг. Үйлдвэрийн бүх нэхмэлийн сууриуд бүртгэлтэй байх ба түүнээс гарсан хивс бүрийг хүүхдийн хөдөлмөрийг ашиглаагүй гэдгийг баталгаажуулдаг. Энэ шошго нь олон улсын хэмжээнд бүртгэлтэй ба энэхүү стандартын дагуу шалгагдсан бүтээгдэхүүн шошгыг ашиглах эрхтэй болдог.

Эх үүсвэр: ОУХБ. Хүүхдийн хөдөлмөр : Их дээд сургуулийн оюутнуудад зориулсан сурах бичиг. УБ 2007

5.7.4 Ёс зүйн хөрөнгө оруулалт

Ёс зүйн хөрөнгө оруулалт нь хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх чиглэлээр хувь хүмүүсийн оролцож болох үйл ажиллагааны нэг хэлбэр юм. Хувь хүмүүс өөрсдийн оруулж буй хөрөнгө оруулалтаа ёс зүйн хөрөнгө оруулалтын санд нэгтгэдэг. Энэ сангаас зөвхөн олон улсын хөдөлмөрийн стандартад нийцсэн үйл ажиллагааны хэм хэмжээ бодлого баримталдаг компаниудад л хөрөнгө оруулдаг. АНУ-д болсон Нийгмийн Хөрөнгө Оруулалтын Форумаас урьдчилсан шалгуур зааж өгөх, хувь эзэмшигчдээр дамжуулан нөлөөлөх, олон нийтийн хөрөнгө оруулалт гэсэн гурван стратегийг гаргасан. Урьдчилсан шалгуур зааж өгөх гэдэг нь “хөрөнгө оруулахдаа нийгмийн эсвэл байгаль орчны шалгуур үзүүлэлтийг үндэслэн хөрөнгө оруулах эсэхээ шийдэхийг хэлнэ. Нийгмийн чиг баримжаатай хөрөнгө оруулагчид нь ажиллагсадаа хүндэтгэдэг, сайн харилцаатай, орон нутгийн үйл ажиллагаанд оролцдог, байгаль орчны талаар сайтар боловсруулсан бодлого боловсруулан хэрэгжүүлэх туршлагатай, хүний эрхийг хүндэтгэдэг, аюулгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, ашигтай үйл ажиллагаа явуулдаг компанитай хамтарч ажиллахыг эрмэлздэг. Эдгээр шаардлагыг биелүүлж чадахгүй байгаа аж ахуйн нэгжид тэд хөрөнгө оруулахаас зайлсхийдэг” (<http://www.share.ca>). Хувь Нийлүүлэгчдийн Үйл ажиллагааны сүлжээ нь “Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулагчид болон хувь нийлүүлэгчдийг мэдээлэл, дүн шинжилгээгээр хангах зорилготой” (<http://www.shareholderaction.org>). Олон нийтийн хөрөнгө оруулалт нь АНУ-ын болон хөгжиж буй орнуудын орлого багатай орон нутгийнхны хөгжлийн үйл ажиллагаа, санаачилгыг дэмжих зорилготой. Энэ үйл ажиллагааны хүрээнд хувь хүмүүст орон байртай болох эсвэл нийгмийн хариулагатай бизнесийн үйл ажиллагааг эхлэхэд нь зээл тусламжийг олгодог.

Зарим компаниуд өөрсдийн бүтээгдэхүүнээ олон нийтэд сурталчилахад нийгмийн төслүүдийг ашигладаг. Ийм санаачилга нь нийгмийн олон асуудлыг шийдэхэд дэмжлэг үзүүлдэг ба түүний нэг нь хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх асуудал байдаг.

VI БҮЛЭГ

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАХ НЬ

БҮЛГИЙН ТОВЧ АГУУЛГА

- 6.1 Хэвлэл мэдээллийн хэрэгслийн онцлог юу вэ?**
- 6.2 Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх аргууд**
- 6.3 Хэвлэл мэдээллийн хэрэгслийг сонгох нь**
- 6.4. Хэвлэл мэдээллийнхэнтэй хамтран ажиллах нь**

6.1 Хэвлэл мэдээллийн хэрэгслийн онцлог юу вэ?

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл бол олон нийтэд мэдээлэл түгээх нэг хэлбэр юм. Хэвлэлийн эрх чөлөө оршин тогтнож буй нөхцөлд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь олон нийт, шийдвэр гаргагчид болон бусад олон янзын сонирхогч талуудад өөрсдийн мэдээллээ түгээх чухал арга зам нь болдог билээ. Гэвч хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг төр буюу хэн нэг нь эзэмшиж, хянах эсвэл хатуу шалгуур тогтоосон нөхцөлд мэдээллийн өөр хэрэгслийг ашиглах хэрэгцээ гарч болно.

Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд:

- телевиз,
- радио,
- сонин,
- сэтгүүлүүд
- цахим хуудсууд орно.

Ямар үед хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах вэ?

- ➔ Олон нийтэд асуудлынхаа талаар танилцуулан анхаарал хандуулах
- ➔ Олон нийтийн хандлагыг өөрчлөх
- ➔ Засгийн газрын бодлого, хууль тогтоомжид нөлөө үзүүлэх
- ➔ Үйл ажиллагаандаа зориулж хөрөнгө мөнгө цуглуулах
- ➔ Гишүүд, дэмжигчдийг элсүүлэх ажилд ашигладаг.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй ажиллахын ач холбогдол:

- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь олон нийт, төр захиргааны шийдвэр гаргагчид зэрэг олон чухал сонирхогч талд хүрч чаддаг.
- Хэвлэл мэдээллийн нөлөө их. Олонхи хүмүүс тэр бүр нийгмийн асуудлуудтай биечлэн тулгарч үзээгүй байдаг тул тодорхой асуудлын талаарх өөрийн мэдлэг болон байр сууриа хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олж авдаг.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь чөлөөтэй, үнэгүй байдаг тул эдийн засгийн хувьд хязгаарлагдмал бүлгийнхний хувьд их ач холбогдолтой мэдээллийн хэрэгсэл болдог.

6.2 Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх аргууд

Олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар нөлөөлөл хийхэд дараах аргыг ашиглаж болно.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх аргууд:

- ➔ Хэвлэлийн мэдээ бэлтгэх
- ➔ Хэвлэлийн бага хурал хийх
- ➔ Телевиз , радио, хэвлэлд ярилцлага өгөх
- ➔ Утсаар шууд ярилцлагад явуулах, оролцох
- ➔ Телевизээр илгээмжээ цацах
- ➔ Редакцид захидал бичих
- ➔ Тэргүүн өгүүлэлийн сэдвээр ярилцлага хийх
- ➔ Сонин сэтгүүлд өгүүлэл нийтлэх, нийтлэлийг цааш нь түгээх
- ➔ Интернетийн хуудас, хаягийг ашиглах



Аргачлал 6.1 Хэвлэлийн мэдээ бичих зөвлөмж

- ➔ Анхаарал татсан гарчгаар эхэлнэ. Богино өгүүлбэрүүдийг хэрэглэ.
- ➔ Эхний өгүүлбэр буюу догол мөрөндөө **ХЭН? ЮУГ? ХЭЗЭЭ? ХААНА? ХЭРХЭН** гэсэн 5 асуултан п хариулж бич.
- ➔ Гол мэдээллийг эхний догол мөрөнд оруулан танилцуулах бөгөөд дараагийн мөрүүдэд илүү дэлгэрэнгүй мэдээллийг оруулна. Догол мөрүүдийг мэдээллийн зэргээр нь дараалуулна.
- ➔ Ишлэлүүдийг үргэлж хүний нэртэй холбож өгнө.
- ➔ Зохистой газар нь тоо баримтыг хэрэглэнэ.
- ➔ Холбоо барих хүний овог нэр, холбоо барих хаягийг оруул.
- ➔ Ерөнхийдөө хэвлэлийн мэдээ нь нэг буюу хагас нүүрнээс ихгүй байдаг. Хэрэв та хоёр дахь нүүрийг ашиглавал эхний нүүрийн дор “үргэлжлэл бий” гэж бичихээ мартуузай.
- ➔ Бүрэн гүйцэд төгс болтол нь нягталж уншаарай.

6.2.1 Хэвлэлийн мэдээг хэрхэн бичих вэ?

Хэвлэлийн мэдээ нь тодорхой үйл явдал, амжилт бүтээлийн талаар бичгээр илэрхийлсэн баримт юм. Хэвлэлийн мэдээ ба тусгайлан бэлтгэсэн мэдэгдлүүд нь хэлэх гэж хүссэн зүйлээ өөрийнхөө үгээр илэрхийлэх боломжийг танд олгодог. Хэвлэл мэдээллийн хэрэгслийг урьж оролцуулах шаардлагатай томоохон арга хэмжээ, хэвлэлийн бага хурлын өмнө хэвлэлийн мэдээг бэлтгэх хэрэгтэй.

Хэвлэлийн мэдээг бэлтгэхдээ:

6.2.2 Хэвлэлийн бага хурлыг зохион байгуулах нь



Аргачлал 6.2 Хэвлэлийн бага хурлыг зохион байгуулах аргачлал:

- Үйл явдлын юу, хэн, хэзээ, хаана гэдгийг жагсаасан товч мэдээ бэлтгэж хэвлэл мэдээллийн бүх газар руу утасдуулах эсвэл электрон шуудан факсаар урилгаа хүргүүлнэ.
- Сэтгүүлчдэд тааламжтай газар, цагт хэвлэлийн бага хурлаа хийх хэрэгтэй.
- Үзүүлэн, сургалтын ном хэвлэл хэвлэлийн бага хурлын үеэр хүрэлцээтэй тараах
- Мөн дэвшүүлэн тавьсан асуудал болон байгууллагынхаа тухай мэдээллийг багтаасан хэвлэлийн багцыг тараана. Хэвлэлийн хуралд мэдээлэл хийсэн төлөөлөгч бүрийн бичсэн мэдэгдлийн хувийг сурвалжлагчид тараахаар бэлтгэнэ.
- Хуралд уригдсан хүмүүсийн нэрсийн жагсаалтыг гаргана.
- Хэвлэлийн бага хурал дээр үг хэлэх хүний тоог 2-3 хүнээр хязгаарлах ба тэдний нэг нь гол төлөөлөгч байна.
- Гол илтгэгчдийнхээ өмнө ширээн дээр зохих өндөрт сэтгүүлчдэд зориулсан микрофон байрлуулж телевизийн зураг авах өрөө бэлтгэсэн байх ёстой.
- Нээлтийн үг 2-3 минут, хамтарсан үг 10-15 минут байвал зохино.
- Асуулт хариултад хангалттай цаг гаргах хэрэгтэй.
- Бага хурлын дараа ганцаарчилсан ярилцлага өгөхөд бэлэн байх ёстой.
- Сэтгүүлч бүртэй багаас нэг хүн биечлэн ярилцаж илүү мэдээ, хэлхээ холбоо санал болгох нөхцөл бүрдүүлэхийг хичээгээрэй.
- Хэвлэлийн бага хурлын дараа хуралд ирээгүй хүмүүст хэвлэлийн багцаа илгээх хэрэгтэй.

6.2.3 Радио телевизийн нэвтрүүлэгт ярилцлага өгөх нь

Радио телевизийн нэвтрүүлэгт орж үндсэн мэдээллээ хүргэх хамгийн үр ашигтай арга замын нэг нь ярилцлага юм. Тухайн асуудлын талаар мэдлэгтэй хийгээд ойлгомжтой, тод ярьдаг хүнийг ярилцлага өгөхөөр сонгох хэрэгтэй.

Ярилцлага өгөхийг зөвшөөрөхийн өмнө:

- Хөтөлбөрийн зорилго юу болох, сонсогч хэн болох
- Тэдэнд ямар мэдээлэл байгаа, ямар учраас танаас ярилцлага авахыг хүсч байгаа, таны хэвлэлийн мэдээ, бусад холбогдох материал байгаа эсэх
- Танаас юу асууж болзошгүй, та хэр хугацаанд ярих
- Ярилцлага шууд уу эсвэл бичлэг үү?
- Ярилцлагыг хэн хөтлөх зэргийг мэдэж байх хэрэгтэй

Ярилцлага өгөхийн өмнө:

- Боломжтой бол та оролцох хөтөлбөрөө өмнө нь сонсох буюу үз, нэвтрүүлэг хөтлөгчийн хэв загвар, асуудаг асуулт зэргийг мэдэж авах хэрэгтэй. Хэрэв та тухайн хөтөлбөрийг сонсогч, үзэгчид ямар хүмүүс байгааг мэдэж байвал хариултаа тэдэнд тааруулж чадна.

- Сурвалжлагч, найруулагчтай ярьж нөлөөллийн ажлын талаар ямар мэдээлэл байгааг мэдэж авна. Тэдэнд та материалаа үзэхийг санал болгож болох юм. Ингэснээр ярилцлагад зориулж асуулт зохиоход нь туслах болно. Мөн түүнчлэн тэд ямар учраас ярилцлага авах гэж байгааг олж мэдэх хэрэгтэй
- Ярилцлагын өмнө сурвалжлагч, найруулагчтай ярилцахыг хичээгээрэй. Тэд яг ямар асуулт асуухаа бараг хэлэхгүй ч ямар чиглэлээр ярилцахыг танд лавтай хэлж чадна.
- Асуултыг сайн ойлгоогүй бол тодруулахаасаа бүү эмээгээрэй.
- Радио ярилцлага өгч байгаа бол тоо, баримт, чухал асуудлын жагсаалт, зэргийг бэлтгэн урьдаа тавих хэрэгтэй.
- Ярилцлагын явцад асуултад хянамгай, болгоомжтой хариулах гэж бодох хэрэггүй. Хэрэв шаардлагатай бол дахин давтаж хэлэх буюу тодруулж тайлбарла.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан тохиолдлуудаа бичиж, сонсох хэрэгтэй. Ингэвэл та дараагийн удаа ярилцлага өгөх арга чадвараа сайжруулж чадна.

6.2.4 Телевизээр илгээмжээ цацах

Сүүлийн үед Телевизээр шторк цацах аргыг өргөнөөр ашиглах болсон.

Давуу тал: нийгмийн төрөл бүрийн бүлэгт хүрч очих магадлалтай, голчлон үндэсний хэмжээний нөлөөллийн ажилд ашиглахад тохиромжтой,

Сул тал: үнэ өртөг ихтэй, орон нутгийн чанартай үйл ажиллагаанд тохиромжгүй, телевиз үзэх боломжгүй газарт ашиглах боломжгүй.

Энэ арга нь нилээн үнэ өртөг өндөртэй тул хэнд зориулж боловсруулж байна вэ гэдгээ дахин бодож үзэх ёстой.

Телевизийн шторк нь илгээмж боловсруулах зарчимтай адил гэдгийг анхаарна уу. Нэг минутын илгээмжийн загварыг ашиглан шторз боловсруулж болно.

6.2.5. Редакцид захидал бичих

Сонины редакцид бичсэн захидал нь хамгийн их уншигддаг булангийн тоонд багтдаг. Энэ нь өдөр бүр гардаг бөгөөд олон түмний санаа бодол, хэлэлцүүлэгт чиглэгдсэн байна. Олон нийт, сонгогчдын захидал сонин сэтгүүлд нийтлэгдэхэд бодлого боловсруулагчид, төрийн албаны хүмүүс байнга анзаарч байдаг. Редакцид бичих захидлыг ашиглан асуудлыг уншигчиддаа анхааруулах эсвэл өмнөх захидал, нийтлэл болон редакцийн мэдэгдэлд хариу өгч болно. Ерөнхийдөө, та орхигдсон чухал баримтад анхаарлаа хандуулж, гол санааг тайлбарлахад анхаарлаа хандуулж хэрэгтэй юм. Өөр захидал бичигч, сэтгүүлч эсвэл редакторын байр суурийг ч гэсэн дэмжиж сайшаах нь зохимжтой байдаг. Редакцид бичсэн захидал болон мэдээлэл нь урт байдаг ч танд хэлэхийг хүссэн зүйлээ бичих боломж олгодог. Сонинд саяхан нийтлэгдсэн өгүүлэл буюу тусгай өгүүлэлд хариу болгож эрхлэгчид хандсан захидал бичиж болно. Тухайн өгүүлэлтэй санал нийлж байгаа буюу санал нийлэхгүй байгаа зүйлээ бичиж өөрийн санал үндэслэлээ мэдээлэх хэрэгтэй. Хэрэв эрхлэгчид хандсан захидал сайн бичигдсэн ойлгомжтой товч байвал хэвлэгдэх магадлал өндөр байна. Тодорхой нэгэн өгүүлэлд хариулж байгаа тохиолдолд захидлаа хурдан илгээх хэрэгтэй. Захидалдаа өөрийн байгууллагын хаяг, нэр, албан тушаалаа заавал бичнэ. Өөр нэг арга бол сонины газрын сэтгүүлчийг өгүүлэл бичүүлэхээр ятгаж болох юм.

6.2.6 Өгүүлэл боловсруулах

Өгүүлэл нь тодорхой асуудлаар сонинд зориулж бичсэн зохиомж юм.

Санал бодлоо илэрхийлсэн тусгай өгүүллийг бичихдээ:

- Албан илтгэл шиг бус, харин ярьж байгаа юм шиг бичнэ.
- Хүмүүсийн анхаарлыг татахуйц хүчтэй баримт санаагаар эхэлнэ.
- Өөрийн үзэл бодлоо тайлбарлахын тулд зарим шог яриа оруулж болно.
- Тухайн үзэл бодолтой холбоотой бусад хүмүүсийн байр суурийг тайлбарлана. Мөн баримт, үндэслэл, статистик мэдээ оруулна.
- Зохиогчийн нэр дор байгууллага, албан тушаалаа бичнэ.

6.2.7. Тэргүүн өгүүллийг сэдвээр ярилцлага зохион байгуулах

Хэвлэл мэдээлэлд ямар нэг мэдээлэл хэвлүүлснээр л олон нийтэд нөлөөлж байна гэж үздэг нийтлэг дутагдал байдаг. Тэгвэл хэвлэл мэдээлэлд гарсан дорвитой өгүүлэл, мэдээллийг ашиглан орон нутагтаа хэлэлцүүлэг хийх замаар олон нийтэд болон бодлого боловсруулагчдад нөлөөлж бас болно.

Тэргүүн нүүрний өгүүлэл нь редакцийн бодлого байдаг учраас сэтгүүлчид өөрсдөө үндэсний хэмжээнд судалж байж бичдэг. Иймээс таны нөлөөлөхийг зорьж буй сэдвээр нийтлэгдсэн тэргүүн өгүүллийг олон нийтэд түгээх үйл ажиллагааг зохион байгуулж болно.

Өгүүллийн сэдвийг орон нутагтаа хэлэлцүүлэх замаар олон нийтийн анхаарлыг тухайн асуудал руу татах, ойлголт мэдлэгийг нь нэмэгдүүлэх үйл ажиллагааг явуулж болно.

6.3 Хэвлэл мэдээллийн хэрэгслийг сонгох нь

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэдэг нь суваг хэрэгсэл ба сонирхогч талын аль аль нь мөн билээ. Тэд таны мэдээллийг түгээх боловч, эхний ээлжинд таны илгээмжийг хүлээн авах ёстой гол сонирхогч тал мөн. Юуны өмнө өөрийн сонирхогч талуудаа болон тэдэнд юу нөлөөлдгийг ойлгох нь маш чухал. Эхний ээлжинд хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүтэц, зохион байгуулалт, шинж чанарыг нь үнэлэх хэрэгтэй болно. Ийм мэдээлэл таныг хамгийн ашигтай мэдээллийн байгууллага ба сэтгүүлчдэд анхаарал хандуулах боломжтой болгох ба тэдний анхаарлыг татахын тулд асуудлыг хэрхэн дэлгэж тавихаа тодорхойлоход тус болно. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаар үндсэн мэдээллийг цуглуулж үнэлгээгээ эхэлнэ. Хэрэв хэрэгцээтэй бол мэдээллийн байгууллага руу шууд утасдаж хариулт авах нь зүйтэй.

- Таны гол сонирхогч талуудад хүрэх анхдагч мэдээлэл болон нөлөөллийн эх үүсвэр юу болох вэ? Тодорхой хэвлэл мэдээллийн байгууллагуудын тухайлбал, орон нутаг, үндэсний болон олон улсын сонин, сэтгүүл, радио, телевизийн мэдээ ба хөтөлбөрийн жагсаалтыг гарга.
- Мэдээллийн байгууллага тус бүрийн бүтэц зохион байгуулалт ямар байна вэ? Таны сонгосон асуудлыг олон нийтэд түгээх алба болон тусгай сэтгүүлчид байдаг уу?
- Мэдээллийн байгууллага тус бүрийн хувьд мэдээллийг түгээх сонголтын ямар хэлбэрүүд байна вэ? Нийтлэл, булан, улс төрийн шог, хөрөг, редакцид бичсэн захидлууд, радиогийн ярилцлага гэх мэт ямар хэлбэрээр түгээж болох вэ?
- Сонголт бүрт ямар нэг цагийн хязгаарлалт бий юу? Бэлдэхэд ямар хугацаа шаардлагатай вэ?

Дараа нь хэвлэл мэдээллийн байгууллагын нэвтрүүлэг, нийтлэл болон бусад бүтээлүүдийг сарын турш ажигла. Ажиглалтын үед дараах зүйлсийн талаар эргэцүүлж үзээрэй. Үүнд:

- Таны асуудлыг хэрхэн олон нийтэд хүргэх, ямар мэдээллийг багтаах, хэний дуу хоолойг оруулах зэргийг шийддэг хүн нь хэн бэ? Мэдээллийн хэрэгслээр таны хөндсөн асуудал эсвэл түүнтэй холбогдолтой асуудлыг тогтмол нэвтрүүлж байна уу? Сэтгүүлч, редактор, найруулагч болон бусад хүмүүсийн нэрийг аль болох тодорхой гарга.
- Таны асуудлыг хэр олон удаа нэвтрүүлж, хэвлэж байна вэ? Ямар хэлбэрийг хамгийн ихээр ашиглаж байна вэ? Асуудлыг хэрхэн дүрсэлж байна вэ? Асуудлыг шийдэх хариуцлага бүхий хүн нь хэн байна вэ? Асуудлыг шийдвэрлэх бусад хувилбарын талаар ярилцаж байна уу?
- Нийтлэлд ямар хүмүүсийн бүтээл, үг хэллэгээс иш татаж байна вэ? “Редакцид бичсэн захидал”-д ямар төрлийн хүмүүс хандаж байна вэ? Шийдвэр гаргагчид уу? Мэргэжилтнүүд үү? ТББ-ын төлөөлөгчид үү? Асуудалд нөлөөлж буй хүн ам, бүлгийн төлөөлөгчид үү? Бусад хүмүүс үү?

Эдгээр асуултад хариулт авснаар ямар мэдээллийн байгууллагууд таны хөндсөн асуудал болон мэдээллийг өөрчилж замхруулалгүйгээр түгээж байгаа болон түгээх магадлалтайг тодорхойлно.

Нөлөөллийн үйл ажиллагаанд хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглахад юу анхаарах вэ?

- Шийдвэр гаргагчдад хамгийн ойр, тэдний уншдаг, үздэг, хэвлэл хөтөлбөрийг сонгохыг хичээ.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглахдаа шийдвэр гаргагчдын онцлогийг харгалзах ба хүрэх зорилт юу болохыг тодорхойлох хэрэгтэй.
- Чухал үйл явдал, тухайлбал удахгүй болох сонгууль, хуулийн санал хураалтыг ашиглах шаардлагатай. Олон улсын томоохон үйл явдлыг бүү март.
- Хамгийн сүүлчийн мэдээ, мэдээллийг сонго.

6.4 Хэвлэл мэдээллийнхэнтэй хамтран ажиллах

Хэвлэл мэдээллийн анхааралд байхыг хүсвэл тэдний төлөөлөгчтэй харилцаа холбоо тогтоох нь маш чухал юм.

Холбоо харилцааг хөгжүүлэхдээ :

- ➔ Танай асуудлыг сурвалжилдаг сурвалжлагчийг ажиглаж тэдний нэр, байгууллага, холбоо барих хаягийг тэмдэглэж авна.
- ➔ Хэрэв боломжтой бол орон нутгийн болон олон улсын хэмжээний хэвлэл мэдээллийн газрын жагсаалтыг гаргана. Мэдээллээ радио, сонин, сэтгүүл, интернетийн хаяг гэх мэтээр төрөлжүүлэн зохион байгуулна.
- ➔ Энэ бүх мэдээллийг холбоо барих хүний нэр, утасны дугаарын хамт мэдээллийн санд оруулна. Мэдээллээ тогтмол шинэчилнэ. Үүнийг хийх нэг арга нь тэдэнд ил захидал, хэвлэлийн мэдээний хамт илгээж уг материалыг үргэлжлүүлэн хүлээн авах хүсэлтэй эсэхийг асууна.
- ➔ Бага хурал, тусгай үйл явдалд танилцаж холбоо барих хүмүүсээ урьж уулзаж байх хэрэгтэй.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй ажиллахад нийтлэг тохиолддог саад бэрхшээлүүд ба түүнийг даван туулах аргууд

Саад бэрхшээлүүд	Даван туулах аргууд
Бусад мэдээллийн сувгуудтай харьцуулахад хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр цацагдаж буй мэдээллийг нөлөөлөгч хянах боломж багатай байдаг.	Нөлөөлөгч өөрийн хэвлэл мэдээллийг хэрэгсэлд өгсөн мэдээллээ тухайн хэвлэл мэдээллийн хэрэгсэл цацаж байна уу үгүй юу гэдгийг хянаж байх ёстой.
Хэвлэл мэдээлэл нь өөрийн орлогоор санхүүжигдэж үйл ажиллагаа явуулдаг бизнесийн салбар юм. Иймээс илүү их борлогдох магадлалтай эсрэг тэсрэг байр суурь, зөрчилдөөн, бодит түүхийг харуулсан “үнэтэй” мэдээллийг илүүд үздэг.	Нийгмийн шударга ёсны төлөө нөлөөллийн асуудлууд нь нарийн төвөгтэй, удаан хугацааны туршид яригдсаар ирсэн асуудал байдаг. Иймээс нөлөөлөгчид нь өөрсдийн мэдээг сонирхол татсан шинэ мэдээ болгох арга замыг хайх ёстой.
Мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй асуудлууд нь тодорхой сэдэвт бус салангид үйл явдалд чиглэгдсэн байдаг байна. Өөрөөр хэлбэл ихэнхи мэдээ асуудлын үндсэн шалтгаан ба зохион байгуулалтын тодорхой шийдэл, хэрэгцээ шаардлагад хандахаас илүү хувь хүний хариуцлагад илүү анхаарал хандуулсан байдаг байна.	
Сэтгүүлчид мэддэг зүйлсийнхээ талаар ихэвчлэн бичдэг. Нөлөөлөгчид үүнийг мэддэг хэдий ч мэдээллийн хэрэгслийн залуучид болох сэтгүүлч, редактор, найруулагч зэргийн хүмүүстэй харилцаагаа өргөжүүлж, тэднийг сургаж боловсруулахад цаг гаргадаггүй.	•Хэвлэл мэдээллийн хэрэгслийн сэтгүүлч болон, редактор, найруулагч зэрэг хүмүүстэй харилцах харилцаагаа өргөжүүлэх хэрэгтэй. Тэднийг мэдээллээр ханга
Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь нарийн зааж тогтоосон цаг хугацаанд захирагдан үйл ажиллагаагаа явуулдаг нь нөлөөллийн багуудад тэр бүр тохирдоггүй.	•Цаг хугацааг зөв сонго. Сэтгүүлчийн цагийг хүндэл.

6.4.1 Шинэлэг, сонирхол мэдээг бий болгох нь

Хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан нөлөөлөл хийхэд нөлөөлөгчдийн хувьд өөрийн үнэт зүйлс ба илгээмжийн гол санаагаа хадгалан асуудлыг шинэлэг сонирхол татах хэлбэрээр дэлгэн үзүүлэх нь чухал юм. Иймд тухайн асуудлыг хэрхэн сонирхол татсан хэлбэрт оруулж болох талаар сайтар эргэцүүлэн бодож ажиллах хэрэгтэй.

Шинэлэг, сонирхол татах мэдээллийн түгээмэл хэлбэрээс дурдвал:

- Зөрчилдөөн ба маргаан
- Шударга бус байдал, тэгш бус байдал, хууран мэхлэлт
- Өргөн олны сонирхол эсвэл олон хүмүүст утга учиртай мэт санагдаж буй зүйл
- Тайлагдашгүй ер бусын зүйлс, оньсого
- Зарим нэг зүйлийн талаар дахин бодоход хүргэсэн маргаантай сэдэв
- Үндэсний хэмжээний үйл явдал орон нутагт нөлөөлсөн байдал
- Томоохон асуудал болгон тавьж буй хувийн түүх, үйл явдал нь сонирхогч талуудад харуусах сэтгэгдэл төрүүлж байгаа үйл явдал
- Тухайн асуудал нь илтгэгч болон мэдээллийг түгээж буй хүмүүс болон байгууллагад хэрхэн нөлөөлж байгаа.
- Нэрд гарсан хүмүүс тухайн асуудалтай ямар байдлаар хамаатай байж болох
- Ямар нэгэн зүйл анх удаа, хамгийн их эсвэл том хэмжээнд тохиолдож байгаа
- Хөгжил дэвшлийг хэмжиж болохуйц тэмдэглэлт үйл явдал, ойн арга хэмжээ
- Бодит байдлыг тод томруун харуулах зураг ба үзүүлэн таниулах материал зэрэг нь шинэлэг сонирхол татах материалын эх сурвалж болно.

Нөлөөллийн ажлын туршлагаас харахад асуудлаа шинэлэг сонирхолтой хэлбэрт оруулахад багаараа ажиллах нь их тустай, үр дүнтэй байдаг. Нэгэнт боломжтой бүх хувилбарын талаар жагсаалтаа боловсруулсан бол та бүхэн боломж бүрийн талаар дүн шинжилгээ хийн хэлэлцээд, улмаар хамгийн сайн тохирохыг нь олж тогтоо. Өөрөөр хэлбэл мэдээлэл маань шинэ соргог, мөн таны гол санаа ба баримталж буй үнэт зүйлстэй тохирч буй эсэхийг магадлан нягтална гэсэн үг. Өөр нэг ач холбогдолтой дасгал бол хэвлэл мэдээллийн хэрэгслээ ажиглах явдал юм. Таны хувьд аль үйл явдал, асуудлыг сайн гаргаж таниулж буйг тэмдэглэж ав. Дараа нь тухайн үйл явдлыг юу шинэ соргог, сонирхолтой болгож буйг өөрөөсөө асуугаарай.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж нөлөөлөл хийхэд гол мэдээллээ хамгаалах нь нөлөөлөгчдийн анхаарах ёстой асуудлын нэг юм. Иймд хэвлэлийн төлөөлөгчид, сэтгүүлчид, сурвалжлагчидтай тогтоосон харилцаа таны мэдээ болон асуудлыг тэдэнд ойлгуулах, улмаар олон нийтэд хүргэхэд асар их ач холбогдолтой.

6.4.2 Сэтгүүлчидтэй хэрхэн хамтран ажиллах вэ?

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй тогтоосон харилцааны чухал хэсэг нь сэтгүүлчидтэй ажиллах явдал юм. Хэрэв ямар хүмүүс мэдээг боловсруулах ба түгээх сонголтыг хянаж байдгийг мэдсэн бол түүнтэй харилцаа тогтоох, сургах болон мэдээллээр хангахад анхаарлаа хандуулах хэрэгтэй.

Сэтгүүлчидтэй ажиллахад дараах хэдэн зөвлөмжийг дурдъя. Үүнд:

Сэтгүүлчдийг хэрэгтэй мэдээллээр нь хангаж өгөх. Сэтгүүлч нөхцөл байдлыг мэдэж буй эсэхийг лавлаж нягтлахын оронд нөхцөл байдалд холбогдох мэдээллээр хангаж өгөх нь зохистой байдаг. Мэдээллийг биечлэн, утсаар эсвэл хэвлэлээр дамжуулж өгч болно. Чухал хэрэгтэй мэдээлэл нь дараах шинжийг агуулсан байхыг шаардана.

- Сайн судлагдсан, бодит байдалд нийцсэн товч, мэдээлэл байх бөгөөд хэрэв боломжтой бол жишээ татна.
- Асуудлын цаад эх сурвалжийг дурдсан байна.
- Тухайн асуудлын талаар танай багийн баримталж буй байр суурь, ялангуяа тодорхой, практик шийдлийг тусгасан байна.
- Эсрэг мэтгэлцээнд өгөх хариултыг агуулна.

Хэрэв та аль нэг асуултад хариулж мэдэхгүй байвал түүнийгээ сэтгүүлчидтэй ярилц. Боломжтой бол сэтгүүлчээс өөр эх сурвалжийн талаар болон бусад мэдээллийг хэрхэн олох талаар санал асууна. Үүнд:

- Илтгэх ба мэдээлэл хүргэх хүнийг тодруулах нь чухал. Энэ хүн нь тухайн асуудалтай холбоотой, асуудлыг сайн мэддэг бүлгийн төлөөлөгч, нэр хүндтэй удирдагч болон мэргэжилтэн хүн байна. Хэрэв шаардлагатай бол ярих хүндээ асуудлын талаар бэлтгэхэд нь тусалж, сэтгүүлчидтэй чөлөөтэй ярилцах бололцоо олгоно.
- Сэтгүүлчийн тогтоосон цагт ажиллан түүний хуваарийг хүндэтгэх хэрэгтэй. Асуултанд хариулахын тулд бэлтгэлтэй бай. Хэрэв илүү мэдээлэл санал байгаа бол хэзээ хэрэгцээтэйг нь асуугаарай. Хэрэв сэтгүүлчийн асуултад шууд хариулж чадахгүй эсвэл өөрийн багийнхантай эхлээд зөвлөлдөх хэрэгтэй бол буцаж тэдэнтэй холбоо барьж болох эсэхийг лавлаарай.
- Сэтгүүлчдийн асуудалд бодит өнгөөр хандах болон асуудлыг бүх талаас нь дэлгэн үзүүлэх шаардлагыг хүндэтгэн үзэх хэрэгтэй. Зөвхөн танай байгууллагын байр суурьт анхаарлаа хандуулна хэмээн хүлээх хэрэггүй.
- Хэрэв танай баг урьд нь сэтгүүлчидтэй ямар нэг харилцаа холбоо байхгүй байсан бол өөрсдийгөө танилцуулах цаг гарга. Сэтгүүлчийг дараах мэдээллээр хангах хэрэгтэй. Үүнд:

- Танай багийн тухай, та бүхэн хэнийг төлөөлж байгаа, та бүхнийг хэн дэмжиж байгаа болон ямар ажил хийдэг талаар товч дурдах
- Асуудлын талаар таны баримталж буй байр суурь.
- Дээрх мэдээлэл нь тухайн асуудал тэдний сонирхлыг татах суурь болно. Мөн ирээдүйд та тэдний хувьд мэдээллийн эх сурвалж нь болоход тустай юм.

6.4.3 Өөрийн хүчин чармайлтаа үнэлж цэгнэх нь

Мэдээллийг түгээж буй аль хэлбэрийг сонгосноос үл хамааран, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хэрхэн хамтран ажиллаж байгаагаа үнэлэх хэрэгтэй. Өөрийн үнэлгээ хийхэд дараах асуулт тус болно. Үүнд:

- ➔ Таны мэдээлэл мэдээний буланд гарсан уу?
- ➔ Таны мэдээлэл ойлгомжгүй байсан уу эсвэл буруу ташаа, утга санаа алдагдсан байсан уу?
- ➔ Энэ нь хэрэгтэй ажил болж чадсан уу? Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй ажиллахад шаардагдах байгууллагын хөрөнгө бололцооны талаар эргэн нэг бодоорой
- ➔ Дараа дахин хэвлэл мэдээллийнхэнтэй ажиллавал юуг өөрөөр хийх вэ?

Таны хариултуудаас хэвлэл мэдээллийн байгууллагатай энэ хэлбэрээр ажиллах уу, эсвэл өөр байгууллагатай, өөр хэлбэрээр ажиллах уу гэдэг нь тодорхой болно. Мөн сэтгүүлчид болон бусад бололцоотой хэвлэл мэдээллийнхэнтэй илүү сайн харьцаа тогтоох хэрэгцээтэй эсэхээ мэдэж авна.

Шигтгээ

Улаанбаатар хотын эмэгтэйчүүдийн зөвлөл Налайхын нүүрсний уурхайд хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд ба эрсдэлтэй хүүхдүүдэд суралцах боломж олгох тэднийг нөхөн сэргээх нь төслийг хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд уулзалт зохион байгуулах, телевизийн нэвтрүүлэг бэлтгэж цацах, түүнчлэн өдөр дутмын сонингуудаар сурталчилгааны материал хэвлүүлэх зэрэг олон нийтийн анхаарлыг хүүхдийн хөдөлмөрийн асуудалд хандуулах төрөл бүрийн үйл ажиллагааг зохион байгуулах замаар хүүхдийн хөдөлмөрийн сөрөг үр дагаврын талаарх ойлголтыг дээшлүүлсэн.

Эх үүсвэр: АЙПЕК "Сайн туршлага ба сургамж" номноос 2006

VII БҮЛЭГ

НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ

БҮЛГИЙН ТОВЧ АГУУЛГА:

7.1 Хүүхдийн оролцоо гэж юу вэ?

7.2 Нөлөөллийн үйл ажиллагаан дахь хүүхдийн оролцоо

7.1 Хүүхдийн оролцоо гэж юуг хэлэх вэ?

Оролцоо нь аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн үзэл бодол, хүчин чармайлтыг авч үзэхийг эрхэмлэнэ гэсэн үг. Оролцоо нь хүүхдүүд аливаа зүйлийг ойлгох, шийдвэр гаргах, эдгээрийн үндсэн дээр юм хийх чадвартай юм гэдгийг хүлээн зөвшөөрөх явдалд үндэслэдэг.

Хүүхдийн оролцоог хангахын тулд дараах хоёр суурь зарчим хэрэгжих ёстой байдаг. Үүнд:

- ➔ Нэгдүгээрт, хүүхдүүдийн амьдралд нөлөөтэй шийдвэр гаргахад өөрсдөө нөлөөлж, оролцох боломжоор хангагдах ёстой.
- ➔ Хоёрдугаарт, хүүхдүүд мэдээллээр хангагдах ёстой. Энэ нь тэднийг санал бодлоо үнэн зөв гаргах үндэслэл болж өгнө.

Үүний зэрэгцээ, хүүхдүүд томчуудтай хамт оролцох үйл явц нь дараах шинж чанартай байна. Үүнд:

- ➔ Сайн дурын байх: Оролцох эрх нь оролцохгүй байхаар шийдвэрлэх эрхийг өөртөө агуулна.
- ➔ Мэдээллээр хангагдсан байх: Хүүхдүүд оролцох эсэх талаар санал хэлэхээсээ өмнө оролцох гэж буй үйл ажиллагааны үндэслэл, зорилго, эрсдэл, үр дүнг сайтар ойлгож мэдсэн байх ёстой.
- ➔ Утга учиртай байх: Оролцоо нь тодорхой зорилготой, хүүхдүүдийн зорилго, хүслийг хангах боломжтой байх учиртай.
- ➔ Хүүхдийн ашиг сонирхлыг татаж чадсан байх: Хүүхдүүд үйл ажиллагаанд оролцсоноор гарах ач тус нь гарч болох эрсдэлээс давуу байх ёстой.

Эдгээр үндсэн асуудлаас гадна оролцоо хэрэгжиж буй орчин, үйл ажиллагааны мөн чанар, оролцож буй хүмүүсээс (хүүхэд, томчууд) хүүхдийн оролцооны төрөл хэлбэр мөн хамаардаг.

Хүүхдийн оролцоо яагаад чухал вэ?

Оролцоо нь хүүхдүүдийг чадваржуулна.

Хүүхдүүд үйл ажиллагаанд оролцож үзсэнийхээ үр дүнд өөртөө илүү итгэлтэй болж, цаашдаа ч аливаа үйл ажиллагаанд оролцох дур сонирхолтой болдог. Оролцоо нь хүүхэд аливаа хүчирхийлэл, дарангуйллыг эсэргүүцэх болон өөртөө итгэлтэй болоход сайнаар нөлөөлнө.

Хүүхдүүд бол ирээдүйн том хүмүүс

Оролцоо нь хүүхдүүдийг өөрсдийн шийдвэр, зан үйлийн хариуцлагаа урьдаас ухамсарлаж өөрсдөдөө төдийгүй бусад хүмүүс, нийгэмд тустайгаар хэрэгжүүлэхэд сургаж бэлтгэдэг юм.

Оролцоо бол хүүхдүүдийг хамтын ажиллагаанд суралцах үндэс болдог.

Асуудал шийдвэрлэх, өөрсдийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн төлөө үйл явц дунд оролцогч хүүхдүүд нь өөрсдийн давуу болон сул талаа танин мэдэж, бусдын дэмжлэгийг хэрхэн, хэзээ хүсч, хэнд хандах хэрэгтэй талаар мэдэж авдаг байна.

Хүүхдийн хөдөлмөрийг устгах үйл ажиллагаанд хүүхдийн оролцоог хангах нь

Хүүхдийн оролцоо нь ялангуяа хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үйл ажиллагаанд онцгой чухал юм. Учир нь:

- ➔ Хөдөлмөр эрхэлдэг хүүхэд нь нийгэмд хамгийн бага эрх мэдэлтэй хүмүүсийн бүлэгт хамаарагдаж байдаг. Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн эрх мэдэл дорой байгаа нь зөвхөн тэдний ажил хийдэгтэй холбоотой төдийгүй тэдний гэр бүл, харьяалагддаг олон нийт нь эрх мэдэл, шийдвэр гаргах үйл явцаас хол тусгаарлагдмал байдаг оршино.
- ➔ Тэд нийгмийн хамгаалал, нийгмийн суурь үйлчилгээний талаар мэдлэг ойлголтгүй тул эдгээрээс хүртэх боломжоор хязгаарлагдмал байдаг. Хүүхдүүд өөрсдийн эрхийн талаар мэдлэг мэдээлэл авч, санаа бодлоо илэрхийлэх боломжоор хангагдсанаар тэдэнд өөрийгөө хамгаалах мэдрэмж бий болж, эрх нь зөрчигдсөн тохиолдлыг таних, энэ талаар илүү анхаарах болон чадварждаг байна. Энэ бүхний үр дүнд хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд нэгдэн нийлж томчуудын болон нийт хүүхдүүдийн дэмжлэгийг авч өөрсдийн эрхээ хамгаалж, өөртөө итгэлтэй болж өсч хөгжих боломжтой болно.

Хүүхдийн оролцоог хангахад тулгарах бэрхшээлтэй асуудлууд

Хүүхдийн оролцоог хангах явдал нь амар хялбар явц бус бөгөөд их тэвчээр, уян хатан байдал, бүтээлч санаачилгатай байхыг төдийгүй гэр бүл, олон нийт, шийдвэр гаргагчдын дэмжлэг, түншлэлийг бий болгох байнгын шаргуу үйл ажиллагааг шаардаж байдаг. Үүнд:

- ➔ Боловсрол, чадварын түвшин доогуур байх

Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд болон тэдний гэр бүлийн олонхи нь албан ёсны боловсрол эзэмшээгүй эсвэл бага боловсролтой байдаг.

- ➔ Нийгмийн дэмжлэг хангалтгүй байх

Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд нь шилжилт хөдөлгөөн, хүн худалдаалах үйл явцад өртсөнөөс болоод гэр орноосоо холдож хөндийрсөн байх нь элбэг байдаг.

- ➔ Цаг хугацаа, боломж хязгаарлагдмал байх

Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүд урт хугацаагаар ажилладгаас гадна гэрийн ажил хийхийн зэрэгцээ суралцдаг болохоор янз бүрийн үйл ажиллагаанд оролцох чөлөөт цаг, хүч, боломж бага байдаг.

- ➔ Хүүхдийн хөдөлмөр нь эмзэг нарийн асуудал мөн.

Хүүхдийн хөдөлмөрийн зарим тэвчишгүй хэлбэрүүд нь биеэ үнэлэх зэрэг хууль бус үйл ажиллагаанд хамрагдах бөгөөд эдгээрийг ёс суртахуунгүй, жигшүүртэй, ичмээр гэж олон хүмүүс үздэг. Эдгээр асуудлаар болон ийм хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиллагааг томчууд, түүний дотор ажил олгогчид болон олон нийтийн гишүүд, эрх баригчид төдийлөн дуртай байдаггүй юм.

- ➔ Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдтэй холбоо тогтооход бэрхшээлтэй байдаг.

Цаг хугацаа болон асуудлын эмзэг байдалтай холбоотой гарч ирэх өөр нэгэн асуудал бол тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдтэй холбоо тогтооход хэцүү байдаг явдал юм.

➔ Нийгэм сэтгэл зүйн үр нөлөө

Тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэх нь хүүхдэд сэтгэл зүйн, сэтгэл санааны хувьд муу уршиг, хор нөлөө ихтэй байна.

Хүүхдийн оролцоог хангахад баримтлах ёс зүйн үндсэн зарчмууд

Харилцан хүндлэл

Хүүхдийн оролцоо нь харилцан хүндлэл бүхий уур амьсгалд явагдах ёстой. Хүүхдүүд өөрсдийнх нь хувь нэмрийг үнэлж байгааг, нас, хөгжлийн бэрхшээлтэй байдал, хүйс, гарал үүсэл, ядуу гэж ялгаварлалгүй сонсож байна гэдгийг мэдэж байх ёстой.

Мэдээлэл авах эрх, боломжоор хангагдах

Хүүхдүүд бодитой, бүрэн дүүрэн мэдээлэлгүйгээр үйл ажиллагааг төлөвлөж, үр дүнтэй шийдвэр гаргаж чадахгүй билээ. Бичмэл эх сурвалж, дуу болон дүрс бичлэг, зурагт үзүүлэн, хүүхдийн хурал цуглаанд илтгэл тавих зэрэг хүүхдэд мэдээлэл өгөх боломжит арга замууд байдаг. Мэдээлэл олох чадварыг хөгжүүлэх нь дүн шинжилгээ хийх, янз бүрийн эх сурвалжаас авсан мэдээллийн чанарыг үнэлэх чадвар эзэмшүүлэхтэй нягт холбоотой.

Мэдээллийн үндсэн дээр зөвшөөрөл авах асуудал

Хүүхдийн оролцоо сайн дурын үндсэн дээр явагдана гэдэг нь оролцоонд тулгуурласан аливаа үйл ажиллагааг эхлэхийн өмнө мэдээлэл өгч, зөвшөөрөл авсан байх ёстой гэсэн үг.

Нууцыг хадгалах асуудал

Мэдээллийн нууцыг хадгалах эрх нь бүх хүүхдэд олгогдох ёстой бөгөөд уг эрхийг томчууд болон бусад хүүхдүүд ч дагаж мөрдөх ёстой. Ялангуяа хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн хувьд нууцыг хадгална гэдэг нь хамгийн чухал асуудал болдог. Яагаад гэвэл, тэдний үйл ажиллагаанд оролцох чадвар, нэр төр, аюулгүй байдал нь нууцыг хадгалахаас шууд хамаарч байж болох юм.

Хүүхдийг хамгаалах асуудал

Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд их эмзэг байдаг тул үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэхдээ энэ талаар нэн тэргүүнд анхаарах хэрэгтэй байдаг. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь эмчлэх үйл ажиллагаанаас илүү учраас хүүхдүүдэд тусалж чадах цагдаа, төрийн бус байгууллага, орон нутгийн засаг захиргаа, хуульчидтай холбоо тогтоож ажиллах нь ухаалаг алхам болно.

Оролцох тэгш эрхээр хангах нь

“Хүүхдүүд болон түүний эцэг эх буюу хууль ёсны асран хамгаалагч яс үндэс, арьсны өнгө, нас, хүйс, хэл яриа, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарал үүсэл, эд хөрөнгийн байдал, эрүүл мэнд болон бусад байдлаас үл шалтгаалан” (ХЭК-ийн 2-р зүйл) бүх хүн тэгш эрхтэй.

7.2 Нөлөөллийн үйл ажиллагаан дахь хүүхдийн оролцоо

Нөлөөллийн үйл ажиллагаанд хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийг оролцуулснаар хүүхдийн эрхийг хамгаалах болон хүүхдийн хөдөлмөрийн талаар олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх ажил илүү үр дүнтэй болдог. Учир нь хүүхдүүд энэ үйл ажиллагаанд оролцож байгаагаараа хүүхдүүдийг олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцах чадавхитай гэдгийг олон нийт ойлгож авахад тус дөхөм үзүүлдэг юм.

Өмнө нь хөдөлмөр эрхэлж байсан хүүхдүүд орон нутгийн бодит байдалд нийцсэн, тэдний амьдралд ойр дөт нөлөөллийн үйл ажиллагаа ба илгээмжийг боловсруулж чадна.

Илгээмжийг янз бүрийн сонсогчдод тохирсон өөр өөр арга замаар хүргэх ёстой. Тухайлбал сонин хэвлэл, радио, телевиз гэх мэт зэрэг мэдээллийн сувгуудаас тухайн зорилтот бүлгийн хамгийн их итгэдэг, унших дуртай хэлбэрийг нь сонгон ашиглах хэрэгтэй. Олон нийтийн дунд жүжигчилсэн тоглолт хийх болон бусад урлагийн тоглолтыг ашиглах нь олон нийтэд хүрч чадах үнэмшилтэй хэрэгсэл байж болох юм.

Хүүхдүүдийн зохион байгуулсан орон нутгийн компани ажил

2002 оны 4-р сард Камбожийн Такео дүүрэгт 50 гаруй хүүхэд хамтран өөрсдийн амьдарч буй дүүрэгт гарч буй хүүхэд худалдаалах гэмт хэргийн эсрэг олон нийтийн анхны компани ажлыг зохион байгуулсан юм. Хүүхдүүд айлуудаар явж өөрсдийн компани ажлын зорилгыг тайлбарлан, өөрсдийн зохион явуулж буй хагас өдрийн боловсрол, мэдээллийн арга хэмжээнд хүмүүсийг оролцохыг урьсан байна. Үүний үр дүнд энэхүү хагас өдрийн арга хэмжээнд 4000 гаруй хүмүүс оролцсон бөгөөд орон нутгийн засаг захиргааны зүгээс хүн худалдаалах асуудал байгааг хүлээн зөвшөөрч, хүн худалдаалагчдаас орон нутгийн хүүхдүүдийг хамгаалах, түүнд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажилд анхаарч ажиллахаа илэрхийлэхэд хүрчээ.

Эх сурвалж: Азийн хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд байгууллага. “Ази дахь хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг шийдвэрлэхэд хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн оролцоог дэмжих нь. ТББ-ын хамтын ажиллагаа ба иргэдийн хөдөлгөөн: CWA 2002 тайлан”.

Жүжигчилсэн тоглолт

Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд жүжигчилсэн болон бусад хэлбэрийн тоглолтууд үр дүнтэй байдаг. Жүжигчилсэн тоглолт нь үзэгчдийн анхаарлыг татан, сэтгэлийг нь хөдөлгөхийн хамт хүүхдүүдэд өөрсдийн авьяас чадвараа харуулах боломжийг олгодог. Ардын уламжлалт урлагийн сэдэвтэй жүжигчилсэн тоглолт, бүжиг, хүүхэлдэйн жүжиг зэрэг нь үзэгчдийн сэтгэлд илүүтэй хүрэхээс гадна орчин үеийн техник технологи тэр бүр шаарддаггүйгээс ямар ч нөхцөлд үнэ өртөг багатайгаар зохион байгуулж болдог.

Үзүүлэн таниулах аргууд

Уран зураг, гар зураг болон бусад үзүүлэн таниулах материал ашиглах аргууд нь оролцооны үйл явцын судалгаа, төлөвлөлт, нөлөөллийн болон ойлголт, мэдлэг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд өргөн хэрэглэгддэг.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд сонин, сэтгүүл, радио, телевиз багтдаг. Радио нь аливаа үйл явдлын тухай мэдээллийг алслагдсан бүс нутгийн болон хотын захын хүн ам, бүлгүүдэд хүргэх чадвартай хамгийн түгээмэл мэдээллийн эх сурвалж болдог. Хүүхдүүд нэвтрүүлэгч, сурвалжлагч, тайлбарлагч, танилцуулга хийх зэрэг үүргийг сайн гүйцэтгэж чаддаг байна

Индонезийн хүүхдүүдийн радио санаачилга

Бантар Гебанг-ийн Хүүхдийн Олон Нийтийн Радио нь “Homeless World Foundation” ТББ-ын хүүхдүүдийн санаачилгаар бий болсон юм. Бантар Гебанг-д байдаг Индонезийн томоохон хогийн цэгүүдийн нэгэнд байгуулагдсан тус радио станцийг хог ухаж амьдардаг хүүхдүүд нийгмийн ажилтан ба мэргэжлийн радио нэвтрүүлэгчийн тусламжтайгаар ажиллуулдаг байна. Амьдралын боломж муутай хүүхдүүдийг хөгжөөж, улмаар боловсруулж хөгжүүлэхэд тус радио голлон анхаардаг. Хог түүж амьдардаг хүүхдүүдийг татан оролцуулснаар тэд хүнтэй харилцах харилцааны ур чадварт суралцаж, илүү нээлттэй, чөлөөтэй болж, улмаар өөртөө итгэх итгэл нь нэмэгдэх зэргээр үр дүнгээ үзүүлэхэд тус дэм болох үүднээс энэхүү радио санаачилга ажилладаг байна.

Эх сурвалж: “АБАХ .Хамтран ажиллахад суралцахуй” номноос. УБ 2007.

Сонин ба “ханын сонин”

Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд төрийн ба ТББ-уудаас эрхлэн гаргадаг сонин сэтгүүл ба бусад төрлийн хэвлэмэл материалуудаар дамжуулан хүүхдүүд тодорхой хэмжээгээр хувь нэмрээ оруулж чадна.

Гудамжинд амьдардаг, хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн зарим байгууллагууд нэг нүүр бүхий “ханын сонин” гаргаж түүнийгээ бусад хүүхэд болон насанд хүрэгчдэд зориулан хананд нааж, номын сан, их сургууль, коллеж, ТББ-уудаар тараадаг. Ханын сонин нь хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн асуудал, хүний эрх ба бусад үйл явдлын талаар мэдээ, мэдээлэл өгч, хүүхдийн үзэл бодлыг түгээн дэлгэрүүлэхэд үр дүнтэй хэрэгсэл болдог.

Интернет

Интернетэд холбогдох нь хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд, тэдний гэр бүл, олон нийтэд хязгаарлагдмал хэдий ч үүнийг хайхрахгүй орхиж болохгүй бөгөөд хөтөлбөр, төслүүд өөрсдийн техник хангамжийн нөөцөө дайчлан, эсвэл интернет кафений үйлчилгээг ашиглан хүүхдүүдийг интернет ашиглахад сургаж болно.

Интернет нь хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд, хүүхдийн төлөө зүтгэлтнүүд ба компанит ажил зохион байгуулагчдын хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд сайн үр дүнтэй байдаг.

VIII БҮЛЭГ

НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ НЬ

БҮЛГИЙН ТОВЧ АГУУЛГА

- 8.1. Үнэлгээ: Бидний төлөвлөгөө хэрэгжиж буйг хэрхэн мэдэх вэ?
- 8.2. Богино хугацаанд ямар өөрчлөлт гарсан бэ?
- 8.3. Урт хугацаанд юу өөрчлөгдсөн бэ?
- 8.4. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

8.1 Үнэлгээ: Бидний төлөвлөгөө хэрэгжиж буйг хэрхэн мэдэх вэ?

Нөлөөллийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад нөхцөл байдал өөрчлөгдөх явдал гарахаас гадна хүчин чармайлтын үр дүн, ашгийг үнэлж дүгнэж байх хэрэгтэй. Үнэлгээг мөн өөр зорилгоор ашиглаж болно. Энэ нь байгууллагын аливаа шинэчлэл, танин мэдэхүйн сургалтын чухал үйл явцын нэг хэсэг болно. Мөн ололт амжилтыг тодорхойлоход тусална. Бүлэг өөрийн үйл явцаа үнэлэхэд туслах үүднээс бид дараах асуултыг боловсрууллаа.

1. Богино хугацаанд ямар өөрчлөлт гарав?
2. Урт удаан хугацаанд юу өөрчлөгдсөн бэ? гэсэн хоёр үндсэн асуулт багтана.

Нөлөөллийн ажлын үр дүн ба үр нөлөөг тооцох нь

Ажлын хэмжүүр	Өсөлтийн шалгуур үзүүлэлт – сайн ба муу	Өөрчлөлт ба урт хугацааны үр нөлөөний шалгуур үзүүлэлт
➤ Бодлогын өөрчлөлт ➤ Хууль эрх зүйн өөрчлөлт ➤ Хуулийн өөрчлөлт ➤ Хамтран ажиллах зан байдлын өөрчлөлт	➤ Асуудлын талаар харилцан ярилцлага нэмэгдэх ➤ Үзэл бодол өөрчлөгдөх ➤ Олон нийтийн болон хувь хүний харилцааны үр чадвар өөрчлөгдөх ➤ Бичиж хэвлүүлсэн материал, ном товхимолын өөрчлөлт ➤ Голлох боловсон хүчний өөрчлөлт ➤ Корпорацууд хөрөнгө сан бүрдүүлэх санал болгох	➤ Бодлого өөрчлөгдсөн. ➤ Хууль өөрчлөгдсөн. ➤ Бодлого хуулийн хэрэгжилтэнд өөрчлөлт гарсан. ➤ Бодлогын хэрэгжилтийг хариуцсан өндөр чадвартай боловсон хүчин ➤ Бодлого хуулийн өөрчлөлтийн үр дүнд хүмүүсийн амьдралд өөрчлөлт гарах
Дараах байгууллагуудтай хамтран ажилласнаар нөлөөлөл явуулах чадавхи дээшлэх ➤ ТББ ➤ Хөдөлгөөн/эвсэл ➤ Үйлдвэрчний эвлэл ➤ Олон нийтэд түшиглэсэн байгууллагууд ➤ Нэр хүнд бүхий байгууллагууд ➤ Түнш байгууллагууд ➤ Сэтгүүлчид ➤ Эрдэм шинжилгээний байгууллага ➤ Хуульчид	➤ Гишүүн хувь хүний мэдлэг, чадавхи, үр чадвар, үр ашгийн өөрчлөлт ➤ Иргэний бүлгүүдийн мэдлэг, чадавхи, үр чадвар, үр ашгийн өөрчлөлт ➤ Сүлжээний хүрээнд нэгдмэл томоохон зорилт тавих, үйл ажиллагаа зохион байгуулах ➤ Эсвэл эвсэл, сүлжээ тарж бутрах ➤ Иргэний нийгмийн байгууллага, бүлгийн эв нэгдэл, итгэлцэл, хамтын ажиллагааны хүрээнд гарах өөрчлөлт ➤ Илэрхийлэх ихээхэн эрх чөлөөтэй байх ➤ Иргэний нийгмийн бүлгүүдийн ихээхэн дэмжлэг хүлээх, ➤ Иргэний нийгмийн бүлгүүд дотооддоо асуудал өргөн хүрээнд шийдэх ➤ Иргэний нийгмийн бүлгүүдийн хууль нэмэгдэх ➤ Иргэний нийгмийн байгууллагуудын гишүүд нэмэгдэх	➤ Иргэний нийгмийн ажлын үр ашиг нэмэгдэх ➤ Иргэний нийгмийн бүлгүүд ядуу хүмүүст үр ашгаа өгөх өөрчлөлт гаргахын тулд шийдвэр гаргагчдад нөлөөлөх идэвхи ➤ Бодлого боловсруулах илүү уян хатан бүтэц тогтоох ➤ Шийдвэр гаргахад нөлөөлөх иргэний нийгмийн бүлгүүдийн оролцоо нэмэгдэх ➤ Олон нийтийн байгууллагуудын хариуцлагын тогтолцооны өөрчлөлт ➤ Иргэний нийгмийн бүлгүүдийн хариуцлагын тогтолцооны өөрчлөлт

Эх сурвалж : Costanza de Toma & Louisa Gosling, (2005), Advocacy Toolkit. 31x

8.2 Богино хугацаанд ямар өөрчлөлт гарсан бэ?

Энэ асуултыг хэр ойрхон, байнга асуух нь ихэвчлэн компани ажил буюу хүчин чармайлтын явцаар тодорхойлогдоно. Жишээ нь хэрвээ бүлэг сонгуулийн өмнө маш хүчтэй лоббидох компани ажил дээр ажиллаж байгаа бол энэ асуултыг магадгүй, цаг тутам, өдөр тутам, долоо хоног тутам өөрсдөөсөө асууж болно. Хэрвээ хэлэлцэж буй асуудлыг олон нийтэд нээлттэй болгох, танин мэдүүлэх үүднээс хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллаж байгаа бол үүнийг долоо хоног бүр юмуу, сар бүр өөрсдөөсөө асууж болно. Хэрвээ хүмүүсийг зохион байгуулан, дайчлан ажиллаж байгаа бол гурваас зургаан сар бүр энэ асуултыг өөрсдөөсөө асууж болох юм.

Дараах асуултыг хэзээ асуух ёстойг тунгаан бодно уу.

- ➔ Бидний зорилго, зорилт одоо хүртэл хэрэгжих боломжтой хэвээр байна уу?
- ➔ Бидний гол сонирхогч тал өөрчлөгдсөн үү? Хэн нэгний дэмжлэг болон эсэргүүцлийн түвшин өөрчлөгдсөн үү? Хэлэлцэж буй асуудалд чухал болж гарч ирсэн шинэ сонирхогч тал байна уу?
- ➔ Бүлэг хүчин чадавхиа хөгжүүлж чадсан уу? Урьд нь бидэнд саад болж байсан дотоод бэрхшээлтэй асуудлаа даван туулж чадсан уу?
- ➔ Бидний хүчин чадал буурсан уу? Жишээ нь чухал ажилтан маань биднийг орхиж явсан уу? Бид одоо хүртэл гишүүдийн идэвхитэй дэмжлэгийг хүлээж байна уу? Бидэнд хөрөнгө мөнгө хангалттай бий юу?
- ➔ Гадаад орчин өөрчлөгдсөн үү? Бидэнд шинэ боломж байна уу? Ямар нэг боломжийг алдсан уу? Бүлгийн багш нарт ямар нэгэн гэнэтийн бэлэг байгаа юу?
- ➔ Бидний эрсдлийн үнэлгээ нягт нямбай хийгдсэн үү? Бид ямар нэг зүйлийг анзааралгүй орхисон уу?
- ➔ Бидний тооцоолсон эрсдлүүд зорилгодоо хүрэхэд тусалсан уу? Эрсдлийг давж гарахаар байсан уу?
- ➔ Бидний үйл ажиллагаа үр дүнтэй байсан уу? Тийм бол яагаад үр дүнтэй болов? Үгүй бол яагаад?
- ➔ Бид юуг ёслон тэмдэглэж болох вэ?
- ➔ Дараагийн ямар алхмууд бий вэ?
- ➔ Бид юуг үргэлжлүүлэн хийх вэ?
- ➔ Бид өөр алхам хийх хэрэгтэй юу?
- ➔ Хэрэв тийм бол юуг бид өөрөөр хийх ёстой вэ?

8.3 Урт удаан хугацаанд юу өөрчлөгдсөн бэ?

Бүлэг мэдэгдэхүйц өөрчлөлтөнд хүрсэн үед цаашаа хэрхэн ажиллах, өмнөх арга хэмжээгээ төгсгөх талаар бодох шаардлагатай болно. Үүнд дараах асуулт тусална.

- ➔ Бид тавьсан зорилгодоо хүрсэн үү? Хэрвээ тийм бол аль зорилтод нь хүрсэн бэ?
- ➔ Урт ба богино хугацааны зорилт уу?
- ➔ Гадаад ба дотоод хүчин зүйлст чиглэсэн зорилт уу?
- ➔ Янз бүрийн түвшинд чиглэсэн зорилт уу?
- ➔ Урьдчилан таамаглаагүй байсан гэнэтийн ямар нэг зүйлийг бид хийсэн үү?
- ➔ Бидний үйл ажиллагааны юу нь үр дүнтэй байсан бэ? Яаж үр дүнд хүрэв? Тийм бол яагаад? Үгүй бол яагаад?
- ➔ Бид ганцаараа буюу салангид нөлөөлөгчтэй харьцуулахад хүчтэй юу? Бидэнд өөртөө итгэх итгэл, шинэ ур чадвар, шинэ мэдлэг илүү байна уу?
- ➔ Бүлэг эсвэл байгууллага болохын хувьд бид илүү хүчтэй байна уу? Бид шинээр харилцаа холбоо тогтоосон уу? Бид арга хэмжээндээ олон хүмүүсийг татан оролцуулсан уу? Бид удирдагч, манлайлагчийг шинээр төрөн гарахыг дэмжиж байсан уу?
- ➔ Бид иргэний нийгэм буюу хэлэлцэж буй асуудлын салбарт хүчтэй юу?
- ➔ Бид хэлэлцэж буй асуудлын талаарх олон нийтийн ойлголт, ухамсрыг нэмэгдүүлэхэд тусалж чадсан уу?
- ➔ Шийдвэр гаргах үйл явцад хүмүүсийн оролцоог хангахад бид тусалж чадсан уу? Энэхүү үйл явцад олон нийтийн оролцоог хуульчлах тал дээр бид тусалсан уу?
- ➔ Бид юу сурсан бэ?
- ➔ Бид юуг ёслон тэмдэглэж болох вэ?
- ➔ Ямар алхмууд хийгдэх вэ?
- ➔ Бид юуг үргэлжлүүлэн хийх вэ?
- ➔ Бид өөр алхам хийх хэрэгтэй юу?
- ➔ Хэрвээ тийм бол бид юуг өөрөөр хийх вэ?

Нөлөөллийн ажлаа үнэлэх үнэлгээгээр:

- ➔ нөлөөллийн үйл ажиллагаа нь орон нутаг, хүмүүсийн хэрэгцээтэй хэрхэн нийцэж байгаа,
- ➔ тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлснээр хүрсэн үр дүн, хамарсан цар хүрээ,
- ➔ үйл ажиллагааны цаашид үргэлжлэх тогтвортой байдал,
- ➔ Нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлснээр зорилтот бүлэгт бий болсон үр нөлөө,
- ➔ үйл ажиллагаанаас ямар сургамж туршлага олж авсан,
- ➔ үйл ажиллагааны уялдаа холбоо зэргийг үнэлж тодорхойлно.

Үнэлгээ хийхэд төрөл бүрийн мэдээлэл цуглуулна. Мэдээлэл цуглуулах аргууд:

- ➔ Тоон болон чанарын судалгаа хийх
- ➔ Нөлөөллийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцах
- ➔ Үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланд дүн шинжилгээ хийх
- ➔ Ганцаарчилсан ярилцлага болон бүлгээс ярилцлага авах
- ➔ Ажиглалт
- ➔ Цуглаан, уулзалт зохион байгуулах,
- ➔ Туршлага судлан харьцуулах гэх мэт.

8.4 Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Үйл явцын шалгуур.

Үйл явцад чиглэсэн зорилт нь нөлөөллийн үйл ажиллагаа хэр явагдсан талаарх мэдээллээр тодорхойлогддог.

Үйл явцын шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход ашиглах асуултууд:

- Нөлөөллийн ажил саадгүй явагдсан уу?
- Хангалттай тооны ажилтнууд байсан уу?
- Хөрөнгө санхүүжилтийн эх үүсвэр хангалттай байсан уу?
- Харилцаа холбоо сайн байсан уу?
- Олон нийтийн дэмжлэгийг хүлээсэн үү?
- Манлайлал нь зохих хэмжээнд байж чадсан уу?
- Бүлгийн үйл явцад гишүүд сэтгэл хангалуун байсан уу?
- Хямралын үед юу тохиолдсон бэ?

Үр дүнгийн шалгуур

Үр дүнд чиглэгдсэн зорилт нь нөлөөллийн хөтөлбөрийн хүрсэн ололт буюу үр дүнгийн тухай мэдээллээр тодорхойлогдоно.

Эдгээр нь ихэвчлэн тодорхой, тоолж болохуйц шалгуур байдаг. Жишээ нь:

- Үйлчилгээний хэлбэр буюу давтамж. Хичнээн уулзалт явагдсан бэ? Хичнээн анги төлөөлсөн бэ? Одоо ямар шинэ үйлчилгээ хүртээмжтэй болсон бэ?
- Олон нийтийн буюу бүлгийн үйл ажиллагаа. Хичнээн чуулга уулзалт зохиосон бэ? Хичнээн хүн оролцсон бэ? Гол манлайлагчидтай хэдэн удаа уулзсан бэ?
- Хөтөлбөр дэх өөрчлөлт. Хотын захиргаанд бодлогын өөрчлөлт хийгдсэн үү? Хууль тогтоох байгууллагад хийгдсэн үү? Шинэ үйлчилгээг эхлүүлсэн үү? Ямар нэгэн жижиг амжилтанд хүрсэн үү?
- Үйлчилгээний хүртээмж. Илүү олон үйлчүүлэгчид үйлчүүлж байна уу? Ямар саад бэрхшээл байна вэ?
- Хэрэгжсэн зорилтуудын тоо. Хөтөлбөрийн хэрэгжсэн зорилтуудыг эргэн харж ямар дэвшил гарсныг тэмдэглэ.

Үр нөлөөний шалгуур

Үр нөлөөнд чиглэгдсэн зорилт нь нөлөөллийн хөтөлбөрийн шууд үр дүн буюу тухайн үеийн өөрчлөлтөөр тодорхойлогдоно. Иймэрхүү үр дүнг хэрхэн хэмжих нь хөтөлбөр эхлэхийн өмнө цуглуулсан мэдээллийн баазаас хамаарна. Нөлөөллийн хөтөлбөрийн үйл ажиллагааны амжилтыг дараах байдлаар хэмжиж болно. Үүнд:

- Зан төлөвийн үзүүлэлт Хүмүүсийн биеэ авч явах байдал өөрчлөгдсөн үү? Зан төлөвийн тодорхой өөрчлөлт гарсан уу? Тухайлбал: Сургуулийн хүүхдүүд сургууль завсардах нь цөөрсөн үү?
- Олон нийтийн түвшний хэмжүүр үзүүлэлт. Танай хөтөлбөрийн үр дүнд олон нийтийн дунд тодорхой өөрчлөлт бий болсон уу? Статистикийн үзүүлэлт өссөн үү? Буурсан уу?

Үйл ажиллагааны үр дүнг тоон болон чанарын үзүүлэлтүүдийг ашиглан тодорхойлно.

Жишээ нь хэдэн хүүхэд хөдөлмөрөөс хөндийрсөн, хичнээн эцэг эхчүүдийг хамарсан сургалт зохион байгуулсан, хэдэн удаа радио нэвтрүүлэг хийсэн, хичнээн байгууллага хамтарч ажиллан хэдэн удаа уулзалт цуглаан зохион байгуулсан гэх мэт тоон мэдээлэл үйл ажиллагааны шууд үр дүнг илэрхийлнэ. Харин чанарын үзүүлэлтүүд нь хүмүүс асуудлыг юу гэж үзэх болсон, хүмүүсийн хандлага оролцоо хэрхэн өөрчлөгдсөн, гэр бүл, хүүхдүүд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд хэр зэрэг сэтгэл ханамжтай байгаа зэргээр тодорхойлогдоно.

Мэдээллийн сан:

Төлөвлөж буй үнэлгээ хийх үйл ажиллагаатай нягт уялдаатай мэдээллийн санг бий болгох нь нөлөөллийн хөтөлбөрт чухал байдаг. Мэдээллийн сан бий болгоход тустай аргачлал болон эх үүсвэрийг дор нэгтгэсэн бөгөөд эдгээрээс үнэлгээг боловсруулахад ашиглаж болно.

- ➔ Уулзалтын тэмдэглэл, товчлол
- ➔ Ажлын цаг, үйлчүүлэгчдийн уулзалт зэрэг тусгай үйл ажиллагааны талаарх мэдээллийг агуулсан баримтын хүснэгт (долоо хоногийн, сарын, жилийн баримт байж болно)
- ➔ Хэрэглэгчид болон ажилтны үнэлгээний дүн
- ➔ Байгууллагын, зорилго болон зорилтын тунхаглал
- ➔ Сонины хайчилбар, шинэ мэдээ болон радио, телевизын бичлэг (минутаар)
- ➔ Хэлэлцээр, мөнгөн биш хандив, үйлчилгээ, бэлэг эсвэл хүлээн авсан хандив.
- ➔ Тусгай үйл явдал буюу үйл ажиллагааны үеэр чухал хүмүүсийн өгсөн ярилцлага
- ➔ Байгууллагын сэдэвт холбогдох гэхдээ бусад байгууллагаас авсан баримт мэдээ
- ➔ Байгууллагын ажилтны эсвэл бусад олон нийтийн байгууллага, холбоодын явуулсан судалгаа зэрэг мэдээллийн санг бүрдүүлнэ.

НЭР ТОМЬЁО, ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

Энэ гарын авлагад нэр томьёо, товчилсон үгийг дараах утгаар ашигласан болно.

138-р конвенци	Ажил хийх насны доод хязгаарын тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын конвенци (1973)
182-р конвенци	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах тухай ОУХБ-ын конвенци (1999)
190-р зөвлөмж	ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах тухай 182-р конвенцийн (1999 он) хэрэгжилтийг хангах чиглэл заавар
Зорилго	Хөтөлбөр төслийн болон төлөвлөгөөт үйл ажиллагаа зорьсондоо хүрэх эцсийн байдал
Зорилт	Ерөнхий зорилгод хүрэх тодорхой зорилгууд
Мэдээлэгдсэн зөвшөөрөл	Хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааны зорилго, явц, үр нөлөө, үр дүнгийн талаарх мэдээллийг авсны үндсэн дээр оролцох зөвшөөрөл өгөх
Нөлөөллийн үйл ажиллагаа	Хууль өөрчлөх, хуулийн хэрэгжилтийг хангах талаар бодлого боловсруулагчдад нөлөөлөх, хүмүүсийн зан үйл хандлагыг өөрчлөх зорилго бүхий үйл явц
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
Олон Улсын Хөдөлмөрлөх Эрхийн Сан	Дэлхий даяар ажилчдад шударга ханддаг болгохын төлөөх нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага
Ойлголт мэдлэг дээшлүүлэх үйл ажиллагаа	Асуудлыг олон нийтийн анхааралд хүргэхэд чиглэсэн үйл ажиллагаа
Оролцоо	Үйл ажиллагаа, хөтөлбөр төслийн төлөвлөлт, хэрэгжилт, шийдвэр гаргах явцад оролцох оролцоо
Стратеги	Тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэх төлөвлөгөө
ТББ	Төрийн бус байгууллага. Улсын байгууллага бус иргэний нийгмийн хүрээнд ажилладаг байгууллага.
Төлөвлөгөө	Тодорхой нөөц, хугацааны хүрээнд хүрэх зорилго, стратегийг тодорхойлох, зохион байгуулалттай явц

Үнэлгээ дүгнэлт	Урьдчилан тодорхойлсон шалгуурт нийцүүлэн ололт ахицаа системтэйгээр үнэлэх явц
Үе тэнгийнхэн	Ижил насны, байр суурь, нийтлэг чанартай хүмүүс (хүүхэд)
Хүүхэд	18-аас доош насны хүн
Хүүхдээс- хүүхдэд	Хүүхэд-Хүүхдэдээ байгууллага эсвэл үе тэнгийнхний сургалтын тухай үзэл хандлага
Хүүхэд- төвтэй	Гэр бүл, олон нийт, нийгмийн орчинд хүүхдүүдийн ашиг сонирхол, үзэл бодлыг харгалзах
Хөтөлбөр төсөл	Хүүхдийн оролцоог хангах үйл явц бүхий төлөвлөгөөт үйл ажиллагаа
Хүн дамжуулан худалдаалах	Хүчирхийлэл, айлган сүрдүүлэх, хууран мэхлэх хэлбэрээр болон өрийн төлбөр болгож хүмүүсийн хөдөлмөрийг мөлжиж ажиллуулахаар элсүүлэх, зөөх
Ханын сонин	Олон нийтийн газарт хананд тогтооход зориулсан зурагт хуудсаар мэдээ, санаа бодлыг түгээх хэрэгсэл
Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд	ОУХБ-ын 1999 оны 182-р Конвенцийн 3-р зүйлд зааснаар устгах шаардлагатай гэж тодорхойлогдсон хүүхдийн хөдөлмөрийн хэлбэрүүд (ОУХБ-ын 182-р Конвенцийг үзнэ үү)
ХТҮГ	Хүүхдийн төлөө үндэсний газар
Чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа	Сургалтад оролцогч хүмүүсийн эзэмшсэн мэдлэг, чадвар, туршлагад тулгуурлан сургах гэсэн үзэл баримтлал бүхий сургалтын үйл ажиллагаа
ЭКПАТ	Анхны товчлол нь Азийн жуулчлал дахь Хүүхэд биеэ үнэлэх явдлыг устгах гэсэн утгатай. Одоо ЭКПАТ олон улсын сүлжээ болж хүүхдийн биеийг үнэлүүлэх, бэлгийн мөлжлөгт өртөх, хүүхдийг сексийн зорилгоор хил дамжуулан худалдаалах явдлыг устгах дэлхий нийтийн сүлжээ болжээ.

Ашигласан ном, материалууд

- АЙПЕК. Сайн туршлага ба сургамж: Монгол дахь хүүхдийн хөдөлмөрийг устгах ба урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр II үе шат. Улаанбаатар хот, 2006 он.
- АЙПЕК. Хөдөө аж ахуй дахь хүүхдийн хөдөлмөрт анхаарал хандуулъя. 2007 оны 6 сарын 12.
- БСШУЯ, ОУХБ. Хүүхэд насыг хүнд хөдөлмөрт биш, хөгжилд зориулъя сэдвээр хичээл явуулах аргачлал. 2006 он. Улаанбаатар хот.
- ДОХ-той тэмцэх Үндэсний сан. Ухуулга сурталчилгаа хэрхэн хийх вэ? аргачлал. Улаанбаатар хот. 2004 он.
- ДОХ-той тэмцэх Үндэсний сан. Олон нийтийн сурталчилгаагаар хүний зан үйлийг өөрчлөх, ДОХ-оос сэргийлэхэд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглах нь
- НҮБ-ын Хүн Амын сан, ЭМЯ. Ухуулга сурталчилгаа (гарын авлага). Улаанбаатар, 2004.
- ОУХБ, Тэгш Мөр Төв. Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн талаарх ерөнхий ойлголт, тэдэнд чиглэсэн арга хэмжээнүүд (сургалтын материал). Улаанбаатар, 2003-2005 он
- ОУХБ. Хүүхдийн хөдөлмөрийг устгах: Хүрч болохуйц зорилт. 2006 он.
- ОУХБ. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад чиглэсэн нөлөөллийн стратеги 2007-2011. Улаанбаатар хот. 2007 он.
- Тэгш Мөр Төв, ЕСПАТ. Худалдааны зах дээр хөдөлмөр эрхэлдэг охидын судалгаа. Улаанбаатар, 2005 он.
- ҮСГ, ОУХБ. Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгааны тайлан 2002-2003. Улаанбаатар хот 2004 он.
- Худалдааны захууд дээр хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн нөхцөл байдал (Хүчитшонхор, Да хүрээ, Баянзүрх, Цайз зах). Улаанбаатар, 2005 он
- ЭМЯ, НҮБ-ын хүн амын сан. Ухуулга сурталчилгаа гарын авлага. Улаанбаатар хот. 2004 он.
- ADHOC, Pact Cambodia. Grassroots Advocacy Handbook.
- Black, 2002. A handbook for advocacy: Child domestic workers: Finding a voice. London: Anti-slavery International
- Child Workers in Asia, Task Force on Child Domestic Workers. Raising one voice. Bangkok. 2005.
- Communication strategy for the elimination of child labour and the promotion of education. 03.12.2004. Document Submitted to ILO by Thompson Social J Walter Thompson Delhi Office.
- Conceptual clarity on trafficking, core messages on CP-TING project is focus and approaches and advocacy strategy: working document for use in china As development during meeting in Guangzhou (8-10 september 04) organized by ACWF & ILO-through the CP-TING project.
- CARE International in Vietnam. Advocacy strategy for adolescent sexual and reproductive health: For Rhiya Program In Vietnam 2005-2006.
- Cohen. D., de la Vega, R. Watson, G. (2001). Advocacy for social justice. Chapter 5. Strategy Development, 59-87. CT: Kumarian Press
- Child Workers in Asia: Task Force on Child Domestic Workers. Raising one voice: A training Manual for advocates on the rights of child domestic workers.
- Gordon, Graham. (2002) Advocacy toolkit: Understanding advocacy. UK: TearFund.
- Gordon, Graham. (2002) Advocacy toolkit: practical action in advocacy. UK: Tearfund.
- Gender and advocacy training manual.
- INDUS Child Labour Project. (2004). Communication strategy for the elimination of child labour and the promotion of education. Document submitted to ILO by Thompson Social, Delhi Office, New Delhi http://www.pitt.edu/~Super1lecture/lec_1835/005.htm. What is Advocacy Strategy?
- Regional Working Group on Child Labour (RWG-CL). (2001) Child Labour getting the message across. Bangkok Thailand.
- Schneider, R, E, and Lester, L. (2001). Social Work Advocacy, Chapter 4, Influence 115-148, CA: Brooks/Cole Thomson Learning.

